2025
он

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**

“МАХНЫ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ” судалгааны тайлан

ПАРЛАМЕНТЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт 3

Хүснэгтийн жагсаалт 4

Графикийн жагсаалт 4

Зургийн жагсаалт 4

Хавсралтын жагсаалт 4

Нэг. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ 5

1.1 Судалгааны үндэслэл, зорилго зорилт 5

1.2 Судалгааны аргачлал 7

Хоёр. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ 12

Гурав. 2024 ОНД ЭКСПОРТОД ГАРСАН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДҮН МЭДЭЭЛЭЛ 29

3.1 Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний экспорт 29

3.2 Махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний экспорт 31

Дөрөв. СУДАЛГААНЫ ҮР ДҮН 34

4.1 Махны үйлдвэр барьж, зөвшөөрөл авах үйл явц 34

4.2 Үйлдвэрийн хяналт шалгалт 37

4.3 Мах экспортлох зөвшөөрөл авах үйл явц 41

4.3.1 Квот болон Бодлогын гэрээ 42

4.3.2 Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ авах 48

4.3.3 Гаалийн улсын байцаагч хяналт шалгалт хийж, бүтээгдэхүүний дээж авах 52

4.3.4 Гарал үүслийн гэрчилгээ 56

4.3.5 Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ 57

4.3.6 Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд өгч, дүгнэлт гаргуулах 60

4.3.7 Тохирлын гэрчилгээ 63

4.3.8 Гаалийн бүрдүүлэлт хийх 64

4.3.9 Тээвэрлэлт 65

4.3.10 Хил дээр гаальд бүртгүүлэх, гадна үзлэг хийлгэх 66

4.4 Мах экспортлогч аж ахуй нэгжийн зүгээс ирсэн санал 66

Тав. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ 69

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ 76

Эх сурвалжийн жагсаалт 80

Хавсралт 82

СУДАЛГААНЫ БАГ

П.Түмэнцэцэг, хэлтсийн дарга

Г.Ган-Эрдэнэ, судлаач

М.Нямжаргал, судлаач

Б.Намнамбаяр, судлаач

Судалгаа гүйцэтгэсэн хугацаа: 2025.3.15-2025.4.25

Товчилсон үгийн жагсаалт

МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МУИС	Монгол Улсын Их сургууль
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ОХУ	Оросын Холбооны улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ЭСЯ	Элчин сайдын яам
ААН	Аж ахуйн нэгж
УМЭАЦТЛ	Улсын Мал Эмнэлгийн Ариун Цэврийн Төв лаборатори

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн (улсаар) *30*
Хүснэгт 2. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн (аж ахуй нэгжээр) *30*
Хүснэгт 3. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний эзлэх жин *31*
Хүснэгт 4. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн (малын төрлөөр) *31*
Хүснэгт 5. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн (улсаар) *31*
Хүснэгт 6. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн (аж ахуй нэгжээр) *32*
Хүснэгт 7. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний эзлэх жин *32*
Хүснэгт 8. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүн (малын төрлөөр) *33*
Хүснэгт 9. Мах, махан бүтээгдэхүүний экспорттой холбоотой хууль тогтоомжийн давхардал *69*
Хүснэгт 10. Мах, махан бүтээгдэхүүний экспорттой холбоотой хууль тогтоомжийн зөрчил *73*

Графикийн жагсаалт

Гарфик 1. 2024 онд экспортод гарсан мах, махан бүтээгдэхүүний эзлэх жин *29*

Зургийн жагсаалт

Зураг 1. Мах экспортлох зөвшөөрөл авах үйл явц *41*

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Мах, махан бүтээгдэхүүний экспорттой холбоотой харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн актын жагсаалт *82*

Нэг. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

1.1 Судалгааны үндэслэл, зорилго зорилт

Үндэсний статистикийн хорооноос жил бүр гаргадаг Монгол Улсын статистикийн эмхэтгэлээс харвал, Малын тоо 2023 онд 64.7 сая толгойд хүрч, адуу 4.8 сая, үхэр 5.4 сая, тэмээ 473.9 мянга, хонь 29.4 сая, ямаа 24.6 сая толгой болсон. Малын тоо өмнөх оноос 6.4 сая буюу 9.1 хувиар буурчээ.

Малын махны экспортын гүйцэтгэл 2023 оны байдлаар 80.4 мян.тн байгаа нь 2020 онтой харьцуулахад 2 дахин, өмнөх онтой харьцуулахад 5 дахин өссөн үзүүлэлт юм. 80.4 мян.тн-ыг хонин толгойд шилжүүлэн үзвэл 6.4 сая.тол гарч байна.

Малын тоо толгой болон экспортод гаргасан махны хэмжээг харьцуулж харвал, Монгол Улсын хувьд экспортод гаргах махны нөөц хангалттай байгаа юм.

МҮХАҮТ, МУИС-ийн Бизнесийн сургуулиас 2017 онд хийсэн “Монголын бизнесийн орчны судалгаа, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар 2020 онд хийгдсэн “Экспортын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд тохиолдож буй саад бэрхшээлүүд” судалгаа, 2024 онд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166-р тогтоолыг төлөвлөлтийг үнэлэх, үр нөлөөг дээшлүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх” зөвлөх үйлчилгээ зэрэг өмнө нь хийгдсэн судалгаануудаас харахад, Монгол Улсад бизнес эрхлэхэд тохиолддог хамгийн гол бэрхшээл буюу саад тотгор нь засаглал, хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудлууд байдаг бөгөөд гадаад орны экспортоор авах малын мах, махан бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, хууль эрх зүйн орчны нөхцөлтэй тохирдоггүй асуудал байдаг аж.

Тиймээс, малын мах, махан бүтээгдэхүүнийг экспортод гаргахад хууль, эрх зүйн хувьд тулгардаг асуудлуудыг тодруулж, холбогдох хууль, тогтоомжуудыг судлан, санал зөвлөмж хүргүүлэх шаардлага байна.

Зорилго, зорилт

Монгол Улсын мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд тулгардаг хууль, эрх зүйн асуудлуудыг тодруулж, төрийн зүгээс бизнесийн орчныг сайжруулахад бодитой дэмжлэг үзүүлэх баримт нотолгоонд суурилсан санал, зөвлөмж боловсруулна. Энэ хүрээнд:

- Сэдвийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлуудтай танилцаж, дүн шинжилгээ хийнэ;

- Малын мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн, дотоод болон гадаад худалдаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн төлөөлөлтэй уулзаж, эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг илрүүлэх процессын зураглал хийнэ;
- Мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагааг зохицуулдаг дотоодын хууль тогтоомж, журмуудыг судалж, тэдгээрийн давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлнэ;
- Процессын зураглал болон хууль, эрх зүйн орчны судалгааг уялдуулан холбож, санал, зөвлөмж боловсруулна.

Судлах зүйл: Малын мах, махан бүтээгдэхүүн экспортод гаргахад хууль, эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудал

Судалгааны объект

- Гүйцэтгэх чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага
- Малын мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн, дотоод болон гадаад худалдаа эрхэлдэг аж ахуй нэгж
- Мах, махан бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорттой холбогдох хууль тогтоомж

Үндсэн ойлголтын тайлбар

Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгж нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, мал төхөөрөх, мах боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг холбогдох стандарт, техникийн зохицуулалтын дагуу гүйцэтгэдэг хуулийн этгээд. Эдгээр аж ахуйн нэгжүүд нь экспортын эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай зөвшөөрөл, гэрчилгээг авсан бөгөөд экспортын үйл ажиллагаанд оролцохын тулд импортлогч орны хорио цээрийн болон эрүүл ахуйн шаардлагыг хангасан байгууллага.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) нь мах, махан бүтээгдэхүүний экспортын бодлого боловсруулж, экспортын үйл ажиллагааг зохицуулж, зах зээлийг тэлэх чиглэлээр ажилладаг төрийн захиргааны төв байгууллага юм. Тус яам нь экспортын гэрчилгээ, холбогдох протокол, хууль, журам батлан хэрэгжүүлж, гадаад зах зээлд мах нийлүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын тогтолцоог зохицуулах үүрэг бүхий төрийн байгууллага юм. Мах экспортлох үйл ажиллагаанд гарал үүсэл, ариун цэврийн гэрчилгээ олгох, мал эмнэлгийн цахим системд бүртгэл хийх замаар хяналт тавьдаг.

Гаалийн ерөнхий газар нь Монгол Улсын хилээр нэвтрэх бараа, бүтээгдэхүүнд хяналт тавих, гаалийн татвар, хураамжийг ногдуулах, хууль бус бараа эргэлтээс сэргийлэх үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага юм. Мах, махан бүтээгдэхүүн экспортлох үед ГЕГ нь гарал үүсэл, мал эмнэлгийн гэрчилгээ зэрэг шаардлагатай бичиг баримтыг шалгаж, гаалийн бүрдүүлэлт хийж, экспортын үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлдэг.

Хөдөө аж ахуйн бирж нь мал, мах, ноос, ноолуур зэрэг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нээлттэй, ил тод арилжаалах зорилготой хөрөнгө, үнийн мэдээлэл, гэрээний суурь талбар болдог байгууллага юм.

Мах экспортлох үйл ажиллагаанд энэ бирж нь үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэр, экспортлогч болон худалдан авагчдыг холбож, махыг зах зээлийн үнээр арилжаалах нөхцөлийг бүрдүүлж өгдөг чухал дэд бүтэцтэй байгууллага юм.

1.2 Судалгааны аргачлал

Малын мах, махан бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорттой холбогдох хууль тогтоомжийн жагсаалтыг гаргаж, мах, махан бүтээгдэхүүн экспортлохтой холбоотой тулгамдсан асуудлыг шинжлэх тул чанарын дескриптив судалгаа болно.

1) Малын мах, махан бүтээгдэхүүний экспортыг зохицуулж буй хууль тогтоомжийн харилцан уялдаа ямар байна вэ?,
2) Гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллага малын мах, махан бүтээгдэхүүний экспортыг зохицуулж буй хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэл байна уу?,
3) Малын мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдэд хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл учирч байгаа юу? гэсэн гурван асуултыг дэвшүүлж, мэдээллүүдээ баримт бичгийн анхдагч, ганцаарчилсан ярилцлагын хоёрдогч аргаар цуглуулав.

❖ Ганцаарчилсан ярилцлагын аргачлал

Ганцаарчилсан ярилцлага (in-depth interview) нь оролцогчдын гүн гүнзгий туршлага, хандлага, ойлголтыг тодорхойлох, контекстэд суурилсан чанарын мэдээлэл цуглуулахад тохиромжтой арга юм (Patton, 2002). Чанарын судалгаанд өргөн ашиглагддаг энэ аргаар оролцогч үзэл бодлоо нээлттэй илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлдэг (Kvale, S., & Brinkmann, S., 2009).

Түүвэрлэлтийн арга

Зорилтот түүвэрлэлтийн арга (purposive sampling) ашигласан бөгөөд энэ нь тухайн судалгааны сэдэвт хамааралтай, мэдээлэл өгөх чадамжтай хүмүүсийг сонгоход чиглэдэг (Palinkas, L. A., Horwitz, S. M., Green, C. A., Wisdom, J. P., Duan, N., & Hoagwood, K., 2015).

1. Ганцаарчилсан ярилцлагын аргаар мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжийн төлөөлөл, гүйцэтгэх чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага болох ХХААХҮЯ, Мал Эмнэлгийн Ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газар, ХААБ-ийн албан хаагчаас судалгаа авсан.
2. Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч 58 аж ахуй нэгжээс төлөөлөл болгож 9-ийг дараах шалгууруар сонгосон.
    - Мах экспортлох зөвшөөрөл авсан жил:
        - 2015 оноос өмнө – 3,
        - 2016-2020 он – 4,
        - 2021 оноос хойш - 2
    - Экспортолдог махны хэмжээ (2024.01.01-2024.12.31-ний Гаалийн ерөнхий газрын “Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний экспортын мэдээ”-ээр 58 аж ахуй нэгж дунджаар 834,628 кг мах, махан бүтээгдэхүүн экспортод гаргасан.)
        - Дунджаас дээш хэмжээгээр мах, махан бүтээгдэхүүн экспортолсон аж ахуй нэгжийн төлөөлөл – 1
        - Дунджаас доош болон бага хэмжээгээр экспорт хийдэг – 8)
    - Мах экспортолсон улс (ОХУ, БНХАУ-ыг хөрш улс гэсэн шалгууруар, булангийн орон болон БНСУ, халаал мах авдаг Арабын улс)
    - Экспортод гаргадаг махны төрөл

Ярилцлагын бүтэц

Ярилцлагын хагас бүтцэт загвар (semi-structured interview) ашигласан. Энэхүү загвар нь урьдчилан бэлтгэсэн асуулттай ч, ярилцлагын явцад уян хатан байдлаар шинэ сэдвийг хөндөх боломжийг олгодог (Bryman, A., 2016).

Өгөгдөл цуглуулалт ба боловсруулалт

Ярилцлагуудыг биечилсэн байдлаар зохион байгуулж, аудио бичлэг хийн, бүрэн эхээр нь бичвэр болгон буулгасан. Дараа нь Матриц (matrix) ашиглан кодчилсон (Miles, M. B., Huberman, A. M., & Saldaña, J., 2014). Судалгааны үйл явцад рефлексив хандлагыг баримталсан.

Ёс зүйн хэм хэмжээ

Мах, махан бүтээгдэхүүний экспорт хийхэд хууль эрх зүйн хувьд тулгардаг бэрхшээлийг тодорхойлохыг зорьж байгаа тул оролцогчдод судалгааны зорилго, оролцох нөхцөл, хувийн нууцыг хэрхэн хамгаалах талаар тайлбарлаж, албан ёсны зөвшөөрөл (informed consent) авсан болно. Мөн ярилцлагад оролцогч аж ахуй нэгжийн төлөөлөл, гүйцэтгэгдэх чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчидтай нэрийг дурдалгүй өгөгдөл цуглуулах болно гэж зөвшилцөн судалгааг авсан.

❖ Хоёрдогч өгөгдлийн шинжилгээний арга

Гаалийн Ерөнхий газраас ирсэн 2024.01.01-2024.12.31-ний хугацаанд экпортод гарсан мах, махан бүтээгдэхүүний статистик дүнд шинжилгээ хийж, 2024 онд хэдэн байгууллага, ямар ямар улс руу, ямар мах, махан бүтээгдэхүүнийг хэдий хэмжээгээр гаргасан дүнг гаргаж, тайлбар дүгнэлт хийсэн.

❖ Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал

Энэхүү аргачлалын зорилго нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид байгаа давхардал, зөрчил, хийдлийг тогтоох замаар тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулахад оршино.

Энэхүү аргачлал дахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

- **хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах** гэж хууль тогтоомжийг харьцуулан судлах замаар тэдгээрийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоон арилгах цогц үйл ажиллагааг;

- **давхардал** гэж хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэл зүйн хувьд хуулбарласан, эсхүл тэдгээрийн зохицуулалтын агуулга, зорилго нь ижил байхыг;
- **зөрчил** гэж нэг этгээдийн зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, Үндсэн хууль болон хууль тогтоомжийн эрэмбэлэлийн аргын дагуу хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томъёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг;
- **хийдэл** гэж тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг.

Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх үндсэн арга: Хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулахдаа дараах үндсэн аргыг хэрэглэнэ:

2. анализ-синтезийн арга
3. ярилцлагын арга;
4. харьцуулалтын арга:
   a. бичвэрийн харьцуулалтын арга;
   b. агуулгын харьцуулалтын арга.

Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийхдээ хууль тогтоомжийн бичвэр болон агуулгыг харьцуулах бөгөөд хууль тогтоомж давхардсан, зөрчилдсөн гэж үзвэл түүнийг хууль тогтоомжийн эрэмбэлэх аргын дагуу хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд хууль, эрх зүйн бусад актыг нийцүүлэх замаар ажиллана.

Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх үе шат: Уялдаа холбоог сайжруулах ажлыг дараах үе шатаар хийнэ:

1. бэлтгэл үе шат;
2. хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шат;
3. хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг системчлэх;

4. хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах замаар тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах санал боловсруулах

Бэлтгэл үе шат нь дараах хэсгээс бүрдэнэ: Бэлтгэл үе шатанд сонгож авсан хуультай холбоотой Хүснэгт 1-ээр харуулсан эрх зүйн актыг цуглуулсан.

Цуглуулсан хууль, хуульчилсан актаасаа хүчинтэй үйлчилж байгааг нь ялгах; /Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актын хүчин төгөлдөр эсэхийг тогтоохдоо Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн эсэхийг удирдлага болгосон/.

Цуглуулсан хууль, хуульчилсан актаа уншиж танилцаад эдгээрээс тухайн хуультай шууд холбогдох хууль, хуульчилсан актыг ялгаж авах;

Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох: Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шатанд тухайн хуультай шууд холбогдох хууль, хуульчилсан акттай сонгож авсан хуулийн заалт бүрийг харьцуулж хүснэгтэлнэ.

Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг системчлэх үе шат: Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоосны дараа тэдгээрийг системчлэн.

Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг хууль тус бүрээр системчлэх бөгөөд хууль тогтоомжийн тодорхой зүйл, хэсэг, заалт бичвэрийн хувьд болон агуулгын хувьд давхардсан, зөрчилдсөн бол эрэмбэлэхдээ дээд хүчин чадалтай, эсхүл суурь харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид бусад хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэл баримтална.

Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах замаар тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах санал боловсруулах /хуулийн төсөл/ үе шат: Захиалагч нь тайлангийн саналд үндэслэн хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулна.

Хоёр. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Махны экспорттой холбоотой дараах судалгаанууд нь Монгол Улсын махны салбарын нийлүүлэлт, экспортын өртгийн сүлжээ, зорилтот зах зээл, бүтээгдэхүүний чанар, хууль эрх зүйн орчин, логистик болон цахим экспортын систем зэрэг олон талт асуудлыг хамарсан судалгаанууд юм. Харин энэхүү судалгаа нь өмнөх судалгаануудаас ялгаатай нь мэдээлэл болон процессын давхардлыг бууруулах, экспортын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн институт хоорондын уялдаа, бодлого, зохицуулалтын түвшний дүн шинжилгээг цогц байдлаар хийснээрээ онцлогтой.

1. Махны нийлүүлэлтийн тогтолцоо (2022)

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын махны салбар дахь нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, шат дамжлагыг оновчтой болгох, тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлон, тэдгээрт шийдэл санал болгоход чиглэсэн болно. Судалгаанд малын төрөл, бэлчээрийн хүчин чадал, махны чанар, нийлүүлэлтийн бодит тоон үзүүлэлтүүд, дотоодын зах зээлийн онцлог, экспортын чиг хандлагуудыг хамарсан өргөн хүрээний өгөгдөл, бодлого, бүтэц, тогтолцооны үнэлгээ багтжээ.

Монголын мал аж ахуйн салбар нь ихэнхдээ уламжлалт, бэлчээрийн маллагаанд суурилсан бөгөөд махны нийлүүлэлтийн тогтолцоо нь төвлөрсөн зохион байгуулалтгүй, зах зээлийн өрсөлдөөнд суурилсан хэлбэртэй явагдаж байна. Үйлдвэрлэгч, хэрэглэгч хоёрын хооронд олон шат дамжлагатай, завсрын наймаачид давамгайлсан бүтэц нь махны чанар, аюулгүй байдал, үнийн тогтворгүй байдалд сөргөөр нөлөөлж байгааг онцлон тэмдэглэжээ.

Судалгаагаар тогтоогдсончлон, сүүлийн 5 жилийн дунджаар бэлтгэсэн нийт махны 5%-иас бага хувийг л бүрэн хүчин чадал бүхий мах боловсруулах үйлдвэрүүд бэлтгэж байгаа нь дотоодын боловсруулах чадавхийн сул талыг илэрхийлж байна. Энэ нь олон улсын экспортын стандартын шаардлагыг хангаж чадахгүй байдалтай шууд хамааралтай юм.

Нийлүүлэлтийн сүлжээнд:

- Малчид: анхан шатны оролцогчид боловч гарал үүсэл, малын эрүүл мэндийн мэдээллийн дутмаг байдал, санхүүгийн хүртээмжийн асуудалтай.

- Завсрын худалдаачид: ариун цэврийн шаардлага хангаагүй хадгалалт, тээвэрлэлт гүйцэтгэж, эцсийн хэрэглэгчид эрсдэл бүхий мах нийлүүлдэг.
- Үйлдвэрүүд: стандартгүй жижиг цех давамгайлж, хүйтэн сүлжээ хөгжөөгүй, бүтээгдэхүүний төрөл цөөн, технологийн хоцрогдол ихтэй байна.
- Тээвэрлэлтийн хувьд: сүлжээний зохион байгуулалт муу, хөргөлттэй тээврийн хүрэлцээ бага, стандарттай агуулах хомс байгаагаас үр ашгийг бууруулж байна.

Мөн махны зах зээлд мэдээллийн ил тод байдал сул, бодит статистик, нийлүүлэлтийн урьдчилсан төлөвлөлт дутмаг, махны үнэ тогтворгүй байх зэрэг асуудал тогтмол ажиглагдаж байна.

Судалгаанд үндэслэн дараах шийдлүүдийг дэвшүүлжээ:

- Биржийн зохион байгуулалтыг сайжруулж, мал, махны нийлүүлэлтийг ил тод болгох.
- Малын гарал үүслийн баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх.
- Малчдын хоршоог дэмжих замаар шууд нийлүүлэлтийг дэмжих.
- Нийлүүлэлтийн сүлжээг шат дамжлага багатай, эрүүл ахуйн шаардлага хангасан байдлаар бүрдүүлэх.
- Экспортын чадамжтай үйлдвэрүүдийг оновчтой бүсчлэлтэй хөгжүүлэх.
- Бодлогын уялдаа холбоог хангаж, салбар хоорондын зохицуулалтыг нэг мөр болгох.

Тайлангийн гол дүгнэлт нь махны нийлүүлэлтийн одоогийн тогтолцоо нь тэнцвэргүй, олон асуудал дагуулсан хэлбэрээр явагдаж байгаа тул бодлогын реформ, бүтэц, процессын шинэчлэл хийх шаардлагатайг тодотгож байна (Хөдөө аж ахуйн бирж, 2022).

2. Монгол дахь махны экспортын өртгийн сүлжээний судалгаа (2021)

Далайд гарцгүй түүхий эдийн хамааралтай хөгжиж буй орнуудыг бүс нутгийн болон дэлхийн худалдааны гинжин хэлхээнд нэгтгэх төсөл: Монгол улс

Энэхүү судалгаа нь Монгол Улсын махны экспортын өртгийн сүлжээний өнөөгийн нөхцөл байдал, оролцогч талуудын үүрэг, тулгамдаж буй бэрхшээл, хөгжлийн боломжуудыг цогцоор нь авч үзсэн бүтээл юм. Судалгааны гол зорилго нь

экспортын өртгийн сүлжээний гол түвшинд оролцогч талуудын байр суурь, гинжин хэлхээний шат дамжлагуудын уялдаа холбоо, төрийн бодлого, зах зээлийн механизмын оновчгүй байдлыг тодорхойлон гаргаж, сайжруулах боломж, зөвлөмжийг боловсруулахад чиглэжээ.

Судалгаа 168 малчин, 14 мах боловсруулах үйлдвэр (МБҮ), төрийн болон хувийн байгууллагын мэдээлэл, холбогдох статистикт тулгуурлан хийгдсэн. Арга зүй нь бизнесийн процессын анализ, чанарын ярилцлага, өгөгдөлд тулгуурласан хандлагад суурилжээ.

Махны гинжин хэлхээний ерөнхий бүтэц

Судалгаанд оролцогч талууд нь:

1. Малчид,
2. Дундын зуучлагчид,
3. Нядалгааны төвүүд,
4. Мах боловсруулах үйлдвэрүүд,
5. Тээврийн байгууллагууд гэх мэт шаталсан бүтэцтэй байгааг харуулсан.

Гэвч энэ сүлжээний уялдаа холбоо сул, төрийн бодлого, санхүүгийн дэмжлэг, дэд бүтэц, зах зээлийн холболт хангалтгүй байдал нь экспортын тасралтгүй байдлыг сааруулж байв.

Малчид ба бэлчээр

Малчид экспортын сүлжээний хамгийн эхний цэгт байрладаг ч тэдний хувьд хамгийн бага орлого, мэдээллийн дутмаг байдалтай байна. Малын ашиг шимийг нэмэгдүүлэх санхүүгийн эх үүсвэр, мал эмнэлгийн үйлчилгээ хангалтгүй, мал нядлах нас, эрүүл мэндийн үзүүлэлт олон улсын шаардлагад нийцэхгүй байгаа нь экспортын чанарт шууд сөрөг нөлөө үзүүлдэг. Бэлчээрийн доройтол улс орон даяар 57%-д хүрсэн бөгөөд энэ нь махны чанарт, нийлүүлэлтийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж буй.

Нядалгааны ба боловсруулах төвүүд

Нядалгааны төвүүдийн тоо өсч байгаа ч тэдний 90% нь улирлын чанартай ажилладаг, олон улсын стандарт хангах чадвар муу, дэд бүтэц сул байгааг онцолсон.

Мөн зах зээлд гар аргаар мах бэлтгэх нь давамгайлсан хэвээр байгаа нь албан ёсны МБҮ-үүдийн өрсөлдөх чадварыг бууруулж байна.

Үйлдвэрүүдийн ихэнх нь олон улсын стандарт (HACCP, ISO гэх мэт)-ыг бүрэн нэвтрүүлээгүй, техникийн хүчин чадал дутмаг, хүний нөөцийн мэргэжлийн байдал сул, бүтээгдэхүүний төрөл цөөн, хөргөлтийн логистик хязгаарлагдмал гэсэн сул талууд илэрсэн.

Экспорт, тээвэр, зохицуулалт

Экспортын процесс дотор дэд бүтэц, агуулахын хүрэлцээ, тээвэрлэлтийн нөхцөл, хууль эрх зүйн давхардал, экспортын зөвшөөрөл олголтын зохисгүй хуваарилалт, сав баглаа боодол, брэнд хөгжүүлэлт зэрэг олон асуудлууд багтаж байгаа. Экспортын квотыг МБҮ-д шударга бус хуваарилж, шаардлага хангаагүй үйлдвэрүүдэд квот олгодог байдал мөн тодорхой болжээ.

Мөн мах экспортлогч нь гаалийн байгууллагын магадлан итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр л тээвэр хийх ёстой болсон бөгөөд тээврийн хэрэгсэл, хөргөлтийн үйлчилгээний хүртээмж маш хомс байгааг онцолсон.

Гол дүгнэлт, зөвлөмж

- Экспортын сүлжээний **бүх шатанд зохион байгуулалтын оновчлол шаардлагатай**.
- **Бэлчээрийн менежмент**, **малын эрүүл мэндийн хяналт**, **нядалгаа, боловсруулах үйлдвэрүүдийн стандартын шинэчлэл**, **тээвэрлэлтийн дэд бүтцийн шийдэл**, **экспортын квотын хуваарилалтын ил тод байдал** зэргийг нэн даруй сайжруулах хэрэгтэйг зөвлөсөн.
- Мөн **махны брэнд, маркетинг, төрөлжүүлэлт, гүн боловсруулалт, олон улсын стандарт нэвтрүүлэх** нь экспортын өсөлтийн боломжийг бүрэн ашиглах үндэс болохыг дүгнэсэн.

3. Монголын мах экспортлогчдын зорилтот зах зээлийн шинжилгээ (2021)

Энэхүү судалгаа нь Монгол Улсын махны экспортын чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор зах зээлийн шинжилгээ хийхэд чиглэсэн бөгөөд хамгийн ирээдүйтэй таван зах зээлийг тодорхойлж, тэдгээрт нэвтрэх нөхцөл боломж, бэрхшээлүүд, хэрэглэгчийн хандлага, импортын бүтэц, ложистикийн сүлжээ, бизнесийн хамтын

ажиллагаа байгуулах арга замуудыг дэлгэрэнгүй судалсан байна. Судалгаанд БНХАУ, Япон, ОХУ, Вьетнам, Казахстан гэсэн таван улс стратегийн зах зээлээр сонгогдсон бөгөөд махны худалдааны урсгал, нэг хүнд ногдох болон нийт махны хэрэглээ, тээвэрлэлтийн зардал гэсэн шалгууруар үнэлгээ хийгдсэн байна.

Зах зээлийн онцлогууд

- **БНХАУ** – Хамгийн том импортлогч бөгөөд нийт хүн амын өсөлтөөс илүү өндөр өсөлттэй махны хэрэгцээтэй. Ялангуяа үхрийн мах, хонь, ямааны махны импорт эрчимтэй нэмэгдэж байна. Хөргөлтийн тээвэр, цахим худалдаа, нутгийн түгээлтийн сувгуудыг ашиглах нь чухал. Монголын хувьд экспортын хамгийн том түнш бөгөөд адууны махны гол нийлүүлэгч орон.
- **Япон** – Өндөр худалдан авалтын чадвартай, хүн ам нь буурч байгаа ч махны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа орон. Зах зээл нь олон давхар дистрибьютерээр дамждаг, чанар, стандартын өндөр шаардлага тавьдаг. Эмзэг бүлгийн хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүн хөгжүүлэх, цахим худалдааны сувгаар борлуулалт хийх нь боломжтой.
- **ОХУ** – Махны хэрэглээ өндөр, дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж байгаа боловч тодорхой төрлийн маханд импортод хамааралтай хэвээр. Монголын адууны махны хоёр дахь том худалдан авагч. Гэхдээ экспортын квотын бууралтаас шалтгаалан нийлүүлэлт буурсан. Зах зээлд оролцохын тулд албан ёсны экспортын сувгийг сайжруулах шаардлагатай.
- **Вьетнам** – Хурдан өсөн нэмэгдэж буй эдийн засагтай, хүн ам залуу, махны хэрэглээ өндөр. Ил тод, шинэ махыг уламжлалт захуудаар худалдан авах соёл давамгайлдаг ч орчин үеийн худалдааны сүлжээ хурдацтай өргөжиж байна. Монголын мах, ялангуяа хонины махыг сонирхох хандлагатай. Импортлогч байгууллагуудтай стратегийн түншлэл тогтоох нь чухал.
- **Казахстан** – Монголтой ижилхэн уламжлалтай, мах ихээр хэрэглэдэг орон. Гэхдээ гахайн махны хэрэглээ бага, хонины маханд хэрэгцээ өндөр. Монголын зүгээс морины мах экспортлох боломж нээлттэй. Тээвэрлэлтэд газар нутгийн хязгаарлалтаас шалтгаалан хөрш орнуудын логистикийн сүлжээ зайлшгүй шаардлагатай.

Дүгнэлт ба зөвлөмж

- Монгол Улс адууны махны хувьд стратегийн нийлүүлэгчийн байр суурьтай хэдий ч үхэр, хонины махны хувьд өрсөлдөөнд амжилт олоход нэгдсэн стратеги, чанар, стандарт, ложистикийн шийдлүүд зайлшгүй хэрэгтэй.
- Зорилтот зах зээл бүрт тохирсон экспортын стратеги боловсруулах, хэрэглэгчийн онцлогт нийцсэн бүтээгдэхүүн боловсруулах, зах зээлийн брэнд болон маркетинг хөгжүүлэх шаардлагатай.
- Цахим худалдаа, олон улсын үзэсгэлэн, импортлогч түнш байгууллагуудтай хамтран ажиллах зэргээр экспортын сувгийг төрөлжүүлэх хэрэгтэй.
- Экспортын тээврийн дэд бүтэц, мах боловсруулах стандарт, хяналт баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах замаар Монголын махны экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

4. Монголын дотоодын болон экспортын махны өртгийн сүлжээний судалгаа (2021)

Энэхүү судалгаа нь Монгол Улсын махны салбар дахь өртгийн сүлжээний бүтэц, үр ашиг, оролцогч талуудын үүрэг оролцоог тодорхойлох, системийн доголдлыг илрүүлэх, түүнийг засах бодлогын хувилбаруудыг санал болгоход чиглэсэн болно. Судалгаанд малчдаас эхлэн махны үйлдвэр, дамжин өнгөрөх худалдаачид, ложистик үйлчилгээний байгууллагууд, төрийн болон төрийн бус дэмжих байгууллагуудын оролцоог бүхэлд нь хамруулсан бөгөөд олон нийтэд суурилсан судалгаа, тоон болон чанарын шинжилгээнд үндэслэсэн байна.

Үндсэн ололт, дүгнэлтүүд

- Монгол Улсад 70 сая гаруй толгой мал бүртгэлтэй бөгөөд нэг хүнд ногдох малын тоогоор дэлхийд тэргүүлдэг ч махны экспортын хэмжээ болон нэмүү өртөг шингээх чадвар харьцангуй сул хэвээр байна.
- Малчдын олонх нь санхүүгийн эмзэг байдалтай, мэдээллийн хүртээмж бага, зах зээлийн үнэ тогтоох боломжгүй нөхцөлд ажиллаж байна. Малын эрүүл мэнд, тэжээллэг байдал, генетикийн чанар буурч, махны жин, чанар доройтож байгаа нь сүлжээний эх үүсвэрт ноцтой нөлөө үзүүлж буйг судалгаанд дурдсан байна.

- Бэлчээрийн даац хэтэрсэн, уур амьсгалын эрсдэл өндөр байгаа нь мал аж ахуйн тогтвортой байдалд аюул учруулж байна. Улсын нийт бэлчээрийн 57% нь доройтолд орсон гэж тооцогдсон байна.
- Малын халдварт өвчин, ялангуяа “хөлөн дээрх өвчин”-ий тархалт нь экспортын томоохон саад болж, олон улсын зах зээлд Монголын махны нэр хүндийг бууруулж байна.
- Мах бэлтгэх, боловсруулах үйлдвэрүүдийн дийлэнх нь хуучирсан техник, стандартын шаардлага хангахгүй, хүний нөөцийн чадавх сул, хөргөлт, агуулахын дэд бүтэц муу байгаа нь экспортод сөрөг нөлөөтэй.
- Хөргөлттэй ложистик, TIR гэрчилгээтэй тээврийн компани цөөн, гаалийн бүрдүүлэлт удаан, олон шат дамжлагатай бичиг баримт шаардлагатай байдал нь экспортын хурдыг сааруулдаг.
- Махны үнэ тогтворгүй, улирлын хэлбэлзэлтэй, зах зээлд хяналт сул, зохион байгуулалтгүй байна. Малчдын орлого, үйлдвэрлэлийн үр ашиг байнгын дарамтад байна.

Бодлогын зөвлөмжүүд

- **Богино хугацаанд** малын өвчнөөс ангид бүс тогтоох, бэлчээр ашиглалтын хууль, малын гарал үүслийн бүртгэл, экспортын квотын хуваарилалтыг ил тод болгох, бичиг баримтын системийг хялбаршуулах, хамтын хоршоо, кластерийн хөгжлийг дэмжих шаардлагатай.
- **Дунд хугацаанд** лабораторийн дэд бүтцийг сайжруулах, хөдөө аж ахуйн тээврийн шинэ зам, хил дамнасан ложистик коридоруудыг хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх талаар хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрт идэвхтэй оролцох хэрэгтэй.
- **Урт хугацаанд** боловсруулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээсэн махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, салбарын ажиллах хүчийг чадваржуулах, махны чанарын хяналтыг сайжруулах замаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг өсгөх боломжтой гэж судалгаа зөвлөжээ.

5. Монгол малын махыг экспортын чадамжтай брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх судалгааны ажлын тайлан (2023)

Монгол малын махыг олон улсын зах зээлд өрсөлдөхүйц чанартай, экспортын чадамжтай брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилготой энэхүү судалгаа нь Монгол орны мал аж ахуйн өнөөгийн байдал, бэлчээрийн доройтол, малын ашиг шимийн үзүүлэлт, махны биохимийн чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл байдал, ханган нийлүүлэлтийн сүлжээ, экспортын саад бэрхшээл, боломжуудыг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй үнэлгээний ажил юм.

Судалгаа нь Монгол орны дөрвөн бүсийн төлөөлөл болох Сэлэнгэ, Завхан, Дундговь, Хэнтий аймагт хийж, 1800 гаруй малын амьдын жингийн хэмжилт, галбирын үнэлгээ, биеийн хэмжээсүүд, 216 махны дээжинд хийсэн биохимийн шинжилгээ зэрэг бодит өгөгдөлд тулгуурласан. Махны дээжийг төрийн болон хувийн лабораториудад шинжилж, уураг, тос, эрдэс, антиоксидант идэвх, хүнд металл, эмийн үлдэгдэл, нянгийн бохирдлын түвшин зэрэг үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлжээ.

Судалгаагаар нутгийн монгол мал нь бэлчээрт дасан зохицсон, эрүүл ахуйн хувьд чадамжтай ч малын амьдын жингийн хувьд бүс нутгийн байгаль, бэлчээрийн нөөц, маллагааны аргаас ихээхэн хамааралтай болохыг тогтоосон. Жишээ нь, Сэлэнгэ болон Дундговь аймгийн малын амьдын жин, биологийн үзүүлэлтүүд стандартын түвшинд ойртож байхад Завхан, Хэнтий аймгуудад зарим үзүүлэлтүүд харьцангуй доогуур байгаа нь зуншлага, мал үржлийн зохион байгуулалт, тэжээллэг дутагдлаас шалтгаалж байгааг тэмдэглэжээ.

Махны биохимийн үзүүлэлтээр хонины маханд дунджаар 16-17% уураг, 9-13% тос, ямааны маханд 15-16% уураг, 7-11% тос, үхрийн маханд 15-17% уураг, 8-12% тос агуулагдаж байв. Хонины махны эрдсийн агууламж дунджаар 1.2-1.4%, харин гадаадын стандарттай харьцуулахад зарим хувьд тосны агууламж их, уургийн агууламж бага байх хандлага ажиглагдсан.

Махны аюулгүй байдалтай холбоотойгоор нянгийн бохирдол, хүнд металлын агууламж, эмийн үлдэгдэл илрэх тохиолдол ажиглагдсан нь мах бэлтгэлийн дараалал, хяналт хариуцлагын тогтолцоо сул байгааг илтгэж байна. Мөн махны боловсруулалтын шатанд хөргөлтийн сүлжээ дутмаг, нөөшлөлт, сав баглаа боодлын технологийн хөгжил сул байгаагаас олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар сул хэвээр байна.

Экспортын чадамжийг үнэлэхдээ БНХАУ, ОХУ, Вьетнам, Иран, Киргиз зэрэг зах зээлийн бүтэц, тээвэр ложистик, экспортын шаардлага, саад тотгоруудыг шинжлэн

судалсан. Тус судалгаанд багтсан SWOT ба PESTLE шинжилгээний дүнгээс харахад Монгол малын мах байгалийн цэвэр гарал, органик онцлог зэрэг давуу талтай ч, бэлчээрийн доройтол, малын эрүүл мэндийн хяналт сул, нэмүү өртөг шингээх дэд бүтэц дутагдалтай, экспортын бүрдүүлэлт төвөгтэй зэрэг сул талууд давамгайлж байна.

Судалгааны дүгнэлтэд, малын чанар, үржлийн удмын санг сайжруулах, бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй зохион байгуулалт хийх, махны аюулгүй байдлыг хангасан боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, олон улсын стандарт нэвтрүүлэх, логистикийн сүлжээг хөгжүүлэх, экспортын гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулах, зорилтот зах зээлд тохирсон маркетингийн бодлого хэрэгжүүлэх зэргээр цогц бодлогоор махны салбарыг дэмжих шаардлагатайг онцолжээ (ХХААХҮЯ, Судалгаа, хөгжлийн төв, 2023).

6. БНХАУ-д адууны мах экспортлох гарын авлага (2020)

Монгол Улсын адууны махыг БНХАУ-д экспортлох боломж, нөхцөл, зохицуулалт, практик шаардлагуудыг судалсан энэхүү гарын авлага нь бизнес эрхлэгчид, махны үйлдвэрлэгчдэд зориулсан бодит хэрэглээний шинжтэй, цогц мэдлэг, чиглүүлэг бүхий эх сурвалж юм. Гарын авлага нь адууны махны зах зээлийн нөхцөл байдал, үйлдвэрлэлийн чадамж, экспортын эрх зүйн орчин, стандартад нийцсэн бүтээгдэхүүн бэлтгэх болон экспортын бүх шат дамжлагыг ойлгомжтой, бодит жишээгээр тайлбарласан бүтээл болсон байна.

Судалгааны эхэнд БНХАУ-ын адууны махны хэрэгцээ, дотоодын үйлдвэрлэлийн бууралт, импортын хандлагыг авч үзсэн. 2018 оны байдлаар БНХАУ 177.8 мянган тонн адууны мах хэрэглэж, 29.5 мянган тонныг гадаадаас, голчлон Монгол Улсаас импортлосон байна. Тус улсад нэг хүнд ногдох адууны махны хэрэглээ бага ч өсөх хандлагатай бөгөөд махны үнэ өндөр, хэрэглээний чанарын шаардлага өндөр байгааг судалгаагаар тогтоосон. Монголын хувьд адууны махны нийт үйлдвэрлэлийн 65 хувийг экспортолж байгаа бөгөөд адууны махны нөөц, үйлдвэрийн аргаар бэлтгэх чадамж жилээс жилд өсч байгаа хэдий ч малын нөхөн сэргэлт удаан, сүргийн бүтэц хязгаарлагдмал тул экспортын зохицуулалт шаардлагатай байдаг.

Гарын авлагад тусгаснаар БНХАУ-д адууны мах экспортлох үйл явц нь олон улсын болон хоёр талын хууль, журам, гэрээ хэлцлүүд дээр суурилдаг. Тухайлбал, малын гарал үүслийн баталгаажуулалт, халдварт өвчнөөс ангид байх шаардлага,

малын эм, хорт бодисын үлдэгдлийн хяналт, дулааны боловсруулалтын шаардлагуудыг хангасан байх ёстой. Мөн экспортод зориулагдсан махны үйлдвэр нь БНХАУ-ын баталгаажуулалтын системд бүртгэгдсэн, хянан магадлагаанд хамрагдсан байх нь зүйтэй.

Экспортын өмнөх бэлтгэл ажилд гэрээ байгуулах, тээвэрлэлтийн хэлцэл хийх, төлбөр тооцоо тохирох, бүтээгдэхүүний шошго, сав баглаа боодлыг стандартын дагуу бэлтгэх зэрэг олон талт үйл явц багтдаг. БНХАУ-ын гаалийн байгууллагын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг экспортлохын тулд стратегийн хүнсний экспортын зөвшөөрөл, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ зэрэг албан ёсны баримт бичгийг бүрдүүлэх шаардлагатай. Үүний зэрэгцээ экспортын тээвэрлэлтийн горим, лацдах үйл явц, тээврийн хэрэгслийн ариун цэвэр, хадгалах нөхцлийн шаардлага ч өндөр тавигддаг.

Гарын авлагын төгсгөлд экспортын үйл ажиллагаанд нийтлэг тулгардаг хүндрэл, эрсдэлийг тодорхойлж, түүнийг бууруулах бодитой зөвлөмжүүд өгсөн. Тухайлбал, БНХАУ-ын зах зээлийн хэл, соёл, хууль тогтоомжийн онцлог, бүртгэлийн төвөгтэй процесс, үйлдвэрлэлийн стандартыг хангах шаардлагатай тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, мөн экспортыг дэмжих түншлэлүүдийг зөв төлөвлөх хэрэгцээг онцолсон. Мөн адууны махны үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд хатаасан мах, утсан мах, хиам зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэх, зорилтот бүс нутагт (ШУӨЗО, Шинжаан) чиглэсэн маркетингийн стратеги боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэйг онцолжээ.

Энэхүү гарын авлага нь адууны мах экспортлох үйл явцын хууль эрх зүйн зохицуулалт, стандарт шаардлага, хэрэгжүүлэх алхамуудыг нарийвчлан танилцуулсан төдийгүй, бизнесийн практикт шууд хэрэгжихүйц зааварчилгаа, зөвлөмжүүдээр баялаг баримт бичиг болжээ (Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Ганчимэг, Х.Бодьсайхан, Э.Тэмүүлэн, 2022).

7. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох гарын авлага (2022)

Судалгаанд БНХАУ-ын махны үйлдвэрлэлийн бүтэц, хэрэглээний чиг хандлага, импортын хэмжээ, зохицуулалтын орчин, экспортын түнш орнуудын талаарх мэдээлэлд үндэслэн Монгол Улсын хувьд өгөөж өндөртэй, боломжит экспортын гол зах зээл болохыг дүгнэсэн. Тус улс 2020 онд 9.9 сая тонн мах импортолсон ба махны төрлөөр авч үзвэл гахайн мах зонхилж, үүний дараагаар тахианы мах, үхрийн мах, хонины мах багтдаг. Гэвч хонины махны хувьд импортын

хэмжээ буурч байгаа хэдий ч нэгжийн үнэ өсөх хандлагатай байгаа нь өндөр үнээр нийлүүлэх боломжийг илтгэж байна.

Экспортод тохирох бүтээгдэхүүний ангилал, боломж

Экспортод хамгийн тохиромжтой гэж үзсэн бүтээгдэхүүний ангилалд:

- Нөөшилсөн мах (HS:160290)
- Хатаасан үхрийн мах (HS:160250)
- Хонины хөргөсөн мах (HS:020422)
- Хөлдөөсөн адууны мах (HS:020690)
- Нохойн хоол (HS:230910)
- Хөлдөөсөн гулууз (HS:020441)
- Хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн (HS:160100) багтдаг.

Эдгээр ангилалд Монгол Улс RCA үзүүлэлт, Портерийн загвар ашиглан давуу байршил эзэлдэг бөгөөд олон бүтээгдэхүүний ангилалд Монгол Улс БНХАУ-ын цорын ганц нийлүүлэгч орон байгаа нь зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг.

Экспортын үйл явц ба зөвшөөрлийн тогтолцоо

Мах экспортлох үйл явцад Монгол Улсаас дараах төрийн байгууллагууд оролцдог: МХЕГ, МЭЕГ, СХЗГ, ГЕГ, ХХААХҮЯ. Харин БНХАУ-ын талаас GACC, SAMR, NHCC зэрэг байгууллагууд хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийг хариуцдаг.

Хоёр улсын хооронд байгуулсан протоколын дагуу БНХАУ-д экспортлох махны үйлдвэрүүдийн урьдчилсан хянан магадалгаа, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээ зэрэг 13 нэр төрлийн бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай.

Экспортын төвшин дэх бэрхшээл ба шийдэл

Тайланд дурдсанаар экспортын тогтолцооны хүндрэлүүд:

- Хилийн боомтын гаалийн хүнд суртал
- Хөргөлтийн логистик хангалтгүй
- Шошго, сав баглаа боодол нь олон улсын стандарт хангахгүй байх

- Бүтээгдэхүүний амт, бүтэц БНХАУ-ын хэрэглэгчийн хандлагад нийцэхгүй байх зэрэг байна.

Иймд судалгааны дүгнэлтээр дараах зөвлөмжийг гаргасан:

- Бүтээгдэхүүний ангилалд тохирсон шошго, баглаа боодол, брэнд хөгжүүлэлт хийх
- Экспортын санхүүжилт, эргэлтийн хөрөнгийн дэмжлэг бий болгох
- БНХАУ-ын дотоодын хэрэглээний онцлогт нийцсэн боловсруулалт хийх
- БНХАУ дахь импортлогч байгууллагуудтай урт хугацааны түншлэл байгуулах
- Мах экспортлогч 31 итгэмжлэгдсэн үйлдвэрүүдийн техникийн чадавхыг сайжруулах (Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Энх-Амгалан, Ц.Батнаран, О.Амартүвшин, 2020).

8. БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох (2022)

Энэхүү гарын авлагын зорилго нь Монгол Улсын үхрийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, экспортлогч аж ахуйн нэгжүүдийг БНХАУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэг, баримт бичиг, хууль эрх зүйн зохицуулалт, техникийн шаардлагууд, экспортын үе шаттай дэлгэрэнгүй танилцуулах явдал юм. Судалгааны агуулга нь Хятадын зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн бүтэц, Монголын үйлдвэрлэлийн чадамж, экспортын бэлтгэл болон техникийн зохицуулалтын талаарх иж бүрэн мэдээллийг агуулдаг.

Үндсэн ололт, дүгнэлтүүд

БНХАУ бол дэлхийн хүнсний хэрэглээний томоохон зах зээл бөгөөд үхрийн махны хэрэглээний өсөлт нь тогтвортой хэвээр байна. 2020 онд БНХАУ-д үхрийн махны хэрэглээ 8.33 сая тоннд хүрсэн нь өмнөх 10 жилийн хугацаанд 41.8 хувийн өсөлттэй байжээ. Үйлдвэрлэлийн хувьд 6.72 сая тонн мах үйлдвэрлэсэн боловч дотоодын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь импортын эрэлт нэмэгдэх шалтгаан болж байна. Гахайн махны хэрэглээний бууралт нь үхрийн махны хэрэглээг улам нэмэгдүүлж буй гол хүчин зүйл юм.

Монгол Улсын хувьд 2019 оны байдлаар 114.7 мянган тонн үхрийн мах бэлтгэсэн бөгөөд 92.7 хувийг нь дотоодын зах зээлд, 7.3 хувийг гадаад зах зээлд нийлүүлсэн байна. Монголчуудын нэг хүнд ногдох үхрийн махны хэрэглээ 42.09 кг байгаа нь олон улсын дунджаас өндөр үзүүлэлттэйд тооцогдоно. Үхрийн махны экспортын дундаж үнэ нэг кг тутамд 2.95 ам.доллар байгаа ба голчлон БНХАУ, ОХУ, Япон зэрэг улсууд руу экспорт хийдэг байна.

Экспортын зохицуулалт ба бэрхшээлүүд

Махны экспортын үйл ажиллагаа нь олон шат дамжлагатай бөгөөд стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, дотоодын болон олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээ зэрэг бичиг баримтын иж бүрэн бүрдлийг шаарддаг. БНХАУ-ын импортын хяналт нь маш нарийн бөгөөд шошго, сав баглаа боодол, тээвэрлэлтийн горим хүртэл тусгай стандартад нийцэх шаардлагатай. Мөн үйлдвэрүүд нь урьдчилсан магадалгаа хийлгэж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын бүртгэлд хамрагдах ёстой бөгөөд энэ нь ихээхэн зардал, хугацаа шаарддаг процесс юм.

Бодлогын зөвлөмжүүд

- **Техникийн болон зохицуулалтын хүчин чадлыг сайжруулах**: Экспортын процессын бүхий л шатанд оролцогч талууд БНХАУ-ын хууль эрх зүй, стандарт шаардлагад нийцсэн чадвар, хангамжийг бүрдүүлэх нь нэн чухал.
- **Эрүүл бүсийн тогтолцоо ба мөшгих систем**: Мал, түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулах, эрүүл мэндийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь экспортын боломжийг нээж, зах зээлд итгэл төрүүлэх гол нөхцөл юм.
- **Худалдааны чадамжийг нэмэгдүүлэх**: Үйлдвэрлэл, боловсруулалт, сав баглаа боодол, ложистикийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, бүтээгдэхүүнээ брэнд болгон экспортлох маркетингийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.
- **Экспортлогчдын нэгдсэн цахим систем ашиглах**: Гаалийн бүртгэл, гэрчилгээний үйл ажиллагааг цахимжуулж, нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх замаар цаг хугацаа, зардлыг бууруулах боломжтой (Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Энх-Амгалан, Ц.Батнаран, О.Амартүвшин, 2022).

9. ОХУ-д адууны мах экспортлох монгол улсын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчдэд зориулсан цогц гарын авлага (2020)

Энэхүү судалгааны гол зорилго нь Монгол Улсын адууны махны үйлдвэрлэл, экспортын чадамжийг үнэлэх, ОХУ-ын зах зээлийн онцлогийг тодорхойлох, экспортын бэлтгэл ажлууд болон зохицуулалтын орчныг нэгдмэл байдлаар тайлбарлаж, экспортлогч аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай мэдлэг, зөвлөмж өгөхөд чиглэсэн юм. Судалгаа нь ОХУ дахь адууны махны хэрэглээний бүтэц, Монголын адууны махны үйлдвэрлэлийн хэмжээ, экспортын түүхэн өгөгдөл, тээвэр ложистик, тарифын болон тарифын бус саад бэрхшээл, хууль эрх зүйн орчин зэрэг олон талт мэдээлэлд тулгуурласан.

Монгол Улс нь адууны тоо толгойгоор дэлхийд дээгүүрт жагсаж, 2018 оны байдлаар 3.94 сая адуутай, үүнээс жилд дунджаар 57.2 мянган тонн адууны мах үйлдвэрлэж, үүний 42 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж байна. Адууны махны экспорт 2003 оноос эхэлж, 2014 оноос тогтвортой өсч, 2018 онд нийт махны экспортын 81.8 хувийг эзэлсэн байна. Гол зах зээл нь БНХАУ, ОХУ, Казахстан бөгөөд ОХУ руу чиглэсэн экспортын хэмжээ 2015 оноос буурсан ч тус улс нь Монголын адууны махны уламжлалт, чухал хэрэглэгч хэвээр байна.

ОХУ нь адууны махыг голлон Латин Америк болон Монгол Улсаас импортолдог ба Монгол улс 2018 онд ОХУ-ын нийт адууны махны импортын хоёрдугаар том нийлүүлэгч байсан. Импортын үнийн дүн нь ойролцоогоор 2.6 ам.доллар/кг бөгөөд энэ нь өрсөлдөх чадвартай ханшид тооцогддог. Гэсэн ч экспортын үйл явцад оролцохын тулд олон шатлалт шалгалт, гэрчилгээ, стандартад нийцэл, хянан магадлагаа шаардлагатай. Мах боловсруулалтын үйлдвэрүүд ОХУ-ын Россельхознадзор байгууллагаар хянан магадлуулж, ЕАЭЗХ-ийн эрх бүхий жагсаалтад бүртгэгдэх шаардлагатай байдаг. Одоогийн байдлаар Монголын 30 үйлдвэр бүртгэгдсэнээс 26 нь экспортын эрхтэй байна.

Судалгаанд дурдсанаар экспортын эрх авахын тулд дотоодын үйлдвэрүүд дараах шаардлагыг хангах ёстой. Үүнд түүхий эдийн эрүүл ахуйн байдал, үйлдвэрлэлийн технологийн урсгал, ариун цэврийн хамгаалалтын бүсийн зохион байгуулалт, хүйтэн агуулахын систем, сав баглаа боодол, шошголжилт, экспортын бичиг баримтын бүрдүүлэлт, гэрээний нөхцлийн зохицуулалт багтдаг. Мэргэжлийн хяналтын байгууллага, мал эмнэлгийн албаны үзлэгээр олон нийтлэг зөрчлүүд

илэрсэн бөгөөд эдгээр нь үйлдвэрлэлийн чадамжийг бууруулж, экспортод сөргөөр нөлөөлж байна.

Гаалийн болон тарифын зохицуулалтын хувьд ОХУ нь адууны маханд 15% эсвэл 1 кг тутамд 0.15 еврогийн хосолсон татвар ноогдуулдаг ч Монгол улс Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу 25%-ийн хөнгөлөлт эдэлж, 11.25% тарифтай бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой. Үүнийг баталгаажуулахын тулд “FORM A” гарал үүслийн гэрчилгээ шаардлагатай байдаг.

Судалгааны дүгнэлтээр адууны махны экспортын чадамжийг нэмэгдүүлэхэд дараах арга хэмжээг онцлон санал болгожээ:

- **Экспортын стандартын тохируулга**: ОХУ-ын болон ЕАЭЗХ-ийн махны импортын стандарт, шалгуурт нийцсэн байдлыг хангах;
- **Мал эмнэлэг, ариун цэврийн тогтолцоог сайжруулах**: Мал эмнэлгийн хяналт, өвчингүй бүсчлэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн нөхцөлийг чангатгах;
- **Үйлдвэрлэлийн чадавхийг нэмэгдүүлэх**: Ариун цэвэр, хүйтэн хэлхээ, лабораторийн шинжилгээний чадамжийг олон улсын түвшинд хүргэх;
- **Зохицуулалтыг хялбаршуулах**: Экспортын зөвшөөрөл, гэрчилгээ, гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг хялбаршуулах;
- **Сургалт, чадавхжуулалт**: Үйлдвэрүүдийн менежер, мэргэжилтнүүдийг ОХУ-ын хууль, журамд нийцүүлэн сургалтанд хамруулах;
- **Мөшгих тогтолцоо бүрдүүлэх**: Бүтээгдэхүүний гарал үүслийг фермерээс хэрэглэгч хүртэл хянах системийг нэвтрүүлэх;
- **Маркетинг, брендинг**: Адууны махны онцлог, эрүүл мэндийн ач холбогдлыг хэрэглэгчдэд хүргэх брэнд хөгжүүлэлт хэрэгжүүлэх (Д.Адьяасүрэн, Н.Отгонсайхан, А.Доржпалам, 2020).

10. Экспортын нэг цонхны цахим үйлчилгээний систем (2023)

Монгол Улсад малын гаралтай бүтээгдэхүүн, тэр дундаа мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явц олон шат дамжлага, байгууллагын оролцоотой, баримт бичгийн төвөгтэй бүрдүүлэлт шаарддаг тогтолцоотой байгаа нь экспортын бүтээмж, бизнесийн орчныг хүндрүүлж буйг судалгаагаар онцолсон. Энэхүү

судалгааны ажлын зорилго нь энэхүү үйл явцыг хөнгөвчлөх, цахимжуулах, төрийн байгууллагуудын мэдээлэл солилцоог сайжруулах зорилготой “Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем”-ийг нэвтрүүлэх нөхцөл, шаардлага, боломжийг тодорхойлоход чиглэжээ.

Судалгааны явцад мах, махан бүтээгдэхүүний экспортод шаардагдах нийт 50 гаруй баримт бичиг, эдгээрийн дунд 8 нэр төрлийн баримт бичгийн бүрдүүлэлт нь 2 ба түүнээс дээш байгууллагад давхарддаг болох нь тогтоогдсон. Энэ нь зөвхөн нэг компани экспортын зөвшөөрөл авахын тулд 15 нэр төрлийн баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай байдаг ба үүний дараагаар экспортын гэрчилгээ авахдаа дахин 12 баримт бичиг бүрдүүлэх шаардлага гардаг. Ийм нөхцөлд экспортлогчдын хувьд цаг хугацаа, зардлын дарамт үүсч, авлига, хүнд суртлын эрсдэл нэмэгддэг.

Судалгаагаар гадаад орны жишээ, тухайлбал БНХАУ, Энэтхэг, Австралийн экспортын зохицуулалтыг харьцуулан судалсан бөгөөд эдгээр орнуудад төрийн зохицуулалт төвлөрсөн, цахимжсан, үйлчилгээний стандарт тогтсон, бизнес эрхлэгчдэд зориулсан нэгдсэн платформ, мэдээллийн нээлттэй системүүд хөгжсөн нь экспортын үйл явцыг илүү шуурхай, үр ашигтай болгож буйг харуулсан.

Монгол Улсад ийм төрлийн шийдэл хэрэгжих бүрэн боломжтой бөгөөд “Экспортын нэг цонхны цахим нэгдсэн систем” нь төрийн байгууллагуудын мэдээллийг нэг төвд цуглуулан, аж ахуйн нэгжүүдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх, баримт бичгийн бүрдүүлэлтийг хялбарчлах, мөн төрийн байгууллагуудын хоорондын уялдааг сайжруулах, нэгдсэн платформоор дамжуулан хүсэлт илгээх, гэрчилгээ, зөвшөөрөл олгох, хяналт шалгалтын үйл явцад ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох чухал ач холбогдолтой гэж дүгнэжээ.

Тайлангийн үр дүнд “Экспортын нэг цонхны систем”-ийг дэмжихэд шаардлагатай хууль эрх зүйн өөрчлөлтүүдийг мөн тодорхойлсон бөгөөд стратегийн хүнсний бүтээгдэхүүний экспортын зөвшөөрөл, бодлогын гэрээ, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээ зэрэг бичиг баримтуудыг цөөлөх, заримыг нь цахимжуулах, шаардлагатай тохиолдолд хасах боломжтойг дурдсан. Судалгаанд дурдсанаар энэхүү систем нэвтэрснээр экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн хугацааг 316 цагаас 50 хувиар бууруулах, зардлыг 300 мянга гаруй төгрөгөөс доош бууруулах бодит боломжтой аж.

Мөн төрийн байгууллагуудын мэдээллийн системийг хооронд нь холбох, API интеграц хийх, анхан шатны баримт бичгийн мэдээллийг нэгдсэн сангаар солилцдог


байхаар шийдэх нь гол тулгуур болох бөгөөд МЭЕГ, ГЕГ, СХЗГ зэрэг байгууллагууд энэхүү системд нэгдэх сонирхлоо илэрхийлсэн байдаг. Судалгааны төгсгөлд энэхүү системийг хөгжүүлж, нэвтрүүлэхэд шаардлагатай техникийн шийдэл, цаг хугацаа, хөрөнгө оруулалтын тооцоог гаргасан бөгөөд системийн анхны загварыг “Бүрдүүлэлт мэдээллийн нэгдсэн систем” хэлбэрээр хэрэгжүүлж, цаашид шат дараатайгаар бүрэн цахим системд шилжих зорилт тавьсан байна (ХААБ, 2023).

Гурав. 2024 ОНД ЭКСПОРТОД ГАРСАН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДҮН МЭДЭЭЛЭЛ

Гаалийн Ерөнхий газраас ирсэн мэдээллээр 2024 онд нийт 269,099,824$-той тэнцэх 69,314,492 кг мах, махан бүтээгдэхүүнийг экспортод гаргасан байна.

Нийт экспортод гарсан мах, махан бүтээгдэхүүний эзлэх жинг хувиар харвал, 70% нь мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн байгаа бол 30% нь махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүн байна. Тус бүтээгдэхүүний статистик дүн буюу орж ирсэн мөнгөн дүнг доллараар харвал, 65% нь мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн, 35% нь махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний экспортоор орж ирсэн орлого байна.

Гарфик 1. 2024 онд экспортод гарсан мах, махан бүтээгдэхүүний эзлэх жин



3.1 Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний экспорт

2024 онд 15 улс руу 48,354,403 кг мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн экспортод гаргасан. Тоо хэмжээ болон статистик дүнг улсаар харьцуулж харвал, БНХАУ болон Иран Улс руу хамгийн их мах экспортолсон байна. Өөрөөр хэлбэл нийт мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний 81.9% нь БНХАУ болон Иран Улс руу экспортод гарсан бол бусад 13 улс руу дээрх 2 улсаас 5 дахин бага буюу 18%-ийн экспорт хийсэн байна.

Хүснэгт 1. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн *(улсаар)*

№	Улс	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	Азербайжан	609,267	1.3%	1,839,611	1.0%
2	Арабын Нэгдсэн Эмират Улс	1,250	0.003%	3,625	0.0%
3	Армени	20,000	0.041%	68,100	0.0%
4	**БНХАУ**	**22,413,280**	**46.4%**	**79,448,896**	**45.3%**
5	Вьетнам	390,000	0.8%	640,300	0.4%
6	Ирак	3,453,003	7.1%	13,474,971	7.7%
7	**Иран**	**17,184,399**	**35.5%**	**66,080,653**	**37.6%**
8	Казахстан	1,060,000	2.2%	3,538,449	2.0%
9	Катар	83,760	0.2%	281,834	0.2%
10	Кувейт	6,978	0.01%	28,781	0.0%
11	ОХУ	195,250	0.4%	732,167	0.4%
12	Тажикстан	35,500	0.1%	131,750	0.1%
13	Узбекстан	1,602,360	3.3%	5,261,001	3.0%
14	Хонконг	1,297,720	2.7%	3,997,426	2.3%
15	Япон	1,636	0.00%	7,649	0.0%
Нийт		**48,354,403**	**100%**	**175,535,213**	**100%**

2024 онд нийт 58 аж ахуй нэгж экспортод мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн экспортолсон. Экспортод гаргасан мах, дайвар бүтээгдэхүүний эзлэх жин болон статистик дүнд аж ахуй нэгжийн эзлэх жинг харьцуулж харвал 58 аж ахуй нэгжээс 20 нь 1%-аас илүү бүтээгдэхүүн экспортод гаргасан бол 38 нь 1% хүртэлх хэмжээний экспорт хийжээ. Үүнээс Монголиан мийт экспорт центр ХХК болон Монголмах экспо ХХК нийт экспортын 41.9%-ыг хийсэн байна.

Хүснэгт 2. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн *(аж ахуй нэгжээр)*

№	Байгууллага	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	Агронэгтгэл трейд ХХК	3,122,350	6.5%	11,560,586	6.6%
2	Азат ХХК	798,200	1.7%	2,742,662	1.6%
3	Баян нью фүүд сентури ХХК	664,500	1.4%	1,659,400	0.9%
4	Булганмах маркет ХХК	837,472	1.7%	2,778,886	1.6%
5	ГЛОБАЛ ОРГАНИК ТРЕЙД ХХК	2,211,300	4.6%	8,914,145	5.1%
6	Дарханмеат фүүдс ХХК	639,463	1.3%	2,249,286	1.3%
7	Дорнодмах маркет ХХК	660,760	1.4%	2,247,784	1.3%
8	Дун фан интернэйшнл трейд ХХК **/ГХО/**	637,210	1.3%	2,746,000	1.6%
9	ДЭЭЖИЙН ӨРГӨӨ ХХК	478,900	1.0%	1,747,985	1.0%
10	Жаргалант мах импекс ХХК	584,996	1.2%	1,930,510	1.1%
11	Жэй Икс Си Эс ХХК **/ГХО/**	2,200,000	4.6%	7,858,186	4.5%
12	Мах-Импекс ХК	1,915,083	4.0%	7,036,285	4.0%
13	Монгема	897,295	1.9%	3,814,445	2.2%
14	**Монголиан мийт экспорт центр ХХК**	**7,447,329**	**15.4%**	**28,177,364**	**16.1%**
15	**Монголмах экспо ХХК**	**12,790,000**	**26.5%**	**45,584,265**	**26.0%**
16	Оргилон гүн ХХК	2,025,000	4.2%	7,242,074	4.1%
17	Саян-Уул ХХК **/ГХО/**	2,500,000	5.2%	8,888,853	5.1%

18	Танассан интернэйшнл трейд	1,279,073	2.6%	5,269,154	3.0%
19	Тэсшим ХХК	550,000	1.1%	1,807,529	1.0%
20	Эрдэнэ хүнс ХХК **/ГХО/**	476,000	1.0%	1,869,000	1.1%
Нийт 1%-аас илүү		**42,714,931**	**88.5%**	**156,124,400**	**89.1%**
21	Бусад	5,564,472	11.5%	19,176,448	10.9%
Нийт		**48,279,403**	**100%**	**175,300,848**	**100%**

2024 онд экспортолсон бүтээгдэхүүний 99% нь мах байгаа бол 1% нь дайвар бүтээгдэхүүн байна.

Хүснэгт 3. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүний эзлэх жин

№	Төрөл	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	Дайвар	513,870	1.1%	648,009	0.4%
2	**Мах**	**47,840,533**	**98.9%**	**174,887,204**	**99.6%**
Нийт		**48,354,403**	**100%**	**175,535,213**	**100%**

Нийт экспортолсон махны 50%-ийн адуу, 47%-ийн хонины мах эзэлж байна.

Хүснэгт 4. 2024 онд экспортолсон мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн (*малын төрлөөр****)***

№	Малын төрөл	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	Адуу	24,007,786	50%	84,472,596	48.1%
2	Үхэр	232,080	0.5%	813,518	0.5%
3	**Хонь**	**22,519,091**	**47%**	**85,614,271**	**48.8%**
4	Ямаа	1,292,809	3%	4,086,270	2.3%
5	Тодорхойгүй	302,636	1%	548,558	0.3%
Нийт		**48,354,403**	**100%**	**175,535,213**	**100%**

3.2 Махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний экспорт

2024 онд 3 улс руу 20,906,090 кг махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүн экспортод гаргасан. Тоо хэмжээ болон статистик дүнг улсаар харьцуулж харвал, БНХАУ руу хамгийн их буюу 99%-ийг эзлэх экспорт хийжээ.

Хүснэгт 5. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн *(улсаар)*

№	Улс	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	БНСУ	80,904	0.4%	219,818	0.2%
2	**БНХАУ**	**20,750,860**	**99.3%**	**93,096,679**	**99.5%**
3	ОХУ	74,326	0.4%	248,115	0.3%
Нийт		**20,906,090**	**100%**	**93,564,611**	**100%**

2024 онд нийт 24 аж ахуй нэгж махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүн экспортолсон. Экспортод гаргасан махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний эзлэх жин болон статистик дүнд аж ахуй нэгжийн эзлэх жинг харьцуулж харвал 24 аж ахуй

нэгжээс 12 нь 1%-аас илүү бүтээгдэхүүн экспортод гаргасан бол 12 нь 1% хүртэлх хэмжээний экспорт хийжээ. Үүнээс Монгол тогоруу трейд ХХК /ГХО/ нийт экспортын 19.4%-ыг эзэлж байгаа нь хамгийн өндөр дүн байгаа бол 10%-аас 15% хүртэлх хэмжээний экспортыг 4 аж, ахуй нэгж *(Дарханмеат фүүдс ХХК, Дунюань ХАА ХХК /ГХО/, Цан сэн тиан ий ХХК /ГХО/, Эрүүл монгол мах эко ХХК)* хийсэн байна.

Мөн нийт экспорт хийсэн 24 аж ахуй нэгжийн 6 нь гадаадын хөрөнгө оруулалттай байгаа бөгөөд 3 нь 12%-аас 19%-ийн буюу хамгийн их хэмжээгээр экспорт хийсэн байна.

Хүснэгт 6. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, статистик дүн *(аж ахуй нэгжээр)*

№	Байгууллага	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	Агро мийт групп ХХК	1,149,000	5.5%	5,383,000	5.8%
2	Булганмах маркет ХХК	1,535,000	7.3%	6,862,500	7.3%
3	**Дарханмеат фүүдс ХХК**	**2,106,380**	**10.1%**	**9,693,529**	**10.4%**
4	**Дунюань ХАА ХХК /ГХО/**	**3,075,000**	**14.7%**	**13,710,000**	**14.7%**
5	Жэй Икс Си Эс ХХК /ГХО/	425,000	2.0%	1,912,500	2.0%
6	**Монгол тогоруу трейд ХХК /ГХО/**	**4,050,000**	**19.4%**	**17,305,000**	**18.5%**
7	Монгол ЭКОМАХ ХХК	1,494,100	7.1%	6,919,684	7.4%
8	Оргилон гүн ХХК	500,000	2.4%	2,475,000	2.6%
9	Өлзийт тал ХХК ГХО-тай ХХК /ГХО/	250,476	1.2%	1,126,364	1.2%
10	ПРЕКОМ ХХК	750,000	3.6%	3,372,138	3.6%
11	**Цан сэн тиан ий ХХК /ГХО/**	**2,500,000**	**12.0%**	**11,207,500**	**12.0%**
12	**Эрүүл монгол мах эко ХХК**	**2,684,660**	**12.8%**	**12,036,601**	**12.9%**
Нийт 1%-аас илүү		**20,519,616**	**98%**	**92,003,817**	**98%**
13	Бусад	386,474	2%	1,560,795	2%
Нийт		**20,906,090**	**100%**	**93,564,611**	**100%**

2024 онд экспортолсон бүтээгдэхүүний 99% нь болгож, хатаасан мах байгаа бол 1% нь нөөшилсөн, нухаш болон хиам байна.

Хүснэгт 7. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний эзлэх жин

№	Төрөл	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	**Мах**	**20,766,997**	**99%**	**93,136,436**	**99.5%**
2	Нөөшилсөн	138,222	0.66%	424,605	0.45%
3	Нухаш	16	0.00008%	139	0.00015%
4	Хиам	854	0.0041%	3,432	0.0037%
Нийт		**20,906,090**	**100%**	**93,564,611**	**100%**

Нийт экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний 64% нь ямааны махаар хийсэн нь хамгийн өндөр дүн байгаа бол 21% нь үхэр, 15% нь хонины махаар хийсэн бүтээгдэхүүн байна.

Хүснэгт 8. 2024 онд экспортолсон махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүн *(малын төрлөөр)*

№	Малын төрөл	Тоо хэмжээ КГ	Тоо хэмжээ хувь	Статистик дүн $	Статистик дүн хувь
1	Адуу	6,989	0.033%	17,074	0.018%
2	Үхэр	4,319,312	21%	21,191,226	23%
3	Хонь	3,048,677	15%	13,240,901	14%
4	**Ямаа**	**13,454,480**	**64%**	**58,902,991**	**63%**
5	Тодорхойгүй	76,632	0.37%	212,420	0.23%
Нийт		**20,906,090**	100%	**93,564,611**	100%

Дөрөв. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1 Махны үйлдвэр барьж, зөвшөөрөл авах үйл явц

Махны үйлдвэр барихад үйлдвэрлэлийн зориулалттай газар авах, үйлдвэрлэл явуулахад шаардагдах үйл явц байдаг.

1. **Газрын асуудал**
   - Үйлдвэрлэл эрхлэх газрыг сонгохдоо тухайн бүс нутагт үйлдвэрлэл явуулах боломжтой эсэхийг судална. Газрыг авахаасаа өмнө цахилгаан, ус, хог хаягдлын асуудлыг өөрсдөө урьдчилан шийдвэрлэх шаардлагатай. Тухайлбал:
     - **Цахилгаан:** Эх үүсвэрийг тодорхойлсон байх (жишээ нь цахилгаан дамжуулах шугамд холбох);
     - **Ус:** Усны эх үүсвэр, хэрэглээ, хаягдлын зохицуулалт;
     - **Хог хаягдал:** Ямар төрлийн хог гарах, хааш нь тээвэрлэх, хэрхэн боловсруулах талаар дүгнэлт гаргуулна.
2. **Мэргэжлийн байгууллагуудын зөвлөгөө авах**

   Газрын асуудлыг шийдсэний дараа дараах байгууллагуудаас аман зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ авдаг. Тодруулбал, тухайн нутаг оронд үйлдвэрлэл явуулах боломжтой эсэх, салхины чиглэл-салхины дээр байрлахгүй, салхины хурд, тоосжилт үүсгэх эрсдэлгүй байршил зэргийг хянаж тогтооно.
3. **Үйлдвэрлэлийн техник шийдэл**
   - Нам даралтын уурын зуух барих, дэд бүтцийн шийдлийг бүрдүүлэх.
   - Барилга угсралтын зургийг гаргахдаа мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг тусгах.
4. **Хяналт, дүгнэлт авах**
   - **Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч**: Үйлдвэрлэл явуулах нөхцөл хангаж байгаа эсэх талаарх **эхний дүгнэлтийг гаргана**.
   - **Улсын комисс**: Хүлээлцэх комисс бүрэлдэж, барилгын чанар, аюулгүй байдал, дүрэм журмыг хангасан эсэхийг шалгана.
   - **Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлт**: Эцсийн батламж хэлбэрээр гарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа албан ёсоор эхлэх боломжтой болно.

Асуудал, бэрхшээл

Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт” нь нийт 7 зүйлтэй бөгөөд мал бэлтгэх, төхөөрөх, мах болон махан бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдах, экспортлох, импортлоход мөрдөх техникийн болон эрүүл ахуйн шаардлагыг нарийвчлан тогтоосон баримт бичиг юм. Энэхүү зохицуулалтын гол зорилго нь хүн, малын эрүүл мэндийг хамгаалах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарыг хангах, улмаар нийтийн ашиг сонирхлыг хамгаалах явдалд оршдог.

Гэвч энэхүү зохицуулалтыг бодит үйл ажиллагаанд бүрэн хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэлүүд бий. Ялангуяа жижиг, дунд үйлдвэрүүд болон орон нутгийн мах бэлтгэлийн нэгжүүдийн хувьд шаардлагад нийцсэн дэд бүтэц, хөргөлт, ариун цэвэр, хаягдал ус цэвэршүүлэлт, тоног төхөөрөмж, мэргэшсэн хүний нөөц зэрэг нөхцөл бүрдүүлэхэд санхүү, техникийн чадавх дутмаг байх нь нийтлэг бэрхшээл болж байна. Түүнчлэн цахим бүртгэлийн системд мэдээлэл оруулах, лабораторийн шинжилгээний тогтолцоог бүрэн хангах, бүх шатны хяналт шалгалт, гэрчилгээжилт зэрэг нь өндөр төвшний зохион байгуулалт, тогтмол зардал шаардаж буй тул энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлүүд учирдаг байна. Тодруулбал,

- *Жижиг үйлдвэрлэгчид махны үйлдвэрийн стандартыг бүрэн хангахад хүндрэлтэй байдаг. Иймээс шаардлагыг бүрэн биелүүлж чадалгүй, зарим тохиолдолд албан ёсны бус, өөр төрлийн арга замаар асуудлыг шийдвэрлэх оролдлого хийдэг.* **Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т “Стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх шаардлагатай.”**
- *Махны техникийн зохицуулалт 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа хууль. Тус хуульд* ***махны үйлдвэрүүд цэвэрлэх байгууламжтай, эсвэл төвийн цэвэрлэх байгууламжтай холбогдсон байх*** *гэдэг заалт байдаг нь хөдөө орон нутагт, тэр тусмаа суманд байдаг үйлдвэрүүдэд боломжгүй зүйл. Хот суурин газар байрладаг үйлдвэрүүдэд тус заалт нь давуу байдлыг бий болгодог.* **"Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт"-ын 3.9.1-т төхөөрөх, боловсруулах үйлдвэр нь цахилгаан, дулааны төвлөрсөн болон хэсгийн сүлжээнд холбогдсон байх.**

Хүнсний тухай хуульд Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагад “хуульд заасан зөвшөөрөл авсан байх, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах үүрэгтэй” гэж ойлгомжгүй, тодорхой бус зүйл заалтыг оруулж өгсөн нь мах үйлдвэрлэх зөвшөөрөлгүй бой, цех, хувь хүн-малчид мах бэлтгэн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Нөгөө талаар зөвшөөрөл авсан байх гэдэг шалгуур үзүүлэлт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Мөн тус хуулиар хүнсний аюулгүй байдалд хяналт тавих хүрээнд төрийн хяналт тавих тухай заасан боловч бодит байдал дээр дотоодын махны хомстол, үнийн өсөлтөөс сэргийлэх шаардлагатай болсон тул хэрэгжүүлж чадахгүй нөхцөл байдал үүсдэг байна. Тодруулбал,

- *Мах үйлдвэрлэх зөвшөөрөлгүй бой, цех, хувь хүн-малчид дотоод болон гадаад мах нийлүүлж байгаа нь зөвшөөрөл авсан аж ахуй нэгжийн хувьд шударга бус нөхцөл байдлыг үүсгэдэг. Үүнийг холбогдох төрийн байгууллагууд мэдэж байгаа хэр нь үйл ажиллагааг нь хорьдоггүй.* “**Хүнсний тухай хууль” 10 дугаар зүйлд Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагын 10.1.7-д “Хуульд заасан бол *зөвшөөрөл авсан байх”,* 10.1.1-т Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг** өөрөө **хариуцах үүрэгтэй**. *Үүнд мэргэжлийн байгууллага тайлбар хийхдээ, Манай салбарын хяналтын байгууллага энэхүү үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохих хязгаарлалтыг хэрэгжүүлэх ёстой. Гэвч өнөөдрийн нөхцөл байдалд махны үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажиллаж, зах зээлд үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг тогтвортой нийлүүлж чадахгүй байгаа нь бодит байдал юм. Иймээс уг үйл ажиллагааг бүрэн хориглох нь шууд хүнсний хангамжийн доголдол үүсгэж болзошгүй. Хэрэв бүрэн хориглосон тохиолдолд зах зээл дээр махны хомсдол бий болж, улмаар иргэдийн махны хэрэглээ тасалдаж, үнийн огцом өсөлтийг үүсгэж болзошгүй. Иймээс бодлого боловсруулахдаа махны хангамжийн өнөөгийн нөхцөл байдал, зах зээлийн чадавхыг бодолцон, үе шаттай, зохицуулалттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн.* **Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд төрийн хяналт тавих үүрэгтэй**.

4.2 Үйлдвэрийн хяналт шалгалт

Монгол Улсад мах экспортолдог үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийх нь хүнсний аюулгүй байдал, чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангах, стратегийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зохицуулахад чиглэгддэг.

Энэ үйл ажиллагаа нь Монгол Улсын Хүнсний тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд хэрэгждэг. Хүнсний тухай хуульд хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой хангах зорилгоор хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтэд тавигдах шаардлагыг тодорхойлсон байдаг. Мөн стратегийн хүнс болох махыг экспортлох, импортлох зөвшөөрлийг олгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ нь махны чанар, гарал үүслийг баталгаажуулахад чухал үүрэгтэй.

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн:

- 7 дугаар зүйлд “Малын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа, малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих”;
- 9 дүгээр зүйлд “Мал эмнэлгийн хяналтын чиг үүрэг, мал төхөөрөх, мах боловсруулах явцад хяналт тавих, хорио цээрийн шаардлага мөрдүүлэх”;
- 10 дугаар зүйлд “Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хяналт, бүх дамжлагад хяналт тавих, баталгаажуулах, лабораторийн шинжилгээнд хамруулах” асуудлыг зохицуулдаг.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн:

- 3 дугаар зүйлд “Хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээлтэй, аюулгүй хүнсээр хангах”, “Хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага, Үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, худалдаанд оролцогч нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах үүрэгтэй.”;
- 6 дугаар зүйлд махны үйлдвэрлэлд тавигдах стандартын шаардлагыг тодорхойлж, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бүх шатны үйл ажиллагааг зохицуулах”
- 7 дугаар зүйлд “Махыг стратегийн хүнс хэмээн зааж, төрөөс онцгой анхаарах шаардлагатай бүтээгдэхүүнд багтаасан тухай”
- 12 дугаар зүйлд “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, гарал үүсэл, ариун цэвэр, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл зэргийг хянах” тухай асуудлууд зохицуулагддаг.

Үүнээс гадна Мал эмнэлгийн ерөнхий газар Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдаагүй асуудлыг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (WOAH)-ын зөвлөмжүүдийг үндэслэн импортлогч орны хорио цээрийн шаардлага болон олон улсын стандартын дагуу мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүдэд хянан магадалгаа хийж экспортлох эрх олгодог.

Хяналт шалгалтыг Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Стандарт хэмжилзүйн газар (СХЗГ) зэрэг байгууллагууд гүйцэтгэдэг бөгөөд эдгээр байгууллагууд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгжтэй хамтран ажиллаж, махны үйлдвэрлэлийн бүх шатанд хяналт тавьж, дотоодын зах зээл болон олон улсын худалдааны шаардлагыг хангах боломжийг бүрдүүлдэг.

Хяналт шалгалтын процесс

1. **Үйлдвэрийн урьдчилсан бүртгэл ба өргөдөл**
   - Экспорт хийх сонирхолтой аж ахуйн нэгж нь Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ) болон холбогдох ХХААХҮЯ-д өргөдөл гаргана.
   - Бүртгэлийн үед дараах бичиг баримтуудыг бүрдүүлдэг. Үүнд:
     - Үйлдвэрийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн мэдээлэл – Стандарт хэмжил зүйн газар
     - ISO[1] (International Organization for Standardization, n.d), HACCP[2] (World Healt Organizatoin, n.d) зэрэг чанарын болон аюулгүй байдлын стандартын гэрчилгээ (хэрэв байгаа бол);
     - Мал эмнэлгийн хяналтын тогтолцооны мэдээлэл – МЭЕГ;
     - Үйлдвэрийн зохион байгуулалтын бүдүүвч зураг, цэвэр бохир бүсийн зааглал.
2. **Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалт**
   - Мал эмнэлгийн ерөнхий газрын (МЭЕГ) хяналт, шалгалтын баг үйлдвэрт биечлэн очиж дараах зүйлсийг шалгана;
     - Халдваргүйтгэл, ариутгалын нөхцөл, үйл явц;
     - Хүнсний аюулгүй байдлын дотоод хяналт (SOP, тэмдэглэл, хяналтын картууд);

[1] ISO стандарт гэдэг нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, системийн чанар, аюулгүй байдал, үр ашиг, харилцан нийцлийг олон улсын түвшинд хангах зорилготой, зөвшөөрөгдсөн шаардлагын хэм хэмжээний баримт бичиг юм.
[2] HACCP нь хүнсний аюулгүй байдалд ноцтой нөлөөлөх аюулыг тодорхойлж, үнэлэн хянах замаар урьдчилан сэргийлэх системчилсэн аргачлал юм.

- Түүхий эд (малын гаралтай бүтээгдэхүүн) нь гарал үүслийн гэрчилгээтэй эсэх;
- Ажилчдын ариун цэвэр, хамгаалалтын хувцасны хэрэглээ;
- Бүтээгдэхүүн хадгалах болон тээвэрлэх нөхцөл;
- Үйлдвэрийн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийнэ;
- Байгаль орчин, агаарын бохирдол, бохир усны зохицуулалт, хог хаягдлын менежментийг үнэлнэ (Стандарт, хэмжил зүйн газар, n.d).

3. **Гадаадын хүлээн авагч орны шаардлага**
   - Хэрэв тодорхой улсад (жишээ нь БНХАУ, ОХУ, Вьетнам) экспорт хийх бол тухайн улсын хүлээн зөвшөөрсөн жагсаалтад багтсан байх шаардлагатай;
   - Зарим тохиолдолд тухайн улсын мэргэжлийн байгууллагын төлөөлөгчид Монголд ирж үйлдвэр дээр шалгалт хийдэг;
   - Улс орон бүр өөрийн шаардлагатай протокол, шалгуурыг тавьдаг ба энэ нь тус тусдаа нэмэлт бичиг баримт, баталгаажуулалт шаарддаг.
4. **Баталгаажуулалт ба Экспортын зөвшөөрөл олголт**
   - Хяналт шалгалт амжилттай болбол МЭЕГ-аас экспортын эрхтэй үйлдвэр хэмээн батламжилж, нэрийг улсын болон олон улсын (импортлогч улсын) системд бүртгэнэ;
   - Үйлдвэр нь экспортын мал эмнэлгийн гэрчилгээ гаргах эрхтэй малын эмчтэй байх ёстой;
   - Экспортын бүрдүүлэлтийн явцад тээврийн хэрэгсэл, сав баглаа, ачилтын нөхцөлд мөн хяналт тавигдана.
5. **Тогтмол хяналт, аудит**

   Экспортын эрх олгосны дараа үйлдвэрүүдэд тогтмол давтамжтай хяналт шалгалт хийдэг. Тухайлбал,
   - Жил бүрийн төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалт;
   - Бүтээгдэхүүний дээж авч лабораторийн шинжилгээ хийх;
   - Гадаадын импортлогч байгууллагын зүгээс санал гомдол ирсэн тохиолдолд тусгай шалгалт.

Асуудал, бэрхшээл

Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандарт хэмжилзүйн газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт хийхдээ Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих,

үр дүнг мэдээлэх журмыг баримталдаг бөгөөд тус журамд “Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан байдаг. Гэтэл үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн зүгээс стандарт шаардлагаа хангаж чаддаггүй, нөгөө талаар томилогдсон албан тушаалтан хувийн ашиг сонирхлыг үүднээс ямар нэг зөрчил илрүүлэхэд анхаарах байдал үүсдэг ч үйлдвэрлэгч талын зүгээс гомдол гаргах гэхээс илүүтэй шалгалтыг амжилттай дуусгахын тулд авлига өгөх тохиолдол гардаг байна.

- *Үйлдвэрийн хяналт, шалгалтад улсаас томилогдсон байцаагч нарт харилцаа, хандлагын асуудал байдаг. Тухайлбал, гэнэтийн шалгалт нэрээр ойр ойрхон ирж үйлдвэрийн үйл ажиллагааг түр хугацаанд цалгардуулдаг. Энэ нөхцөл байдлыг хурдан дуусгахын тулд аж ахуй нэгжийн зүгээс ямар нэг хэлбэрээр авлига өгөх нөхцөл байдлыг үүсгэдэг.*
- *Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандарт хэмжилзүйн газраас төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус 2 шалгалт хийдэг. МЭЕГ болон Стандарт хэмжилзүйн газар тус тусдаа хуулиар олгогдсон хяналт шалгалтын эрхтэй ч, тухайн үйлдвэрт хяналт тавих шалгуур, асуултын бүтэц, шалгалтын давтамжийн талаар уялдаа хангах тусгай заалт буюу мэдээлэл солилцооны механизмыг холбогдох заавруудад тусгаагүй тул шалгах асуудал нь давхарддаг.*
- *Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгжид тавьж буй стандарт, шаардлагыг аж ахуй нэгжийн зүгээс хангаж чадахгүй нөхцөл байдал үүсдэг тул зөвшөөрөл өгдөг газар, нэгжүүдийн удирдлагууд руу холбогдож шийдвэрлүүлэх тохиолдол байдаг.*


  Тус асуудалд ХХААХҮЯ-ны төлөөлөл хариулахдаа, Монгол Улсад махны үйлдвэрийн стандарт хангасан аж ахуй нэгж цөөхөн байдаг. Тэдгээр байгууллагууд нь ямар нэг хэлбэрээр хурдан, шуурхай шийдвэрлүүлэхийг хүсдэг гэж тайлбар хийсэн. **(Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор мал эмнэлгийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, норм, нормативыг мөрдөн, чанарын өндөр түвшинд хүртээмжтэй хүргэх, мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, түүний үр дүнг мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус журмын 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан байдаг.)**

4.3 Мах экспортлох зөвшөөрөл авах үйл явц

Мах экспортын хяналт, баталгаажуулалтын нэгдсэн процесс нь махны чанар, аюулгүй байдал, гарал үүслийг баталгаажуулж, олон улсын зах зээлд итгэлтэй, хууль ёсны экспорт хийх нөхцөлийг бүрдүүлдэг.

Өөрөөр хэлбэл, Зураг 1-т харуулсан үйл явцын дагуу гэрчилгээ болон холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, импортоор авах улс орны шаардлагад нийцсэн тохиолдолд мах экспортлох боломжтой болдог.

Зураг 1. Мах экспортлох зөвшөөрөл авах үйл явц



Асуудал, бэрхшээл

Мах экспортлох зөвшөөрөл авахтай холбогдсон бичиг баримтын бүрдүүлэлт хийж, хүсэлт илгээхэд ХХААХҮЯ, МЭГ, УМЭАЦТЛ, ГЕГ зэрэг байгууллагуудаар явж цаг алдах, мөн цахим сүлжээнээс доголдлоос үүдэн хугацаандаа мэдээллээ бүртгүүлэх боломжгүй болох эрсдэлүүд үүсдэг. Тодруулбал,

- *Цахим сүлжээний доголдлоос шалтгаалан экспортын бичиг баримт, лабораторийн хариу зэрэг мэдээлэл хугацаандаа бүртгэгдэж орж ирэхгүй хүлээгддэг тохиолдол цөөнгүй. Үүний улмаас 3–7 хоногийн хугацаанд саатал гарч, экспортын явц удаашрах, тээврийн зардал нэмэгдэх, бүтээгдэхүүний чанарт эрсдэл үүсэх нөхцөл бүрддэг.*
- *Махны экспорттой холбоотой баримт бичгийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөхийн тулд нэг цэгийн үйлчилгээ зайлшгүй хэрэгтэй. Одоогийн нөхцөлд экспортын зөвшөөрөл, мал эмнэлэг, ариун цэврийн бичиг, гааль, итгэмжлэл зэрэг олон байгууллагаар дамжин бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай байдаг нь цаг хугацаа, зардал ихтэй, хүндрэл үүсгэдэг. Харин нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлснээр бүх бичиг бариmтыг нэг газар, нэг цонхоор дамжуулан шийдвэрлэх боломж бүрдэж, экспортын үйл явц хялбар, хурдан болох нөхцөл бүрдэнэ гэж мах экспортлогч аж ахуй нэгжүүдийн зүгээс санаа бодлоо илэрхийлсэн.*

4.3.1 Квот болон Бодлогын гэрээ

Мах нь Монгол Улсын стратегийн хүнс тул хүнсний аюулгүй байдал, үнийн тогтвортой байдлыг хангах, хомсдолоос сэргийлэх зорилгоор дотооддоо нөөцтэй байх ёстой. Энэ агуулгаар 2022 оны 10 дугаар сараас өмнө экспортын махны квот тогтоодог байсан бол үүнээс хойш “Бодлогын гэрээ”-ээр зохицуулдаг болсон.

❖ **Экспортын махны квот**

Экспортын **махны квотыг** Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөс тогтоодог. Харин ХХААХҮЯ-наас ямар малын маханд хэр хэмжээний квот тогтоохыг зааж өгдөг байсан.

Асуудал, бэрхшээл

Хүнсний тухай хуулиар стратегийн хүнсийг экспортлох зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулах үйл явц болон үр дүнг цахим хэлбэрээр зохион байгуулах зохицуулалтыг хийсэн байдаг. Бодит байдал дээр квот хэрэгждэг байхад Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг томоохон компаниудад давуу байдлыг бий болгож, бусад оролцогч аж ахуй нэгжүүдэд ойлгомжгүй, ил тод бус байдлыг бий болгодог байжээ. Үүнээс үүдэн аж ахуй нэгжүүд дуудлага худалдаагаар квотыг шийдвэрлэх тухай яригдсан ч итгэл үнэмшилгүй байгаа бөгөөд тус шийдвэр нь мөн л томоохон хөрөнгө мөнгөтэй компанид давуу байдлыг бий болгоно гэж хардаж байна.

- *Квотыг ямар шаардлага, шалгууруур олгодог нь байгууллагуудад тодорхойгүй, ойлгомжгүй байдаг. Энэ нь тэгш боломж, ил тод байдалд сөргөөр нөлөөлж, байгууллагуудын төлөвлөлт, оролцоонд хүндрэл үүсгэдэг*.
- *Квот олгохдоо томоохон компаниудад давуу байдлыг бий болгож, жижиг компанийн боломжийг хязгаарладаг. Өөрөөр хэлбэл, том, хөрөнгө мөнгөтэй компаниуд их хэмжээний квот авч, жижиг компаниудаа квот авч чадахгүй байдлыг бий болгож байна. Квот авах эрхийг дуудлага худалдааны дагуу зохион байгуулахаар яригдаж байгаа ч энэ нь дахиад л хөрөнгөтэй компанид давуу байдлыг бий болгох эрсдэлтэй.* **(Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн, 5.1.4. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулахаар хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэсэн, эсхүл энэ хуулийн 5.1.22-т зааснаас бусад тохиолдолд стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.**

  5.1.5. Энэ хуулийн 5.1.4-т заасан сонгон шалгаруулалтыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг зохион байгуулна.

  5.1.6. Энэ хуулийн 5.1.5-д заасан ажлын хэсэг стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын зар гаргах, урилга хүргэх, хариу илгээх, үр дүнг мэдээлэх ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна.)

Хүнсний тухай хуулиар стратегийн хүнсийг экспортлох хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд үнэлгээ хийж, өгч болох тоо хэмжээний дээд хэмжээг тогтдог байна. Бодит байдал дээр аж ахуй нэгжүүдэд үйлдвэрийн хүчин чадлын хэмжээнд бус санхүүгийн чадавх дээр тулгуурлан квотын хэмжээг тогтож байгаа нь дотоодын үйлдвэрлэлийн хөгжлийг зогсонги байдалд оруулах нөхцөлийг бүрдүүлж байна. Тус хуулийн хүрээнд санхүүгийн боломжтой, хүчин чадал өндөр томоохон, эсвэл гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагуудад давуу байдлыг бий болгож байна.

Мөн үйлдвэрийн хүчин чадал, санхүүгийн болон бусад үйл ажиллагааны хувьд хангалттай байсан ч ажлын хэсгийн зүгээс субьектив хандлагаар хүссэн хэмжээнд нь квот тогтоодоггүй гэсэн хардлага мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдийн дунд байна.

- *Бага хэмжээний квот авсан аж ахуй нэгжүүд бүрэн чадлаараа ажиллах боломжгүй болсноор эдийн засгийн эргэлтийг сааруулж, дотоодын үйлдвэрлэлийн хөгжлийг зогсонги байдалд оруулдаг. Нөгөө талаар Монгол Улсад мөнгөн урсгал орж ирэх боломжийг бууруулдаг;*
- *Импортлогч улс дахь аж ахуй нэгжийн захиалгад дүйцүүлэн квотын хэмжээний хүсэлт өгөхөд тал хувьд нь зөвшөөрөл өгдөг. Жишээ нь, Импортлогч улс 1 тоннын гэрээ хийх хүсэлтэй байхад Монгол Улс 500 кг экспортлох зөвшөөрөл өгдөг.* **(ХҮНСНИЙ ТУХАЙ Хуулийн, 5 дугаар зүйлийн 5.1.11-т Ажлын хэсэг стратегийн хүнсийг экспортлох, импортлох хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд үнэлгээ хийж, нэг хуулийн этгээдэд өгч болох тоо хэмжээний зөвшөөрлийн дээд хэмжээг тогтоож болно. 5.1.12-т Ажлын хэсэг хуулийн этгээдийн хүсэлтэд дурдсан тоо хэмжээ болон энэ хуулийн 5 1.7, 5.1.10, 5.1.11-д заасан баримт бичгийг магадлан шалгасны үндсэн дээр уг хуулийн этгээдэд тухайн стратегийн хүнсийг экспортлох, эсхүл импортлох зөвшөөрөл олгох тоо хэмжээг тогтооно.)**

❖ **Бодлогын гэрээ**

Бодлогын гэрээний зорилго нь экспортын тогтвортой байдлыг хангах, чанартай бүтээгдэхүүнээр гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжихэд оршино (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2015).

Хүнсний тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт зааснаар “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага стратегийн хүнсийг экспортлох зөвшөөрөл олгоход зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 10 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлд нийлүүлэх, импортлох зөвшөөрлийг олгоход зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 50 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлээс худалдан авах шаардлагыг тавьж, хуулийн этгээдтэй энэ талаар гэрээ байгуулж болно” гэсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагад дээрх гэрээ байгуулах эрхийг хуулиар өгчихсөн тул “Бодлогын гэрээ”-г хуулийн этгээдтэй байгуулах нь хууль зөрчөөгүй. Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн

Монгол Улсаас түүхий мах, дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх (стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, квот)-тэй үйлдвэр (экспортлогч) нь ХХААХҮЯ-тай Бодлогын гэрээ байгуулна. Энэхүү гэрээ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, 38 хүнсний хангамж, үнийн түвшнийг тогтвортой хадгалахад чиглэгдэнэ. Бодлогын гэрээ байгуулахад дараах материалыг бүрдүүлнэ.

- Үйлдвэрийн танилцуулга;
- Бүтээгдэхүүний мэдээлэл, төлөвлөгөө;
- Мал эмнэлгийн гэрчилгээ;
- Бэлтгэсэн түүхий эдийн 30-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрт нийлүүлсэн тухай гэрээ, төлбөрийн баримт эсхүл экспортод гаргахаар зориулалтын агуулахад хадгалж буй баримт;
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, шинжээчийн дүгнэлт;
- Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хог хаягдлын гэрээ;
- Хоёр орны хооронд байгуулсан протоколын дагуу боловсруулж, батлуулсан технологийн заавар.

Асуудал, бэрхшээл

Хүнсний тухай хуульд Бодлогын гэрээний хүрээнд экспортын махны 10 хүртэлх хувийг дотоодын зах зээлд нийлүүлэх, хүнсний хангамж, үнийн түвшнийг тогтвортой хадгалах тухай зохицуулалтыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хийж, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохицуулдаг. Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.18-д " .....тухайн жилийн мал төллөх болон ургац хураах цаг хугацаанд стратегийн хүнсийг экспортлохгүй....." гэж заасан байхад Нийслэлийн Хүнс Хөдөө Аж ахуйн газар зохион байгуулалтын алдаа гаргаж, Сар шинийн баярын өмнөхөн мах үнэд орсон, мал эцэж ядарсан үед гэнэтийн шийдвэрээр нөөцийн мах бүрдүүлэх шийдвэр гаргаж, биелэх боломжгүй болоход ХХАА ХҮ-ийн сайд махны экспортыг түр хориглох шийдвэр гаргасан нь мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдийн экспортлохоор бэлдсэн байсан бүтээгдэхүүн гацах, үйл ажиллагаа нь зогсох, ажилчдаа тогтвортой ажлын байраар хангах боломжгүй болох, гадаадын харилцагч байгууллагатай хийсэн гэрээг цуцлах гэх зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгосон байна.

Гэтэл Бодлогын гэрээний дагуу өмнөх онд экспортолсон махны 10 хувьтай тэнцэх махаа нөөцөлсөн байх ёстой ч бэлэн байлгаагүй.

Дээрхээс дүгнэвэл, төрийн байгууллагын зүгээс цаг нь тулсан үед гэнэтийн шийдвэр гаргаж мах нөөцлөх шийдвэр гаргахад мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжийн зүгээс гэрээний дагуу нөөцийн бүрдүүлэлтээ хийгээгүй нөхцөл байдал үүссэн байна. Тодруулбал,

- *Нөөцийн мах бүрдүүлэлт хийх тендер хамгийн хямд байх үед зарлагдаж, сонгогдсон аж ахуй нэгж нийлүүлэх махны хэмжээ, үнийн дүнтэй гэрээ байгуулан, урьдчилгаа авч махны нөөцөө бэлтгэх ёстой. Гэтэл Нийслэлийн Хүнс Хөдөө Аж ахуйн газар Сар шинийн баярын өмнө, мах үнэд орсон үед тендер зарласнаар мах үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүд оролцоогүйгээс болж томоохон аж ахуй нэгжийг хүчээр оруулсан ч нөөцийн махаа бүрдүүлж чадаагүй нөхцөл байдал үүссэн. Өөрөөр хэлбэл, Нийслэлийн Хүнс Хөдөө Аж ахуйн газар өөрсдийн буруугаас болж нөөцийн махаа бүрдүүлж чадаагүй хэр нь, мах үнэд орсон үед Монгол Улсад онцгой нөхцөл байдал үүссэн тул мах экспортлогч аж ахуй нэгжүүд Бодлогын гэрээнийхээ дагуу мах нийлүүл гэж гэнэт тулган шаардсан нь бодлогын алдаатай байдлыг харуулж байна.*

- *Засгийн газраас мах экспортлогч аж ахуй нэгжүүдэд урьдчилан анхааруулалгүй махны экспортыг зогсоох шийдвэр гарсан. Жишээ нь, ХХААХҮ-ийн сайд Ж.Энхбаяр 2025.01.29-ний "Махны экспортын хэмжээг 6-р сарын нэгэн хүртэл хязгаарлаж, дотоодын махны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, үнийг буулгана" гэсэн шийдвэр гаргаснаар аж ахуй нэгжүүдийн экспортлохоор бэлдсэн байсан бүтээгдэхүүнүүд гацах, үйл ажиллагаа нь зогсож, ажилчдаа тогтвортой ажлын байраар хангах боломжгүй болох, гадаадын харилцагч байгууллагатай хийсэн гэрээг цуцлах, дотоодын нөөцийн мах хэвийн хэмжээнээс давж, борлуулалтгүй болох сөрөг үр дагаврууд гарсан. ХХААХҮЯ-ны төлөөлөл энэ тухайд албан ёсны шийдвэр гараагүй. Гэтэл төрийн байгууллага болон мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдийн дунд үйл ойлголцол үүссэн гэсэн тайлбар хийсэн.* **(ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН 5 дугаар зүйлийн 5.1.3. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага стратегийн хүнсийг экспортлох зөвшөөрөл олгоход зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 10 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлд нийлүүлэх, ... талаар гэрээ байгуулж болно. 5.1.18. Хүн амын хүнсний хангамж, үнийн түвшнийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний хязгаар тогтоохгүй, тухайн жилийн мал төллөх болон ургац хураах цаг хугацаанд стратегийн хүнсийг экспортлохгүй, импортлохгүй байх зохицуулалтыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хийж болно. 6.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 6.5.Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ. БОДЛОГЫН ГЭРЭЭНИЙ 3.5-д Энэхүү гэрээний 1.2-т заасан нөхцөл үүссэн үед ашиглах зорилгоор өмнөх онд экспортолсон махны тоо хэмжээний 10 хувьтай тэнцэх үхэр, хонины махыг бэлтгэн нөөцөлж, яамнаас чиглэл болгосны дагуу дотоодын зах зээлд худалдан борлуулна.)**
- *Орон нутагт байрладаг, гадаад руу мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагааны чиглэл бүхий аж ахуй нэгж (компани) Улаанбаатар хотод ирж гаалийн бүрдүүлэлт хийдэг. Ингэхдээ Бодлогын гэрээнд заасан*

экспортод гаргах махны 10 хүртэлх хувьд дүйцэх махаа Улаанбаатар хотод түгээхэд хүндрэлтэй байдаг. Учир нь дотооддоо мах түгээх чиглэлийн үйл ажиллагаа явуулдаггүй.

- *Бодлогын гэрээнд "заавал төрийн худалдан авалтад оролцсон байх" гэсэн шаардлага тавигддаг нь зөвхөн экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хүндрэл учруулах тохиолдол бий. Учир нь эдгээр байгууллага дотоодын төрийн худалдан авалтад оролцохоос илүүтэйгээр гадаад зах зээлд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг тул уг шалгуурыг хангах боломж хязгаарлагдмал байдаг.*

4.3.2 Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээ авах

Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/67 дугаар тушаалын дагуу олдог бөгөөд, цахим болон цаасан хэлбэртэй байна.

Гэрчилгээ авар процесс

1. Урьдчилсан бэлтгэх
2. Мал бэлтгэл, тусгаарлалт: Мах экспортлох зорилгоор мал бэлтгэх аж ахуй нь тусгайлан тусгаарласан аж ахуй байгуулах шаардлагатай. Энэ аж ахуй нь мал эмнэлгийн байгууллагын хяналтад байх бөгөөд малын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг тогтмол хийдэг.
3. Малын эрүүл мэндийн хяналт: Мал эмнэлгийн байгууллага нь тусгаарласан аж ахуйд байгаа малыг гоц халдварт өвчингүй болохыг нотлох зорилгоор тархвар зүй, эмнэл зүйн болон ийлдсийн шинжилгээний тандалт хийж, мэргэжлийн дүгнэлт гаргана.
4. Баримт бичгийн бүрдүүлэлт:
    - Мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт: Малыг эрүүл, халдварт өвчингүй болохыг баталгаажуулсан шинжилгээний дүн;
    - Мал эмнэлгийн байгууллагаас олгосон, малыг экспортлох боломжтойг нотолсон баримт бичиг;
    - Худалдах, худалдан авах гэрээ: Экспортлогч болон импортлогч талуудын хооронд байгуулсан гэрээний хуулбар.
    - Тээврийн мэдээлэл: Малыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа зэрэг мэдээлэл.

- Үйлдвэрийн мэдээлэл: Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр, хаяг, байршил зэрэг мэдээлэл.

5. Хүсэлт гаргах: Экспортлогч аж ахуйн нэгж нь дээрх баримт бичгийг бүрдүүлж, МЭЕГ-т Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авах хүсэлт гаргана. Энэ үйл явцыг цахим системээр дамжуулан хүсэлтээ илгээх боломжтой.
6. Баримт бичгийн шалгалт, үнэлгээ: МЭЕГ нь ирүүлсэн баримт бичгийг хянаж, шаардлага хангасан эсэхийг үнэлнэ. Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл, баримт бичиг шаардаж болно.
7. Мал эмнэлгийн гэрчилгээ олгох: Баримт бичгийн шалгалт, үнэлгээний үр дүнд үндэслэн, МЭЕГ нь Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгоно. Энэ гэрчилгээ нь экспортлогч орны мал эмнэлгийн эрх бүхий байгууллагаас малыг эрүүл, халдварт өвчингүй болохыг баталгаажуулсан албан ёсны баримт бичиг юм.

Асуудал, бэрхшээл

Бодлогын гэрээгээр мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хүчин чадлын хүрээнд экспортлох махны төрөл, хэмжээг тогтдог. Мөн импортлогч улс болон Монгол Улсын хооронд хийгдсэн протоколын дагуу экспортын зөвшөөрөл олгогддог байна. Тухайлбал БНХАУ бол зөвхөн өөрийн орны журмын дагуу бүртгэгдсэн аж ахуй нэгжээс л импортоор мах, махан бүтээгдэхүүн авдаг. Гэтэл аж ахуй нэгжийн зүгээс шаардлага хангасан өөр аж ахуй нэгжээс худалдан авалт хийж, өөрийн байгууллагын экспортод гаргах мах, махан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх сонирхолтой байсан ч дээрх зохицуулалт нь хязгаарлалт болдог байна.

Мөн импортлогч улс нь өөрийн лабораторийн шинжилгээний стандартад үндэслэн экспортлогч аж ахуй нэгжийг сонгодог нь Монгол Улс нүүдлийн мал ахуй эрхэлдэг, шаардлагатай тогтмол хийгдэх вакцинжуулалтад малаа хамрагдуулдаггүй малчдын хариуцлагагүй байдал болон Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораторийн тоног төхөөрөмж орчин үеийн шаардлагад нийцдэггүй байдагтай холбоотой байна.

- *.....“зөвхөн өөрийн зөвшөөрөгдсөн үйлдвэрт бэлтгэсэн бүтээгдэхүүнийг экспортлох” гэж заасан байдаг. Улирлын чанар, үйлдвэрийн хүчин чадлаас шалтгаалан экспортоор гаргах махны хэмжээнд хүрэхгүй тохиолдолд дээрх заалтаас болж өөр зөвшөөрөгдсөн үйлдвэрээс махны худалдан авалт хийж, нийлэх боломжгүй байдаг.*

  <u>ХХААХҮЯ-ны зүгээс тайлбар өгөхдөө, Монгол Улс мах экспортлохдоо чиглэл бүрд харилцан адилгүй нөхцөлтэй ажиллаж байна. Экспортын гол</u>

зах зээл болох БНХАУ зөвхөн тодорхой шаардлага хангасан, эрх авсан үйлдвэрүүдээс мах импортлохыг зөвшөөрдөг. Энэ хүрээнд БНХАУ-ын холбогдох байгууллагууд Монголын үйлдвэрүүдэд эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлага хангасан тохиолдолд бүртгэж авдаг. Бүртгэлгүй үйлдвэрээс импорт хийхийг хориглодог.

- *Монгол Улс нүүдлийн мал аж ахуйтай учраас мах боловсруулах үйлдвэрүүдийн гол түүхий эдийг малчдаас авдаг. Гэвч зарим тохиолдолд малчид бүх малаа бүрэн вакцинжуулсан эсэх нь тодорхой бус байдаг. Үүнээс шалтгаалан малд халдварт өвчин байх магадлал үүсэж, махны аюулгүй байдал, экспортын шаардлагад нийцэх эсэхэд эргэлзээ төрүүлдэг.* **(Бодлогын гэрээний 3 дугаар зүйлийн 3.1-т Мал төхөөрөх үйлдвэрийн хүчин чадлын хүрээнд гэрээний хугацаанд .... тн .... малын мах, ... тн ..... малын мах экспортолно.**

  МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, БНХАУ-ЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХООРОНДЫН ПРОТОКОЛЫН 5 дугаар зүйлд "… Экспортлох боловсруулсан бүтээгдэхүүнийг боловсруулах аж ахуйн нэгж өөрийн орны болон импортлогч орны холбогдох дүрэм журмын шаардлагыг хангасан байх бөгөөд импортлогч орон өөрийн орны журмын дагуу экспортлогч орны холбогдох аж ахуйн нэгжийг бүртгэх ажлыг хийнэ. Бүртгэгдээгүй аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүнийг импортлогч орон экспортлохгүй" гэж заасан байдаг.)

Хүнсний тухай хуулиар "Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортолно" гэж заасан нь Монгол Улсад л бүртгэлтэй бол экспортын үйл ажиллагаа явуулж болно гэж ойлгогдож байна. Доорх тохиолдлыг харвал, импортлогч улсын зах зээлд рүү хэрхэн орох үйл явцыг мэдэхгүй байгаа тул өнөөдрийн байдлаар гадаад худалдаа эрхлэх эрх бүхий компаниар (ченж) дамжуулан экспорт хийх боломж л байгааг харуулж байна.

- *Олон улсад мах зардаг ченжүүд Иран руу мах оруулахад шаардлагатай бичиг бариmтуудыг мэддэг болохоор дунд нь тоглогч болж ажилладаг. Тэдгээр хүмүүс үйлдвэргүй, агуулахгүй, зүгээр л бичиг баримт бүрдүүлээд Иран руу аваачиж доллар нэмж зардаг. Мал Эмнэлгийн Ерөнхий Газар ченжүүдэд эрх нээж өгөөд, тэд үйлдвэр болж маск зүүгээд гадагшаа гаргадаг нь Монгол Улсын мах экспортлогч аж ахуй нэгжүүдийн боломжийн*

хулгайлж буйн илрэл гэж судалгаанд хамрагдсан байгууллагуудын зүгээс шүүмжилж байна.

- *Махыг үйлдвэрийн бус аргаар бэлтгэж, бойны мах гэж нэрлэгддэг чанар муутай махыг ченжүүдээр дамжуулан гадагшаа гаргаж байна. Харин ХХААХҮЯ-ны зүгээс түс асуудалд тайлбар хийхдээ, Иран Улсын хувьд уян хатан зохицуулалттай буюу заавал үйлдвэрлэгч өөрөө экспорт хийх шаардлагагүй. Үйлдвэрүүдийн хэлээд байгаа "ченж" гэдэг нь "гадаад худалдаа эрхлэх эрх бүхий компани"-ууд юм. Эдгээр компани нь мах экспортлох эрхтэй, гадаад зах зээлтэй гэрээ байгуулсан, зарим тохиолдолд малын махыг үйлдвэр дээр бэлтгүүлээд өөрсдөө гаргаж байгаа аж ахуй нэгжүүд юм. Жишээ нь, мах экспортлогч хувь хүн болон аж ахуй нэгж Иран руу мах нийлүүлэх сонирхолтой боловч тухайн улсын компанитай хэрхэн холбоо тогтоохоо мэдэхгүй байвал ийм зуучлагч компанитай хамтран ажилласнаар Ираны талтай гэрээ байгуулан, экспортын бүх бичиг баримт, тээвэрлэлтийн зохицуулалт хийдэг. Энэ нь Монгол Улсын хуульд харшлах зүйлгүй гэсэн.* **(Хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортолно.)**

Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт, Амьтны эрүүл мэндийн тухай хуульд малын эрүүл мэнд, мах бэлтгэх үйл явц дахь хяналт, шинжилгээнүүдийг дурдаж өгөхдөө малын эмчийн тоог заагаагүй ч дээрх чиг үүргүүдийг тасралтгүй, бүрэн гүйцэтгэхийн тулд олон эмч хэрэгтэй болдог. Үүнийг салбарын мэргэжлийн байгууллагууд "дор хаяж 4–5 малын эмчтэй байх шаардлагатай" гэж практик хэрэгжилт дээр тогтсон стандартаар баримталдаг байна. Гэтэл хөдөө орон нутагт Улаанбаатар хоттой харьцуулахад малын эмчийн хүний нөөц дутагдалтай, нөгөө талаар мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгж нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдгаас тогтмол 4-5 эмчтэй байх боломжгүй байдаг тул дийлэнх тохиолдолд гэрээт малын эмчтэй байдаг байна.

- *Махны үйлдвэрт 4–5 малын эмчтэй байх шаардлага тавигддаг ч энэ нь орон нутгийн нөхцөл байдалд нийцэхгүй тохиолдол цөөнгүй. Махны үйлдвэр нь улирлын чанартай ажилладаг, мөн орон нутагт малын эмчийн тоо хомс, тогтвортой ажиллах боловсон хүчин хангалтгүй байдаг тул үйлдвэрүүд шаардлагыг биелүүлэхэд хүндрэлтэй байдаг. Үүний улмаас зарим үйлдвэрүүд хувийн мал эмнэлэг, эмч нартай түр хугацаанд гэрээгээр*

ажиллаж асуудлыг шийдвэрлэдэг. **(МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ 2.4.2. малын эмч хорио цээрийн хязгаарлалтын үед бэлтгэлийн малд өвчний шинж тэмдэг илрэх, түүнийг эмчлэх, тусгаарлах, устгах, цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн талаар бүртгэл хөтөлсөн байх; 2.4.3. малын эмч бэлтгэлийн мал бүрд эрүүл мэндийн бүртгэл хөтөлсөн байх. МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ 7.5. Мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн дараах шаардлагыг хангасан эсэхийг хянана:**

- **7.5.1.халдварт өвчингүй, тайван бүс, нутагт маллаж байсан эсэх;**
- **7.5.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай дархлаажуулалтад хамрагдсан эсэх;**
- **7.5.3.тухайн мал, амьтанд халдварт өвчний ерөнхий болон өвөрмөц шинж тэмдэг илэрсэн эсэх;**
- **7.5.4.хүнсэнд хэрэглэх мал, амьтанд эм хэрэглэснээс хойших хориглох хугацаа өнгөрсөн эсэх;**
- **7.5.5.энэ хуулийн 7.4.1-д заасны дагуу ялган тэмдэглэгээ, бүртгэл хийгдсэн эсэх)**

4.3.3 Гаалийн улсын байцаагч хяналт шалгалт хийж, бүтээгдэхүүний дээж авах

Гаалийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/275 тушаалаар батлагдсан “Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн нийтлэг журам”-ын 1.1 дэх хэсэгт: "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт, шалгалт хийх үйл ажиллагааны дэс дараалал тогтооход энэ журмын зорилго оршино." (ГЕГ-ын А/275 тушаал, 2019, зүйлийн 1.1)

Энэ журам нь мах экспортлох бүрдүүлэлт хийхэд мөрдөх нарийвчилсан зохицуулалтыг агуулдаг. Мах нь онцгой хяналтад хамрагддаг хүнсний бүтээгдэхүүн тул тусгай протоколын дагуу бүрдүүлэлт хийгддэг.

Гаалийн бүрдүүлэлт хийх процесс

1. Гаалийн мэдүүлэг гаргах: Экспортлогч аж ахуйн нэгж нь гаалийн мэдүүлгийг бичгээр эсвэл цахим хэлбэрээр гаалийн байгууллагад гаргана. Гаалийн мэдүүлэг нь барааг гаалийн хилээр нэвтрүүлэх үндсэн баримт бичиг бөгөөд

гаалийн хяналт, шалгалт хийх, гаалийн үнийг тодорхойлох, татвар хураамжийг ногдуулахад ашиглагдана.

2. Шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх: Мах нь стратегийн хүнс тул холбогдох төрийн захиргааны байгууллагаас тодорхойлолт авсан байна. Стратегийн хүнс гаалийн хилээр нэвтрүүлэх мэдүүлэгч тухайн асуудал хариуцсан яам, засгийн газрын агентлагаас тодорхойлолт авсан байна.
3. Гаалийн хяналт, шалгалт: Гаалийн байгууллага нь мэдүүлсэн барааnd хяналт, шалгалт хийж, шаардлагатай тохиолдолд барааг гаалийн хяналтын бүсэд шалгана. Бараа, тээврийн хэрэгслийн шалгалтыг гаалийн хяналтын бүсэд хийнэ.
4. Гаалийн татвар, хураамжийг төлөх: Шаардлагатай тохиолдолд гаалийн байгууллагаас ногдуулсан татвар, хураамжийг экспортлогч аж ахуйн нэгж төлнө.
5. Гаалийн бүрдүүлэлтийг дуусгах: Бүх шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллага барааг экспортлохыг зөвшөөрч, гаалийн бүрдүүлэлтийг дуусгана. Энэхүү процесс нь Монгол Улсын Гаалийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу явагддаг бөгөөд мах экспортлох үйл ажиллагааг хууль ёсны дагуу, зохион байгуулалттай явуулахад чиглэгддэг.

Асуудал, бэрхшээл

Гаалийн тухай хууль, Тээвэрлэлттэй Холбогдсон Баримт Бичгийг Хэвлүүлэх, Ашиглах Журам, Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар Хоорондын Протоколоор машин бүр дэх мах, махан бүтээгдэхүүнд шинжилгээ хийж, баглах, хадгалах, лацдах шаардлагын тухай зааж өгсөн байдаг. Энэ нь импортлогч улсад очих хүртэлх хугацаанд тээвэрлэгч машинд байгаа бараа бүтээгдэхүүн халдвар авах, аюултай бодисоор бохирдохоос сэргийлдэг байна. Тэгэхээр мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдийн санал болгосноор зөвхөн үйлдвэрийн шалгалт хийх нь аюулгүй байдлыг сулруулах эрсдэлтэй байна гэж харагдлаа.

- *Малын мах, махан бүтээгдэхүүн экспортлогч байгууллагын төлөөллийн зүгээс, нэг үйлдвэрээс гарч байгаа бүтээгдэхүүн учраас нэг л шинжилгээ хийлгээд, машин бүрдээ хувилж өгөхөд хангалттай. Гэтэл гааль дээр мах ачилт хийж байгаа машин бүр дэх махнаас дээж авч, шинжилгээний бичиг шаарддаг. Энэ нь цаг хугацаа, санхүүгийн хувьд хүндрэл учруулдаг гэсэн.*

- *Аймаг, орон нутагт байрладаг үйлдвэрүүд махаа авчраад гаалийн хяналтын хашаанд бүгдийг нь буулгаж, дахин буцааж ачихад хамгийн багадаа 4 хүн 2 өдрийг зарцуулдаг. Угтаа заавал буулгалгүй коридорлож, эсвэл дээгүүр нь шалгах боломжтой. Эсвэл үйлдвэр дээр ачилт хийх явцад мал эмнэлгийн төлөөлөгч болон ГЕГ-ын төлөөлөгч протокол үйлдэж шалгалт хийх боломжтой. Харин Гаалийн Ерөнхий газрын төлөөлөл үүнд тайлбар хийхдээ, хилээр нэвтэрч байгаа бүх бараа бүрийг шалгах үүрэгтэй. Учир нь машин бүрийг шалгаагүйгээс болж ямар нэг эрсдэл гарвал Гаалийн Ерөнхий газар хариуцлага хүлээдэг бөгөөд энэ нь Монгол Улсын нэр хүнд, цаашлаад олон улсын түвшин дэх эдийн засгийн нөхцөл байдалд томоохон хохирол учруулах эрсдэлтэй байдаг гэсэн.* **(ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 10 дугаар зүйлийн 232.3. Гаалийн хяналтад байгаа барааг ачих, буулгах, задлах, сав, баглаа боодлыг өөрчлөх, тээврийн хэрэгслийг хөдөлгөхийг гагцхүү гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.**

БАРААНААС СОРЬЦ, ДЭЭЖ, ЗАГВАР АВАХ, МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРМЫН 1.2. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт хийх явцад мал, амьтны гоц халдварт өвчин болон ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлыг гаалийн хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах, мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах бараанд гаалийн зорилгоор барааны ангиллын кодыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээ хийнэ. ТЭЭВЭРЛЭЛТТЭЙ ХОЛБОГДСОН БАРИМТ БИЧГИЙГ ХЭВЛҮҮЛЭХ, АШИГЛАХ ЖУРМЫН 2 дугаар зүйлийн 2.12.Улс хоорондын болон дамжин өнгөрөх тээвэрлэлтийн үйл ажиллагаанд автотээврийн харилцааны талаар олон улсын гэрээ хэлэлцээрээр харилцан тохиролцсон тээвэрлэлтийн баримт бичгийг ашиглана.

2.13. Замын хуудас нь цахим хэлбэртэй, холбогдох мэдээллийг агуулсан QR код байх бөгөөд зорчигч(хавсралт 1) ачаа(хавсралт 6), тээврийн гэсэн төрөлтэй байна.

2.14. Замын хуудаст:

2.14.1. автотээврийн хэрэгслийн марк, улсын дугаар

2.14.2. замын хуудас олгосон тээвэрлэгчийн нэр, тэмдэг

2.14.3. ачааны нэр,төрөл, зэрэглэл, тоо, жин

2.14.4. жолоочийн талаарх мэдээлэл

2.14.5. хяналтын бүртгэл

2.14.6. эмчийн үзлэгийн тэмдэглэл,

2.14.7. ажилд гарсан, ажлаас буусан цаг, мин

2.14.8. ачаатай, сул болон нийт гүйлт

2.14.9. тээвэрлэлтийн чиглэл, зай, аяллын дугаар

2.14.10. техникийн байдлыг шалгаж ажилд гаргахыг зөвшөөрсөн албан тушаалтан

2.14.11. Ажилд гарахыг зөвшөөрсөн жолоочийн гарын үсэг

2.14.12. хяналт шалгалтын тэмдэглэл зэргийг багтаах бөгөөд тээвэрлэлтийн төрлөөс хамааран дээрх мэдээллүүдийг агуулсан QR код байна.)

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, БНХАУ-ЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХООРОНДЫН ПРОТОКОЛЫН 10 дугаар зүйлд "Барааг контейнерт ачсаны дараа экспортлогч орны албан есны малын их эмчийн хяналтын дор лацдаж, лацны дугаарыг барааны гэрчилгээнд заасан байна. Тээвэрлэлтийн явцад лацыг онгилгож, баглааг солихгүй" гэж заасан байдаг.)

- *Гаалийн тухай хуулиар ажлын 3 өдөрт багтаан мэдээлэл өгөх үүрэгтэй байдаг бол мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн зүгээс үүнээс богино хугацаанд буюу 1-ээс 2 хоногт багтааж хурдан хариу авахыг хүсдэг байна.*
- *Улаанбаатар хотын гааль дээр байцаагч томилуулах хүсэлт явуулахад ямар байцаагч томилогдсон тухай мэдээлэл ирэхгүй алга болдог учир өөрөө 1-ээс 2 хоног утсаар ярьж, хөөцөлдөж байж мэдэж авдаг.* ***(ГААЛИЙН ТУХАЙ Хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 10.1-д заасан гаалийн байгууллага, албан тушаалтан хүссэн мэдээллийг нь нэн даруй хэрэв ийнхүү өгөх боломжгүй бол ажлын 3 өдөрт багтаан иргэн, хуулийн этгээдэд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр өгөх үүрэгтэй" гэж заасан.)***
- *Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт баримт бичигт ".....савласан мах, хагас болон бүрэн боловсруулсан махан бүтээгдэхүүнийг (0-4)С температурт зориулалтын эргэлтийн сагсанд хийж өрсөн байдлаар.... зориулалтын тээврийн*

хэрэгслээр тээвэрлэх” гэж заасан байдаг. Гэтэл хатаасан мах экспортоор гаргадаг аж ахуй нэгжийн зүгээс энэхүү стандартыг бариимтлах шаардлагагүй гэж үзэж байна.

- *Хатаасан мах зэрэг дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүн нь удаан хадгалагдах боломжтой бөгөөд тусгай хөргүүртэй машин шаардлагагүй. Гэтэл хил дээр заавал хөргүүртэй тээврийн хэрэгсэл шаарддаг нь зохицуулалт, стандартын ойлгомжгүй байдлыг харуулж байна.***(Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт баримт бичгийн, 4 дүгээр зүйл, 4.16.5. хөргөсөн гулууз махыг (0-4)С температурт өлгөсөн байдлаар, савласан мах, хагас болон бүрэн боловсруулсан махан бүтээгдэхүүнийг (0-4)С температурт зориулалтын эргэлтийн сагсанд хийж өрсөн байдлаар, хөлдөөсөн гулууз махыг -180С температурт өрсөн байдлаар зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх.)**

4.3.4 Гарал үүслийн гэрчилгээ

МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирлын А/39 тоот тушаалаар “Монгол улсаас гарал үүсэлтэй экспортын барааанд гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журамд” зааснаар Экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гэрчилгээг Монгол улсын олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээрт заасан нөхцөл, журмыг баримтлан гэрчилнэ хэмжээ тогтоосон акт зэргийг удирдлага болон экспортлогчийн хүсэлтийг үндэслэн холбогдох аргачлалыг ашиглан дараах тохиолдолд олгоно” гэсэн байдаг.

БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор зөвшөөрөгдсөн бүс нутаг болох Монгол Улсаас гарал үүсэлтэй болохыг баталсан гэрчилгээг авах. Өөрөөр хэлбэл, БНХАУ-д HS 0201, 0202 болон 1602 код бүхий бүтээгдэхүүнийг импортлох шаардлагын дагуу тухайн бүтээгдэхүүн Монгол Улсад үйлдвэрлэгдсэн гэдгийг экспортлогч баталгаажуулах ёстой. Үүний тулд МҮХАҮТ-аас гарал үүслийн гэрчилгээ авна. Энэхүү гэрчилгээг авахад дараах шаардагдах баримт бичгийг бүрдүүлдэг. (Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн, 2022).

- УБГ-ний хуулбар Өргөдлийн маягт бөглөх
- Гадаад худалдааны гэрээний хуулбар
- Үнийн нэхэмжлэх, сав баглаа боодлын жагсаалт

- Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл, чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар
- Өргөдөл бөглөх (Form B)

4.3.5 Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ

МЭЕГ-ын даргын 2021 оны А/67 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.5-д зааснаар “Мал эмнэлгийн гэрчилгээг олгохдоо бүртгэл хөтлөх бөгөөд нэгдсэн мэдээллийн санд оруулна. Шаардлагатай тохиолдолд мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд сум дүүргийн мал, мах бэлтгэх, боловсруулах үйлдвэр, хүнсний зах, худалдааны төвийн хөндлөнгийн болон бусад эрх бүхий итгэмжлэгдсэн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн дотоодын болон олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгоно:” гэсэн байдаг.

Экспортлогч нь МЭЕГ-аас мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авна. Энэхүү гэрчилгээ нь эрүүл мэнд, мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна. Энэхүү гэрчилгээг авахад экспортлогч нь албан хүсэлтийг дараах бичиг баримтын хамт бүрдүүлж, МЭЕГ-т өгнө. (Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн, 2022).

- УБГ-ний хуулбар;
- Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг;
- Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалт, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл;
- Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт;
- Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа;
- Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил.

Асуудал, бэрхшээл

Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад Монгол улсад итгэмжлэгдсэн лаборатори нэг л байдаг учраас хугацаа ордог. Нөгөөтэйгүүр гадаад орнууд (Жишээ нь: Хятад, Япон, Иран) Монголын шинжилгээний хариуг бүрэн хүлээн зөвшөөрдөггүй тул аль улс руу мах экспорлох гэж байгаатай уялдуулан Монгол Улсад заавал шинжилгээ хийх эсэх дээр уян хатан зохицуулалт хийх, экспортлосон мах ариун цэврийн шаардлага хангагүй тохиолдолд МЭЕГ өөрийн үүргийн хүрээнд бүх аж ахуй нэгжийн эрх ашгийг эрх тэгш хангахад анхаарч ажиллах шаардлагатай байна. Тодруулбал,

- *Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад Монгол Улсад итгэмжлэгдсэн лаборатори нэг л байдаг учраас хугацаа маш их ордог.* **(МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР, ХЭРЭГЛЭХ ЗААВАР, 3 дугаар зүйл, 3.6. Мал эмнэлгийн байгууллага нь гэрчилгээг олгох, хэрэглэх, хяналт тавихдаа аль болох хүндрэл учруулахгүй, шуурхай байх бөгөөд мэдээлэл нь үнэн зөв, бодитой байна .Гэрчилгээ олгогдсон мал, амьтны тоо жилийн эцсийн мал тооллогын дүнтэй тохирч байх.)**

Хүнсний тухай хуулиар шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагын итгэмжлэл байж болно. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтад импортлогч орны эрх бүхий байгууллагатай байгуулсан мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хэлэлцээрт заасныг харгалзана гэж заасан байдаг. Мөн БНХАУ бол зөвхөн өөрийн орны журмын дагуу бүртгэгдсэн аж ахуй нэгжээс л импортоор мах, махан бүтээгдэхүүн авдаг зэрэг улс орны онцлогоос шалтгаалсан зохицуулалтууд байгаа ч Монгол Улсын зүгээс итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ хийдэг нь гадаад харилцаа, аюулгүй байдлын хувьд давхар хамгаалалт болж өгдөг байна.

- *Монгол Улсад хийгдсэн лабораторийн шинжилгээний хариуг Хятад, Япон, Иран зэрэг улс орнууд бүрэн хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол бий. Тэдгээр улс өөрийн улсын итгэмжлэгдсэн лабораторид дахин шинжилгээ хийж баталгаажуулсны үндсэн дээр л махыг хүлээн авдаг. Тийм учраас Монгол Улсын шинжилгээний хариуг хүлээн зөвшөөрдөггүй улс руу экспорт хийх тохиолдолд заавал Монгол Улсад шинжилгээ хийлгэх шаардлагагүй нөхцөл байдал үүсэж байгаа тул аль улс руу мах нийлүүлэх гэж байгаагаас шалгаалан уян хатан зохицуулалт хийх хэрэгтэй.*

- *Хоёр жилийн өмнө Иранд экспортолсон махнаас микроб илэрч, ариун цэврийн шаардлага хангаагүй гэсэн асуудал гарсан. Үүнээс болж Ираны Мал Эмнэлгийнхэн Монгол Улсад ирж үйлдвэрүүдийг өөрсдөө шалгахаар болсон. Гэтэл Монголын МЭЕГ зөвхөн Улаанбаатар хоттой ойр үйлдвэрүүдийг шалгуулаад бусдыг нь огт үзүүлээгүй. Үүнээс болж орон нутгийн үйлдвэрүүд зөвшөөрөл авч чадаагүйгээс эрх ашиг нь зөрчигдсөн. Үүнд холбогдох албан тушаалтан "Иран Улсын зүгээс тухайн үед МЭЕГ-т мэдэгдэл өгөлгүй ирж, хяналт шалгалт хийгээд буцсан байсан" гэж тайлбар өгсөн.* **(ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН, 5[1] дүгээр зүйл болох Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмын 5[1].7.5-д сонгон шалгаруулалтад орох хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичиг "шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагын итгэмжлэл" байна гэж заасан байдаг.**

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, БНХАУ-ЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХООРОНДЫН ПРОТОКОЛЫН 5 дугаар зүйлд "… Экспортлох боловсруулсан бүтээгдэхүүнийг боловсруулах аж ахуйн нэгж өөрийн орны болон импортлогч орны холбогдох дүрэм журмын шаардлагыг хангасан байх бөгөөд импортлогч орон өөрийн орны журмын дагуу экспортлогч орны холбогдох аж ахуйн нэгжийг бүртгэх ажлыг хийнэ. Бүртгэгдээгүй аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүнийг импортлогч орон экспортлохгүй" гэж заасан байдаг.

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН 3.3.8-д мал эмнэлгийн улсын байцаагч шаардсан тохиолдолд угаах хашаанд газрын түвшнээс доош суулгасан мал гатлах ванн, эсхүл угаалгын шүршүүрийг суурилуулж, малын арьсанд наалдсан бохирдлыг угаасан байх; Тайлбар: Экспортын зориулалтаар мах бэлтгэх үед импортлогч орны эрх бүхий байгууллагатай байгуулсан мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хэлэлцээрт заасныг харгалзана.)

4.3.6 Бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд өгч, дүгнэлт гаргуулах

Монгол Улсаас мах экспортлох үйл ажиллагаанд Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори (УМЭАЦТЛ)-ийн оролцоо нь хууль, журмын дагуу тодорхойлогдсон, зохион байгуулалттай, шинжлэх ухаанд үндэслэсэн процесс юм. Энэхүү лаборатори нь экспортлох мах болон махан бүтээгдэхүүний мал эмнэлэг-эрүүл ахуйн магадлан шинжилгээ, үлдэгдлийн (антибиотик, нянгийн эсэргүүцэл гэх мэт) шинжилгээ, сорил, баталгаажуулалт зэрэг үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэдэг. Тус лабораторийн эрх зүйн үндэс нь “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-д тодорхой тусгагдсан бөгөөд уг хуулийн 29.3-т “Мал эмнэлгийн лаборатори нь мал, амьтны өвчний оношилгоо, тандалт, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ, сорил, баталгаажуулалт хийх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг (Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, 2017, зүйлийн 29.3). Энэ заалт нь мах экспортлох бүтээгдэхүүний аюулгүй байдал, гарал үүслийг шинжилгээний үндэслэлтэйгээр баталгаажуулж, олон улсын зах зээлд тавигдах стандартын шаардлагыг хангах үндсэн нөхцөл болдог.

Мөн Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журамд УМЭАЦТЛ-ийн чиг үүргийг тодорхой заасан ба “Сүлжээ лабораторийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэгдсэн удирдлагаар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори мэргэжил, арга зүйгээр тус тус хангаж ажиллана” гэж тусгасан байна (Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам, 2021, зүйлийн 2.4). Мөн уг журмын 3.5-д “Оношилгоо, тандалт, магадлан шинжилгээ, сорил, баталгаажуулалтын үр дүнгийн үнэн зөвийг шинжилгээ хийсэн лаборатори бүрэн хариуцаж, хараат бусаар ажиллана” хэмээн зааснаар шинжилгээний үр дүнгийн баталгаат байдал нь хуульчлагдсан байдаг.

Лабораторийн шинжилгээгээр дамжин олгогдож буй нотолгоо нь экспортын мал эмнэлгийн гэрчилгээ олгох үндсэн баримт болдог. УМЭАЦТЛ нь мөн Монгол Улсын стандарт болох MNS ISO/IEC 17025:2018-ийн шаардлагын дагуу итгэмжлэгдсэн бөгөөд энэ нь тус лабораторийн шинжилгээ, дүгнэлтийн үр дүн нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүрсэн болохыг нотолно. Мал эмнэлгийн ерөнхий газрын 2024 оны мэдээллээр тус лаборатори нь 9 дэх удаагаа амжилттайгаар итгэмжлэлийн магадлан үнэлгээнд хамрагдаж, олон улсын шаардлагыг хангаж байгааг баталгаажуулсан (Мал эмнэлгийн ерөнхий газар, 2024).

Энэ бүхэн нь Монгол Улсаас мах экспортлох үйл ажиллагаа нь мэргэжлийн, шинжлэх ухааны үндэслэлтэй, итгэмжлэгдсэн лабораторийн хяналтаар баталгаажиж, олон улсын зах зээлд гарах бүрэн боломжтойг илэрхийлж байна.

ГУБ-ын томилсон байцаагчийн авсан дээжид шинжилгээ хийж дүгнэлт гаргана.

Шилжилгээний процесс

1. Дээж хүлээн авах: Экспортлогч байгууллага нь мах, махан бүтээгдэхүүний дээжийг УМЭАЦТЛ-д хүргүүлнэ. Лаборатори нь дээжийг хүлээн авч, холбогдох бүртгэл мэдээллийг бүрдүүлнэ.
2. Шинжилгээ хийх: Хүлээн авсан дээжид мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, эмийн үлдэгдлийн шинжилгээ, сорил, баталгаажуулалт зэрэг шинжилгээг гүйцэтгэнэ. Энэ үйл ажиллагаа нь "Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам"-ын 5.1.2-т заасны дагуу явагдана.
3. Шинжилгээний үр дүн гарга: Шинжилгээний үр дүнг боловсруулахдаа лаборатори нь үнэн зөв, хараат бус байдлыг хангаж ажиллана. Энэ нь мөн дээрх журмын 3.5-д тусгагдсан байдаг.
4. Гэрчилгээ олгох: Шинжилгээний үр дүн эерэг, шаардлага хангасан тохиолдолд УМЭАЦТЛ нь экспортлогчид мал эмнэлгийн гэрчилгээ олгоно. Энэ гэрчилгээ нь бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлыг баталгаажуулж, олон улсын худалдаанд шаардлагатай баримт бичиг болдог.

Асуудал, бэрхшээл

“Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам”-д зөвхөн шинжилгээг үнэн зөв, хараат бусаар, стандартын дагуу гүйцэтгэх үүргийг тусгасан байдаг ч лабораторийн шинжилгээний хариу гарах хугацааны талаар нарийвчлан заагаагүй байна. Харин мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжийн хувьд дээрх зохицуулалтаас үүдэн зарим тохиолдолд 3-аас дээш хоногийн дараа шинжилгээний хариу гарснаар тээврийн хэрэгслийн хүлээлт уртсаж, хадгалалтын болон зогсолтын зардал нэмэгдэн, цаг хугацаа болон эдийн засгийн хувьд дарамт учирдаг байна.

- *Экспортлогч аж ахуй нэгж нь импортоор авч буй улсын тээвэрлэгч компанийн тээврийн хэрэгслийг захиалсан байдаг. Лабораторийн шинжилгээний хариу зарим тохиолдолд 3-аас дээш хоног үргэлжилснээр, тээвэрлэлтийн автомашин удаан хугацаагаар хүлээгдэж, хадгалалт, зогсолтын төлбөр нэмэгдэхэд хүрдэг. Үр дүнд нь экспортлогч*

байгууллагаас нэмэлт зардал гарч, эдийн засгийн хүндрэл үүсэх эрсдэл үүсдэг.

- *Нойтон мах экспортлох тохиолдолд ихэвчлэн агаарын тээврээр (онгоцоор) тээвэрлэдэг. Учир нь энэ төрлийн мах хурдан муудах эрсдэлтэй тул 24-48 цагийн дотор хүргэх шаардлагатай байдаг. Гэвч шинжилгээ, бичиг бариmтын бүрдүүлэлт зэрэг үйл явц удааширвал хугацаа алдах эрсдэл нэмэгдэж, махны чанар алдагдах, экспорт цуцлагдах зэрэг хохирол гардаг.*

  “Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам” 5 дугаар зүйлийн 5.1.3: “Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн шинжилгээгээр сэжигтэй болон эерэг үр дүн үзүүлсэн сорьцыг тухай бүр шинжлэн баталгаажуулах, шинжилгээний хариуг шуурхай хүргүүлэх.”

Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтаар “.....төвлөрсөн бус хангамжтай бол улиралд 1 удаа итгэмжлэгдсэн лабораторийң шинжилгээнд хамруулах.....” гэж заасан ч аймаг, орон нутагт байдаг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн зүгээс холоос ус шинжлүүлэх зорилгоор зөөвөрлөхийг бэрхшээлтэй гэж үзэж Улаанбаатар хотоос цэвэр ус авч шинжлүүлэх байдал үүсдэг байна.

- *Үйлдвэрт анхан шатны бүтээгдэхүүний шинжилгээ хийдэг мини лаборатори байдаг. 7 хоног бүр бид усаа шинжилдэг. Гэвч улирал бүр усаа Улаанбаатарт шинжлүүлэх ёстой гэдэг. Манай үйлдвэр Завхан аймагт байдаг. Завхан аймгаас Улаанбаатар хот руу усаа зөөхөд ус чанараа алддаг. Онгоцоор тээвэрлэхэд зардал өндөр. Амьдрал дээр хэрэгжих боломжгүй ийм шаардлагууд байдаг, бүр сүүлдээ бид нар хотоос цэвэр ус худалдаж авч шинжилгээ өгөх нь холгүй л байна.*
- *Монгол Улсын хэмжээнд дор хаяж гурван бүсэд итгэмжлэгдсэн лабораторитой болох нь нэн шаардлагатай. Ингэснээр бүс нутгуудад үүсдэг тээвэрлэлтийн хүндрэл, цаг хугацааны алдагдлыг бууруулах, лабораторийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах боломжтой. Мөн шинжилгээний хариуг илүү хурдан хугацаанд гаргах нөхцөл бүрдэж, экспортын үйл явц саадгүй, шуурхай явагдана*. <u>*Тэгвэл, МЭЕГ-ын төлөөлөл энэ асуудлыг тайлбарлахдаа, аймаг, орон нутаг бүрд итгэмжлэгдсэн лаборатори байгуулахад асар их зардал, төсөв мөнгө шаардана. Байгууллаа гэхэд тогтмол шинжилгээ хийх шаардлага тэр*</u>

бүр гардаггүй түл байнгын үйл ажиллагаатай байж чадахгүй гэж үзэж байна.

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН 3.10.4-д "технологийн зориулалтаар хэрэглэх ус нь "MNS 0900 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" стандартын шаардлагыг хангасан байх ба төвлөрсөн хангамжийн усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг жилд 2 удаа, төвлөрсөн бус хангамжтай бол улиралд 1 удаа итгэмжлэгдсэн лабораторийң шинжилгээнд хамруулж, шаардлагатай тохиолдолд ус цэвэршүүлэх тоног, төхөөрөмж суурилуулж, ашиглах" гэж заасан байдаг.

4.3.7 Тохирлын гэрчилгээ

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 14.3 зааснаар "Тохирлын гэрчилгээг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага олгоно" гэсэн байдаг.

Стандарт, Хэмжил Зүйн Газраас экспортлогч нь тохирлын гэрчилгээ авах ба энэхүү гэрчилгээ нь экспортод гаргах бүтээгдэхүүн нь холбогдох стандартуудын дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна. (Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн, 2022).

- УБГ-ний хуулбар (баталгаажсан);
- Өргөдлийн маягт бөглөх (masm.gov.mn);
- Худалдах, худалдан авах гэрээ;
- Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг;
- Бүтээгдэхүүний сорилт, туршилт хийгдсэн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн;
- Мэргэжлийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл (шаардлагатай тохиолдолд);
- Үйлчилгээний төлбөр тушаасан баримтын хувь.

Асуудал, бэрхшээл

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар "Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсад болон Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ,

хэлэлцээрээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна” гэж заасан байдаг ч Стандарт хэмжилзүйн газраас гаргасан гэрчилгээ нь олон улсад үнэлэгдэхгүй байх тохиолдол гарсан нь мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдэд итгэл үнэмшилгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

- *Стандарт хэмжилзүйн газраас гаргадаг гэрчилгээнүүдээ олон улсын хэмжээний болгох хэрэгтэй байна. Эндээс авсан гэрчилгээг олон улсад үнэлэхгүй байх асуудал бас гардаг.*
- *Стандарт, хэмжил зүйн газраас (СХЗГ) олгодог гэрчилгээг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар гаргадаг болгох шаардлагатай. Учир нь зарим улс орон Монгол Улсаас олгосон гэрчилгээг бүрэн үнэлдэггүй. СХЗГ-ын итгэмжлэлийн тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгож, гадаадын зах зээл дээр Монголын гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг шууд хүлээн зөвшөөрөх боломжийг бүрдүүлэх нь чухал юм.*

  СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 4 дүгээр зүйлийн 14.4.Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсад болон Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна.

4.3.8 Гаалийн бүрдүүлэлт хийх

Гаалийн тухай хуулийн Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах бичиг баримтын 60 дугаар зүйл. Бараа мэдүүлэхэд шаардагдах бусад бичиг баримтад :

1. Мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор дараах бичиг баримтыг гаалийн байгууллагад өгнө:
   гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх;
2. Тээврийн бичиг баримт;
3. Тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз;
4. Хуульд заасан бичиг баримт;
5. Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг гэж заасан байдаг.

4.3.9 Тээвэрлэлт

БНХАУ-руу мах, махан бүтээгдэхүүн экспортлогчид нь ихэвчлэн авто замын тээврийг ашиглаж байна. Тээвэрлэлтийг хөргүүртэй, чингэлэгтэй, гаалийн итгэмжлэгдсэн тээврийн хэрэгслээр хийнэ. (Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн, 2022).

1. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ
2. Ачаа тээврийн бичиг баримт
3. Гадаад худалдааны гэрээ
4. Төлбөрийн баримт
5. Үнийн нэхэмжлэх
6. Баглаа боодлын жагсаалт
7. Даатгалын бичиг баримт
8. ХХААХҮЯ-ны стратегийн хүнс экспортлох зөвшөөрлийн албан бичиг
9. МХЕГ-аас олгосон мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээ
10. Шинжилгээний бичиг
11. Ачаа тээврийн дагалдах хуудас
12. Ачааны манифест
13. Гаалийн ерөнхий газрын даргын 2011 оны 256 р тушаалын 4 болон 5-р хавсралтыг үндэслэж, ачааны манифестыг бүрдүүлнэ.

Асуудал, бэрхшээл

Гаалийн тухай хуулиар “Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий **хилийн боомтоор** нэвтрүүлнэ” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл гаалийн байгууллагагүй боомтоор нэвтрэх боломжгүй гэсэн үг. Гэтэл мах, махан бүтээгдэхүүн экспортлогчид орон нутагтайгаа ойр хилийн боомтоор бүтээгдэхүүнээ гаргах боломжтой болвол тээвэрлэлтийн зардал, хугацаа багасч, эдийн засгийн үр ашиг нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

Мал мах махан бүт экпортлоход бооmтуудыг заасан 2003 оны 173-р тогтоол байдаг. Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжийн байрладаг орон нутагтай ойр бооmтуудаар мах экспортлох боломж нээлттэй байдаг бол цаг хугацаа, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй гэж судалгаанд оролцогчдын зүгээс үзэж байна. **“ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7 дугаар зүйл 7.1-т “Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүхий хилийн боомтоор нэвтрүүлнэ. 7.2. Энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хилийн**

боомтоор бараа, тээврийн хэрэгслийг Гаалийн удирдах төв байгууллагын зөвшөөрөлтэйгөөр нэвтрүүлж болно” гэж заасан байдаг.

4.3.10 Хил дээр гаальд бүртгүүлэх, гадна үзлэг хийлгэх

Асуудал, бэрхшээл

Хил дээр гаальд бүртгүүлэх, гадна үзлэг хийлгэх, экспортын бүх бичиг баримтыг шалгах явцад Гаалийн хяналтын байцаагч нарын харилцаа, шийдвэр гаргалт, хувийн хандлагаас удаашрах, зарим үед маргалдаж бараагаа буцаалгах тохиолдол гардаг байна. Гаалийн тухай хуулиар аж ахуй нэгжийн зүгээс хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхтэй байдаг. Гэвч гомдол гаргахаас илүүтэй хурдан асуудлыг шийдвэрлэхийн тулд хуулиар гадуурх арга хэмжээ авах тохиолдол түгээмэл байдаг аж.

- *Тухайн байцаагч нарын харилцааны асуудал байдаг. Дуртай байвал явуулчихна, дургүй байвал бараа буцаачихдаг. Хэрвээ гаалийн ажилтантай маргалдах юм бол бараагаа буцаалгах тохиолдлууд гардаг.*
- *Замын-Үүд дээр хяналтын байцаагч экспортын бүх бичиг бариmтыг шалгаад хүлээн зөвшөөрсөн ч ямар нэг шалтгаан хайж удаашруулдаг. Үүний улмаас 400-500 кг бүтээгдэхүүн хил дээр саатаж, бүр хоёр хилийн голд гацаагдаж байсан тохиолдол гарсан.* **(ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 16 дугаар зүйлийн 16.1-т “Мэдүүлэгч нь өөрийнхөө эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдсөн гэж үзвэл гаалийн байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах эрхтэй.”)**

4.4 Мах экспортлогч аж ахуй нэгжийн зүгээс ирсэн санал

1. *БНХАУ өөрийн нутаг дэвсгэрээр мах экспортын тээвэр дамжин өнгөрөхийг одоогоор зөвшөөрдөггүй. Тус хязгаарлалтыг цаашид зөөлрүүлж, дамжин өнгөрөх боломжтой болгох нь манай экспортлогчдын хувьд тээвэрлэлтийн маршрут илүү үр ашигтай болж, зардал багасч, эдийн засагт мэдэгдэхүйц хэмнэлт үзүүлэх боломжтой.* **“Тээврийн ерөнхий хууль” 14 дүгээр зүйл 14.6.1: дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зөвхөн хэлэлцэн тохирогч талуудтай, тохиролцсон чиглэл, маршрут, боомтоор зохион байгуулна.**
2. *Жижиг үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн төрийн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй. Учир нь Монгол Улсын нөхцөлөөс шалтгаалан махны экспорт тогтмол биш байдаг тул орлого тасалдаж, үйлдвэрүүд тогтвортой үйл*

ажиллагаа явуулах боломжгүйд хүрдэг. Эргэлтийн хөрөнгийн дэмжлэг нь эдгээр үйлдвэрүүдийн тогтвортой байдлыг хангах чухал арга хэмжээ юм. **“Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль” 11 дүгээр зүйл 11.1: Төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. 11.6: Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих сангаас олгох зээлийн хэмжээ нь тухайн аж ахуйн нэгжийн сүүлийн жилийн борлуулалтын орлогоос хамаарна. 11.7: Зээлийг шууд болон арилжааны банкаар дамжуулан олгоно.**

3. *Монгол Улсын нөхцөл байдлаас шалтгаалж махны экспортын үйлдвэрүүд байнгын үйл ажиллагаа явуулж чаддаггүй тул ажилчдаа тогтвортой ажлын байраар хангах боломж хомс байдаг. Иймээс төрөөс эргэлтийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэх нь үйлдвэрүүдийн тогтвортой байдалд чухал нөлөөтэй.* **“Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль” 4 дүгээр зүйл 4.1.3: ажлын байрыг нэмэгдүүлэх, хадгалах, үйлдвэрлэл, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх**
4. *Одоогоор малын толгой, шийр зэрэг дайвар бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд экспортлох боломж хязгаарлагдмал байна. Үүний улмаас дийлэнх дайвар бүтээгдэхүүн шууд хаягдаж, устгалд орж, эдийн засгийн ямар ч өгөөжгүй болж байна. Гэтэл эдгээр бүтээгдэхүүн нь зөв боловсруулж, стандартын дагуу бэлтгэвэл хүнс, эм, гоо сайхан, малын тэжээл зэрэг олон салбарт ашиглагдах үнэт нөөц юм. Иймд дайвар бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулж, боловсруулах, дотоодын болон гадаад зах зээлд гаргах бодлогын дэмжлэг шаардлагатай байна.* **“Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль” 8 дугаар зүйл 8.1.7: Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих 8.1.8: Техник, технологийн дэвшлийг нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх**
5. *Махны бирж одоогоор бүрэн хэмжээнд үйл ажиллагаа явуулж чадахгүй байна. Хэрэв малчид малаа ченж бус, биржээр дамжуулан борлуулбал аж ахуйн нэгжүүд илүү хямд, тогтвортой үнээр мах худалдан авах нөхцөл бүрдэнэ. “***Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль” 1 дүгээр зүйл 1.1: ...биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн**

гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

6. *Хэрэв Монгол Улс фермийн аж ахуйн тогтолцоог хөгжүүлж, эсвэл малчдын малаа бэлчээх тодорхой бүс нутагт төвлөрүүлэн зохион байгуулж өсгөвөл экспортын тогтвортой байдлыг хангах боломжтой. Ингэснээр малын гаралтай бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналт сайжирч, вакцинжуулалт, тандалт, мал эмнэлгийн үйлчилгээ илүү үр дүнтэй болох нөхцөл бүрдэнэ.*

Тав. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ

Монгол Улс нь мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжих бодлогын хүрээнд олон хууль тогтоомжийг баталсан ч тодорхой хэдэн хууль тогтоомжийн зүйл, заалтууд хоорондоо давхардсан байгаа бөгөөд судалгааны хүрээнд ”Хүнсний тухай”, ”Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх нөлөөллийг бууруулах тухай“ Монгол Улсын 2 хууль, ”Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай“ 1 Улсын Их Хурлын тогтоол, ”Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох тухай”, ”Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай“ Засгийн газрын 2 тогтоол, ”Шинэ сэргэлтийн бодлого“ 1 Засгийн газрын төлөвлөгөө, нийт 6 хууль тогтоомж, 3 удаа давхардсан байна.

Хүснэгт 9. Мах, махан бүтээгдэхүүний экспорттой холбоотой хууль тогтоомжийн давхардал

№	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн заалт	Батлагдсан он	Дүгнэлт	Шийдлийн төсөл
1	Монгол Улсын хууль	Хүнсний тухай	3.1.6."стратегийн хүнс" гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг;	2024	Уг хуулиудыг харьцуулан субсумбци дүгнэлт гаргавал агуулгын хувьд хуулбарласан шинжтэй байна. Эдгээр хуулиудаар гол нэр төрлийн бүтээгдэхүүн, стратегийн бүтээгдэхүүн гэдгийг тус тусад нь ялгаж салгаагүй бөгөөд эрх зүйг тайлбарлах логик аргаар дүгнэвэл аль аль нь Монгол Улсын стратегийн болоод иргэдийн өдөр тутамдаа хэрэглэгддэг гэсэн агуулгыг ойлгож болохоор байна.	Монгол Улсын хууль тогтоомжийн жишгээс харвал "… хуулийн … дугаар зүйлийн …. дахь /дэх/ хэсэгт заасныг ойлгоно." гэж тусгадаг. Жишээлбэл, Гол нэр төрлийн зарим, бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх нөлөөллийг бууруулах тухай хуульд гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүнд Хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6. дахь хэсэгт заасныг ойлгоно" эсхүл тухайн хуулиудаар стратегийн хүнс болон гол
	Монгол Улсын хууль	Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх нөлөөллийг бууруулах тухай	3.2. Энэ хуулийн 3.1-д заасан гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүнд дараах бараа, бүтээгдэхүүн: 3.2.3. мах	2017		

						нэр төрлийн бараа бүтээгдэхүүний ялгааг тусгах гэх мэт.
2	Монгол Улсын хууль	Хүнсний тухай	51.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг нэр төрлөөс нь хамааруулан дараах хугацаанд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд цахимаар хүргүүлнэ: 51.1.2.малын махны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны дотор;	2024	Хэл зүйн хувьд шууд хуулбарласан шинжтэй байна.	Монгол Улсын хууль тогтоомжийн жишгээс харвал "… хуулийн … дугаар зүйлийн …. дахь /дэх/ хэсэгт заасныг ойлгоно." гэж тусгадаг. Жишээлбэл, Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох тухай журамд Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хүнсний тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт заасныг ойлгоно" гэх мэт.
	Засгийн газрын тогтоол	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам	2.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх) тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг нэр төрлөөс нь хамааруулан дараах хугацаанд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-д цахимаар хүргүүлнэ: 2.2.1. сүүний тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор;	2019		

3	УИХ-ын тогтоол	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай	1/Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр: в/малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, **нэмүү өртөг шингэсэн болон эцсийн бүтээгдэхүүн** үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх; .... 3/Үйлдвэрлэл, борлуулалт, **экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх чиглэлээр**: з/малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг газар зүйн заалтаар тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, **нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих** зорилгоор Монгол Улсад бүртгэгдсэн газар зүйн заалттай бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын газар зүйн заалтад бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх.	2024	УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын төлөвлөгөө нь нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүнийг эцэслэн үйлдвэрлэж, экспортыг нэмэгдүүлэх гэсэн утга санааг давхардуулсан байх ту агуулгын хувьд давхардуулсан гэж үзэхээр байна.	Монгол Улсын Их Хурлын тогтоолоор мах, махан бүтэгдэхүүний экспортыг дэмжих бодлогыг тодорхойлсон бөгөөд Засгийн газрын тогтоол болон төлөвлөгөөгөөр мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжих арга зам, процессын асуудлыг дэлгэрэнгүй байдлаар тусгавал илүү зохимжтой бөгөөд зорилтыг хэрэгжүүлэхэд илүү дэмтэй болов уу.
	Засгийн газрын тогтоол	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	5. Мал төхөөрөх, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр, цехийн хүчин чадлын ашиглалт, боловсруулалтын түвшнийг сайжруулах замаар **нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын зах зээлийг өргөтгөх** үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд даалгасугай.	2020		

	Засгийн газрын төлөвлөгөө	Шинэ сэргэлтийн бодлого	Аж үйлдвэрийн сэргэлтийн чиглэлд 3.5.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан **нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.**	2021		

Монгол Улс мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, олон хууль тогтоомжийг баталсан нь олон асуудлыг зохицуулсан боловч тодорхой хэдэн хууль тогтоомжийн хооронд эрх зүйн зөрчил байгаа нь эрх зүйг хэрэглэх эрэмбэ дарааллын ач холбогдлыг алдагдуулж, онолын зарчмыг зөрчиж байна. “Хүнсний тухай” Монгол Улсын 1 хууль, “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 1 тогтоол, “Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”, “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам” “Мах хөтөлбөр” Засгийн газрын 3 тогтоол, нийт 5 хууль тогтоомж, 3 удаа давхардсан шинжтэй байна.

Хүснэгт 10. Мах, махан бүтээгдэхүүний экспорттой холбоотой хууль тогтоомжийн зөрчил

№	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн заалт	Батлагдсан он	Дүгнэлт	Шийдлийн төсөл
1	Улсын Их Хурлын тогтоол	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай	Д/ малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд хэрэгжүүлж байгаа урамшууллыг дүгнэж, үр дүнд суурилсан, зах зээлийн зарчимд нийцүүлэхэд чиглүүлэх 3/ Үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийн тэлэх чиглэлээр 2. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай 3/ Төрөөс баримтлах энэхүү бодлогын зорилт нь хүнс, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэхэд оршино.	2024	Уг Засгийн газрын тогтоолын тушаал нь дурдсан УИХ-ын тогтоолд нийцээгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэгт "Монгол Улс ... олон хэвшил бүхий эдийн засагтай байна.", УИХ-н тогтоолоор экспортыг зах зээлийн зарчимд нийцүүлэн нэмэгдүүлнэ гэсэн атал Засгийн газрын тогтоолоор 20 хувийг экспортод гаргана гэсэн нь экспортыг хязгаарлаж буй нэг хэлбэр гэж үзэх боломжтой байна. Мөн чөлөөт эдийн засгийн	Засгийн газрын уг тогтоолд дурдсан "… үржлийн бус эр хонь, ямааны 20 хүртэл хувийг экспортлохыг зөвшөөрсүгэй" гэсэн заалтыг хасаж, эсрэгээрээ экспортыг дэмжих, түүнийгээ дагаад бүтээгдэхүүний чанарыг сайжруулах үүднээс хуулийн зохицуулалт нэмэх.

	Засгийн газрын тогтоол	Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	1. мал сүргийн тоо толгойн өсөлт, бэлчээрийн даац, хадлан, тэжээлийн хүрэлцээ хангамжтай уялдуулан тааврын зориулалттайгаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малын гоц халдварт өвчин гараагүй аймаг, сумдаас үржлийн бус эр хонь, ямааны 20 хүртэл хувийг экспортлохыг зөвшөөрсүгэй.	2017	зарчмын дагуу худалдагч, худалдан авагчийн ашиг сонирхол нь худалдааны тэнцлийг бий болгодог ба субьектив хандлагын үүднээс хэрэв гадаад улс орноос үржлийн бус эр хонь, ямааг авах хүсэлтэй байхад 20-н хувьд хүрсэн гэх шалтгаанаар экспортыг хязгаарлах эрсдэлийг бий болгож байна.	
2	Монгол Улсын хууль	Хүнсний тухай	51.3.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага стратегийн хүнсийг экспортлох **зөвшөөрөл олгоход зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 10 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлд нийлүүлэх**, импортлох зөвшөөрлийг олгоход зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 50 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлээс худалдан авах шаардлагыг тавьж, хуулийн этгээдтэй энэ талаар гэрээ байгуулж болно.	2012	Засгийн газрын тогтоолыг хуульд бүрэн нийцээгүй гэж үзэх боломжтой юм. Учир нь эрх зүйг тайлбарлах хэл зүйн аргын үүднээс Хүнсний туай хуулиар дотоодын нөөцийг бүрдүүлэх зорилготой байхад Мах хөтөлбөрөөр дотоодын нөөцөөс гадна экспортын нөөцийг бүрдүүлэх гэсэн утгатай байна.	2 хууль тогтоомжийг нийцүүлэхэд хуульд экспортын нөөцийг бүрдүүлэх утгатай зохицуулалт нэмэх, эсхүл хөтөлбөрөөс экспортын нөөцийг бүрдүүлэх гэсэн хэсгийг хасах гэх мэт.
	Засгийн газрын тогтоол	Мах хөтөлбөр	2.1. Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 2.2.4. **дотоодын болон экспортын махны нөөц бүрдүүлэх**; 3.6. Оролцогч аж ахуйн нэгжийн чиг үүрэг 3.6.1. олгогдсон зээлийг зөвхөн дотоодод болон экспортод гаргах зориулалтаар махны нөөц бүрдүүлэхэд ашиглах; 5.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ: 5.1.2. мах, махан бүтээгдэхүүний экспорт өсөж,	2015		

			гадаад валютын эх үүсвэр нэмэгдэнэ;			
3	Монгол Улсын хууль	Хүнсний тухай	6.7.Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний **эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан** тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтооно.	2012	Уг тогтоол тухайн хуульд нийцээгүй гэж үзэхээр байна. Учир нь Хүнсний тухай хуулиар Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоох атал СХЭИЗОЖ-р Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үндэсний зөвлөлийн зөвлөмжид үндэслэн экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож болохоор ялгаатай тусгажээ.	СХЭИЗОЖ-д зохицуулахдаа "Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасны дагуу тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтооно.
	Засгийн газрын тогтоол	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам	2.3. Үндэсний зөвлөл энэ журмын 2.2-т заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хэлэлцэж зөвлөмж гаргана. 2.4. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын **2.3-т заасан зөвлөмжийг үндэслэн** тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг БТКУС-ийн кодод нийцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор түүхий эд, бүтээгдэхүүн тус бүрээр тогтооно. (Энэ заалтад Засгийн газрын 2021 оны 4 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)	2015		

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

“Махны экспортыг нэмэгдүүлэхэд Монгол Улсын хууль эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудал” судалгааг ганцаарчилсан ярилцлага, хоёрдогч өгөгдлийн шинжилгээ, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлалаар 2025.3.15-2025.4.25-ны хугацаанд хийж гүйцэтгэсэн болно. Судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Мах, махан бүтээгдэхүүн экспортлохтой холбоотой 22 хууль, 28 журамд давхардал, зөрчил байгаа эсэхийг шинжлэхэд 3 давхардал, 3 зөрчил байх боломжтой зүйл, заалт илэрсэн.
- Хэдийгээр дээр дурдсанчлан хууль тогтоомж, журмын хүрээнд давхардал, зөрчил цөөн ч одоо мөрдөгдөж буй хууль, журам, тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт дахь шаардлагуудын зарим нь жижиг дунд, тэр дундаа махны экспортын чиглэлээр ажиллах гарааны бизнес эрхлэгчдийн хувьд биелүүлэхэд хүндрэлтэй, бүүр цаашилбал, биелүүлэх боломжгүй шаардлагууд байна. Энэхүү нөхцөл байдал нь зах зээл дээр жижиг аж ахуй эрхлэгчдийг шахах, томоохон үйл ажиллагаа бүхий, эсвэл гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад л боломж олгосон байдалтай байна.
- Гаалийн Ерөнхий газраас ирсэн 2024 оны экспортод гарсан мах, махан бүтээгдэхүүний статистик дүнд шинжилгээ хийхэд, тус онд нийт 269,099,824$-той тэнцэх 69,314,492 кг мах, махан бүтээгдэхүүнийг экспортод гаргасан байна. 70% нь мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн байгаа бол 30% нь махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүн байна.
    - Мах, махан бүтээгдэхүүний экспортын дүнг харвал, 2024 онд 58 аж ахуй нэгжээс 20 нь 1%-аас дээш хэмжээний бүтээгдэхүүн экспортод гаргасан бол 38 нь 1% хүртэлх хэмжээний экспорт хийжээ. Үүнээс Монголиан мийт экспорт центр ХХК болон Монголмах экспо ХХК нийт экспортын 41.9%-ыг хийсэн бол 4 нь гадаадын хөрөнгө оруулалттай компани байна. Мөн нийт экспортод гарсан бүтээгдэхүүний 48.8% нь хонь, 48.1% нь адууны мах байгаа бөгөөд 45.3% нь БНХАУ, 37.6% нь Иран улс руу экспортлогдсон байна.

- Махаар хийсэн бэлэн бүтээгдэхүүний дүнг харвал, 24 аж ахуй нэгжээс 12 нь 1%-аас илүү бүтээгдэхүүн экспортод гаргасан. Үүнээс Монгол тогоруу трейд ХХК /ГХО/ нийт экспортын 19.4%-ыг эзэлж байгаа нь хамгийн өндөр дүн байгаа бол 10%-аас 15% хүртэлх хэмжээний экспортыг 4 аж, ахуй нэгж хийсэн байна. Тус 24 аж ахуй нэгжийн 6 нь гадаадын хөрөнгө оруулалттай байгаа бөгөөд 3 нь 12%-аас 19%-ийн буюу хамгийн их хэмжээгээр экспорт хийсэн байна. Мөн нийт экспортод гарсан бүтээгдэхүүний 63% нь ямаа, 23% нь үхрийн мах байгаа бөгөөд 99.5% нь БНХАУ руу экспортлогдсон байна.

- “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт” нь хүнсний аюулгүй байдал, чанарыг хангах, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн ч бодит хэрэгжилтэд санхүү, дэд бүтэц, хүний нөөц, техник технологийн хүндрэлүүд тулгарч байна. Ялангуяа жижиг, дунд үйлдвэрүүд болон орон нутгийн нэгжүүдэд шаардлага хангах нөхцөл бүрдээгүй, мөн цахим бүртгэл, лабораторийн шинжилгээ, хяналт шалгалт зэрэг нь ихээхэн зардал, зохион байгуулалт шаарддаг нь хэрэгжилтийг сааруулж байна.
- Мал эмнэлэг үйлдвэрийн хяналт шалгалтыг тогтоосон журмын дагуу хэрэгжүүлдэг ч үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд стандарт шаардлага хангах нөхцөл дутмаг, хяналтын үйл явц хувийн ашиг сонирхлоор зөрчигдөх эрсдэлтэй байна. Үүний улмаас зарим тохиолдолд зөрчлийг нуун дарагдуулах, авлига өгөх замаар шалгалтаас “амжилттай” гарах нөхцөл бүрдэж, хяналт шалгалтын бодит үр нөлөө алдагдаж байна.
- Хүнсний тухай хуульд стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл олгох үйл явцыг цахимаар, ил тод зохион байгуулах ёстой гэж заасан байдаг. Гэвч бодит байдал дээр энэ процесс Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд явагдаж, зөвхөн томоохон компаниудад давуу байдал олгогдож, бусад аж ахуйн нэгжүүдийн хувьд шударга бус, ойлгомжгүй нөхцөл үүссэн байна. Иймээс дуудлага худалдаагаар квот хуваарилах санал гарсан ч жижиг аж ахуйн нэгжүүд энэ арга нь мөн л хөрөнгө мөнгөтэй том компаниудад ашигтай байх вий гэсэн эргэлзээг төрүүлсэн.
    - Мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаанд импортлогч орны протокол, лабораторийн шаардлага, зөвхөн өөрийн бүртгэгдсэн үйлдвэрт бэлтгэсэн бүтээгдэхүүн экспортлох зэрэг зохицуулалт нь экспортлогч аж ахуйн нэгжүүдэд олон талын хязгаарлалт учруулж

байна. Монгол Улсын малын эрүүл мэндийн хяналт, лабораторийн хүчин чадал, малчдын вакцинжуулалтын оролцоо хангалтгүй, малын эмчийн нөөц дутагдалтай байгаа нь экспортын чадавхыг хязгаарлаж байна. Мөн дундын холбон зуучлагч нар нь махны үнийг унагаж Монгол Улсад орж ирэх ашгийг бууруулж байна.

- Гаалийн болон холбогдох протоколын дагуу машин бүрийн мах, махан бүтээгдэхүүнд шинжилгээ хийж, савлалт, хадгалалт, лацдахад тавигдах шаардлага нь тээвэрлэлтийн явцад халдвар, бохирдлоос сэргийлэхэд чухал үүрэгтэй зохицуулалт боловч бодит байдал дээр энэ үйл явц цаг хугацаа, эдийн засгийн хувьд хүндрэл учруулж байна. Үүнээс шалтгаалан хууль бус арга зам сонгох хандлага нэмэгдэх эрсдэл үүсэж байна.
- Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад Монгол Улсад итгэмжлэгдсэн лабораторийн тоо хомс, зарим улс орон Монголын шинжилгээний хариуг бүрэн хүлээн зөвшөөрдөггүй нь экспортын үйл явцад хүндрэл үүсгэдэг. Үүнээс шалтгаалан олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахын тулд зарим тохиолдолд хууль бус арга зам сонгож үүний улмаар зарим орнуудын Монголын гэрчилгээнд итгэх итгэл буурахад хүрч байна.
- “Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам”-д шинжилгээний үнэн зөв, хараат бус байдлыг тусгасан ч хариу гарах хугацааг тодорхой заагаагүй нь аж ахуйн нэгжүүдэд эдийн засгийн болон цаг хугацааны дарамт үүсгэж байна. Мөн орон нутгийн үйлдвэрлэгчид төвлөрсөн лаборатори хүрэлцээгүй, холоос ус зөөж шинжлүүлэхэд хүндрэлтэй байгаагаас Улаанбаатараас цэвэр ус авч шинжлүүлэх зэрэг бодит бэрхшээл үүсэж, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд саад болж байна.
- Хуулиар тохирлын гэрчилгээ олон улсад хүчин төгөлдөр гэж заасан ч Стандарт хэмжилзүйн газраас олгосон гэрчилгээ зарим улс оронд хүлээн зөвшөөрөгдөөгүй тохиолдол гарч, энэ нь мах экспортлогч аж ахуйн нэгжүүдийн гадаад зах зээлд итгэлтэй оролцох итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлж байна.
- Гаалийн байгууллагагүй боомтоор нэвтрэх боломжгүй зохицуулалт нь мах экспортлогчдын тээвэрлэлтийн зардал, хугацааг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг бууруулж байна.

- Гаалийн хяналтын явцад албан хаагчдын хувийн хандлагаас шалтгаалан экспорт удаашрах, бараа буцах тохиолдол гарч, аж ахуйн нэгжүүд хуульд заасан гомдол гаргах эрхээ ашиглахаас илүүтэй асуудлыг хурдан шийдэхийн тулд хууль бус арга замыг сонгох хандлага түгээмэл байна.
- Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжүүд хууль, журмыг бүрэн ойлгоогүй, мэдээллийн хүртээмж хомс байдгаас шаардлагатай бичиг баримтыг зүгээр л бүрдүүлэх байдлаар ханддаг хандлага нийтлэг ажиглагдсан. Үүнээс болж зөвшөөрөл авах, хяналт шалгалтад бэлтгэх, стандарт шаардлага хангах үйл явц нь гүн ойлголтгүй, экспортын чанар, итгэлцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болж байна.

- Аж ахуй нэгжийн зүгээс мах, махан бүтээгдэхүүн экспортлохтой холбоотой бүх хууль, журмыг төдийлөн мэддэггүй бөгөөд ХХААХҮЯ, МЭЕГ, ГЕГ зэрэг мэргэжлийн байгууллагын бүрдүүл гэсэн материалыг л бүрдүүлдэг нь хэрэгжилтэд тодорхой хэмжээнд саад учруулж байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- ✓ Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлд бодлого төлөвлөхдөө жижиг дунд, тэр дундаа гарааны бизнес эрхэлж иргэн, аж ахуй нэгжийн биелүүлэх боломжтой журам, техникийн шаардлага гаргах;
- ✓ Хууль санаачилж батлах болон нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө хэрэгжих боломжтой эсэхийг судлах;
- ✓ Мөн мах, махан бүтээгдэхүүн экспортлохтой холбоотой хаана, ямар баримт бичиг бүрдүүлж өгөх талаарх мэдээлэл ил тод, ойлгомжтой харагдах байдалд анхаарах;
- ✓ Мах, махан бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүдийг сургалтаар хангах;
- ✓ Мах, махан бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл олгох үйл явцыг ил тод, нээлттэй болгох;
- ✓ Монгол Улс нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг тул малчдад малын эрүүл мэндийг хангах тухай сургалтыг тогтмол хийж, аливаа эрсдэл гарахаас сэргийлэх;
- ✓ Нэгэнт баталсан бол тухайн хууль, журмаа хэрэгжүүлдэг байх;
- ✓ Төрийн байгууллагын зүгээс хоорондын уялдаа холбоог сайжруулах. Хяналт шалгалтын давхардлыг арилгах;

Эх сурвалжийн жагсаалт

Монгол эх сурвалж:

Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн. (2022). *БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох.* Улаанбаатар.

Батхүү, Б., М., М., Г., Ч., Э., Э., Ц., З., & Ц., И. (2023). *Монгол малын махыг экспортын чадамжтай бренд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх судалгааны ажлын тайлан.* Улаанбаатар.

Д.Адьяасүрэн, Н.Отгонсайхан, А.Доржпалам. (2020). ОХУ-Д АДУУНЫ МАХ ЭКСПОРТЛО. *МОНГОЛ УЛСЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЦОГЦ ГАРЫН АВЛАГА*.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ. (2017 оны 12 8). *МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ*. Эрх Зүйн Мэдээллийн Нэгдсэн Систем: https://legalinfo.mn/mn/detail/13026-ээс Гаргасан

Стандарт, хэмжил зүйн газар. (n.d). *Стандарт, хэмжил зүйн газар*. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори: https://www.masm.gov.mn/website/services.aspx-ээс Гаргасан

Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Ганчимэг, Х.Бодьсайхан, Э.Тэмүүлэн. (2022). БНХАУ-Д МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ . *МОНГОЛ УЛСЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЦОГЦ ГАРЫН АВЛАГА* .

Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Энх-Амгалан, Ц.Батнаран, О.Амартүвшин. (2020). БНХАУ-д адууны мах экспортлох . *Монгол улсын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчдэд зориулсан цогц гарын авлага* .

Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Энх-Амгалан, Ц.Батнаран, О.Амартүвшин. (2022). БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ. *МОНГОЛ УЛСЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЦОГЦ ГАРЫН АВЛАГА* .

Удирдлагын академи. (2023). *Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ.* Улаанбаатар.

ХААБ. (2022). *Махны нийлүүлэлтийн тогтолцоо судалгааны тайлан.* Улаанбаатар.

ХААБ. (2023). ЭКСПОРТЫН НЭГ ЦОНХНЫ ЦАХИМ НЭГДСЭН СИСТЕМД БИРЖИЙН ОРОЛЦОО.

Хөдөө аж ахуйн бирж. (2022). *“МАХНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦОО” судалгааны тайлан.* Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө, 18А-1, монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны

байр II давхар: Хөдөө аж ахуйн бирж. https://mce.mn/wp-content/uploads/2022/06/%D0%9C%D0%B0%D1%85%D0%BD%D1%8B-%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BB%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D0%BE%D0%B3%D1%82%D0%BE%D0%BB%D1%86%D0%BE%D0%BE-2022.pdf?utm_source=chatgpt.com-ээс Гаргасан

ХХААХҮЯ, Судалгаа, хөгжлийн төв. (2023). Монгол малын махыг экспортын чадамжтай брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх судалгааны ажлын тайлан.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2015). *“МАХ” ХӨТӨЛБӨР*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=207027&utm_source=chatgpt.com-ээс Гаргасан

Гадаад эх сурвалж:

Bryman, A. (2016). Social research methods.

International Organization for Standardization. (n.d). *Standarts*. International Organization for Standardization: https://www.iso.org/standards.html-ээс Гаргасан

Kvale, S., & Brinkmann, S. (2009). Interviews: Learning the craft of qualitative research interviewing.

Miles, M. B., Huberman, A. M., & Saldaña, J. (2014). *Qualitative data analysis: A methods sourcebook.*

Palinkas, L. A., Horwitz, S. M., Green, C. A., Wisdom, J. P., Duan, N., & Hoagwood, K. (2015). Purposeful sampling for qualitative data collection and analysis in mixed method implementation research. *Administration and Policy in Mental Health and Mental Health Services Research*, 533–544. https://doi.org/10.1007/s10488-013-0528-y-ээс Гаргасан

Perez, R., & Boldbaatar, M. (2021). *Meat export value chain study in Mongolia.* Ulaanbaatar: UNCTAD.

Perez, R., & Boldbaatar, M. (2021). *Meat Market Research.* Ulaanbaatar: UNCTAD.

World Healt Organizatoin. (n.d). *GENERAL PRINCIPLES OF FOOD HYGIENE CXC 1-1969.*

Хавсралт

Хавсралт 1. Мах, махан бүтээгдэхүүний экспорттой холбоотой харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн актын жагсаалт

Дугаар	Хууль тогтоомжийн төрөл	Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн заалт	Батлагдсан он
1	Монгол Улсын хууль	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай	22.5.10.доор дурдсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар: 22.5.10.д.эрчимжсэн тахианы аж ахуйд үйлдвэрлэсэн мах, махан бүтээгдэхүүн.	2019
2	Монгол Улсын хууль	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай	4.1.Энэ хуулийн хүрээнд дор дурдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтад хамруулна: 4.1.2.мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, өлөн, эвэр, туурай, шувууны өд, сөд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн; 29.1.Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, дамжуулан өнгөрүүлэх, тээвэрлэх иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 29.1.2. улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаар гаалийн байгууллага, улсын байцаагчид мэдүүлэх; 29.1.3.амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, ургамлын хорио цээрийн гэрчилгээ, импортын болон бараа, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, худалдааны гэрээ, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг улсын байцаагчид шалгуулах;	2002
3	Монгол Улсын хууль	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай	3.1.1."олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ" гэж экспортлогдож буй мал, амьтан, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжид заасан тодорхой нөхцөл шаардлагыг хангаж байгааг гэрчлэн экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажуулалтын баримт бичгийг;	2002

4	Монгол Улсын хууль	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай	9.1.Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд иргэн, хуулийн этгээд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна: 9.1.1.Монгол Улсаас гадаад улстай амьтан, ургамлын хорио цээрийн талаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид заасан стандарт, удирдамж, зөвлөмжийн нөхцөлийг мөрдөх; 9.1.2.экспортлогч улсын хорио цээрийн хяналт, баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хорио цээрийн үзлэг, шалгалтад оруулах; 9.1.3.амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийн хашлага, дэвсгэр, сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэлд хорио цээрийн үзлэг, шалгалтыг хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбай дээр хийлгэх; 9.1.4.биологийн эмгэгт материал, бичил биетний омог, өсгөврийн дээж, хөрс, хөрстэй ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар хил нэвтрүүлэх ба хүлээн авагч улсын холбогдох этгээдэд хүргэх хүртэл сав, баглаа боодол, битүүмжлэлийг задлахгүй байх. 11.1.Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна: 11.1.2.экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх. 13.1.Дараах тохиолдолд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно: 13.1.1.энэ хуулийн 10.1, 11.1-д заасан шаардлагыг хангаагүй; 13.1.2.хорио цээрийн хяналт, шалгалтад ороогүй, эсхүл гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл зөрүүтэй буюу дагалдах бичиг баримт нь хуурамч болох нь хяналт, шалгалтын явцад тогтоогдсон.	2002
5	Монгол Улсын хууль	Амьтны тухай	4.1.7."агнуурын амьтан" гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг;	2012
6	Монгол Улсын хууль	Амьтны тухай	11.1.Агнуурын амьтан агнах, барихтай холбогдсон дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 11.1.9.тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах;	2012

7	Монгол Улсын хууль	Гаалийн тариф, гаалийн татварын тухай	4.1.Монгол Улсад экспортын болон импортын барааны гаалийн тарифыг хэрэглэх бөгөөд гаалийн тарифыг тогтоохдоо барааны код, нэр төрлийг Уялдуулсан системийн дагуу заана. 10.3.Энэ хуулийн 10.1-д заасан аргаар гаалийн үнийг тодорхойлохдоо хэлцлийн үнэд ороогүй, эсхүл хэлцлийн үнээс тусдаа ялгарч харагдах тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн бөгөөд гадаад худалдаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндэслэлтэй мэдээ баримтад тулгуурласан дараах зардлыг нэмж тооцно: 10.3.1.тухайн барааг Монгол Улсын хилийн өртөө хүртэл тээвэрлэхтэй холбогдон гарсан дараахь зардал: 10.3.1.1.тээврийн зардал, тээврийн болон экспортын бичиг баримт бүрдүүлэхэд гарсан зардал, тээврийн хэрэгсэл болон чингэлэг ашиглалтын хөлс, түрээсийн төлбөр; 15.3.Уялдуулан хэрэглэх аргаар гаалийн үнийг тодорхойлоход дараах үнийг үндэслэхийг хориглоно: 16.1.Экспортын барааны гаалийн үнэ нь Монгол Улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцөлөөр тодорхойлогдоно. 16.2.Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлоход дараах аргыг дор дурдсан дарааллын дагуу хэрэглэнэ: 16.2.1.хэлцлийн үнийн арга; 16.2.2.зардлаас тооцох үнийн арга; 16.2.3.нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга; 16.2.4.зах зээлийн мэдээлэл, судалгааны арга. 17.1.Хэлцийн үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлоход хэлцлийн үнэд Монгол Улсын хил хүртэл уг барааг хүргэхэд барааны дараах зардал, төлбөр ороогүй бол нэмж тооцно: 17.1.1.тээврийн зардал; 17.1.2.тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн болон экспортын бичиг баримт, бүрдүүлэлтийн хураамж, даатгалын шимтгэл, түүнчлэн барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачихад гарсан зардал. 17.2.Дараах тохиолдолд экспортын барааны үнэлгээнд хэлцлийн үнийн аргыг хэрэглэхийг хориглоно: 17.2.1.хэлцэл нь гаалийн үнийг тодорхойлох боломжгүй нөхцөлөөр хийгдсэн бол; 17.2.2.худалдагч болон худалдан авагч нь харилцан хамаарал бүхий этгээдүүд бөгөөд энэ хамаарал нь хэлцлийн үнэд мэдэгдэхүйц нөлөөлсөн бол. 18.3.Энэ хуулийн 18.1-д заасан аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо тухайн барааны нэгжид шууд болон шууд бус байдлаар шингэсэн дараах зардал, үнийг нэмж тооцно: 18.3.1.үнийг нь тодорхойлж буй барааг үйлдвэрлэхтэй холбогдсон дараах зардал: 18.3.1.1.үйлдвэрлэгчээс тухайн бараанд бүрэлдэхүүн хэсэг болгон хэрэглэсэн түүхий эд, үндсэн болон туслах материалын үнэ; 20.1.Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох сүүлчийн арга нь зах зээлийн мэдээлэл, судалгааны үнийн арга болно. 20.2.Зах зээлийн мэдээлэл, судалгааны аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо олон улсын худалдааны практик, тухайн үеийн дэлхийн зах зээлийн үнийн дараах мэдээлэл, судалгааг үндэслэнэ: 20.2.1.экспортлогчийн нийтэд зориулан тараасан үнийн жагсаалт, лавлагаа, интернэтийн мэдээлэл; 20.2.3.барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн	2008

			мэдээлэл, зах зээлд зонхилох экспортлогчдын гэрээ, түүний үнэ. 31.7.Барааны гарал үүслийг нотлох баримт бичиг нь дараах хэлбэртэй байна: 31.7.1.барааны гарал үүслийн мэдүүлэг буюу үйлдвэрлэгч, худалдагч, экспортлогчоос барааны гарал үүслийн талаар тусгасан мэдээлэл бүхий үнийн нэхэмжлэх, тээврийн баримт бичиг;	

8	Монгол Улсын хууль	Гаалийн тухай	113.1.Хилийн чанадад гаргах горимд байршуулсан бараанд гаалийн байгууллага экспортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ. 113.2.Хилийн чанадад гаргах горимд байршуулсан бараанд гаалийн байгууллага экспортын гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу гаргуулан авч болно. 115.1.Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн монголын барааг түүний экспортын гаалийн болон бусад татварыг төлүүлсний үндсэн дээр гаалийн нутаг дэвсгэрээс гаргана. 137.4.Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулахаар хилийн чанадаас оруулах гадаадын бараанд гаалийн болон бусад татвар ногдуулахгүй бөгөөд харин гаалийн нутаг дэвсгэрээс гаалийн баталгаат бүсийн горимд оруулах монголын бараанд экспортын барааны болон бусад татвар ногдуулан хураан авч, улсын төсөвт төвлөрүүлнэ. 153.1.Гаалийн баталгаат үйлдвэрийн газарт дараах үйл ажиллагаа явуулна: 153.1.2.материал, түүхий эдийг боловсруулах; 249.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хяналтаас гаргах зөвшөөрөл олгосны дараа гаалийн мэдүүлэг болон гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтад өгөгдсөн мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгах, мэдүүлэгчийн экспорт, импортын үйл ажиллагаанд гаалийн зорилгоор гаалийн байгууллага бүрдүүлэлтийн дараах шалгалтыг явуулна. 249.2.Гаалийн байгууллага, албан тушаалтан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийхдээ дор дурдсан эрх эдэлнэ: 249.2.1.мэдүүлэгчээс гааль, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн болон бусад шаардлагатай бичиг баримтыг гаргуулан авах, мэдээллийн санд нь нэвтрэх; 249.2.2.шалгалттай холбоотой бичиг баримтыг нягтлан шалгах, хуулбарлан авах, баталгаажуулах, холбогдох тайлбар, тодруулга, лавлагааг гаргуулан авах; 249.2.3.бараа хүлээн авагч, эзэмшигч, өмчлөгч, тэдгээртэй харилцан хамааралтай этгээдийн байр, агуулах, талбайд нэвтрэн орох, шалгалт хийх, шаардлагатай гэж үзвэл битүүмжлэх; 249.2.4.бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлэгч, хүлээн авагч, эзэмшигч, өмчлөгч, тэдгээртэй харилцан хамаарал бүхий этгээд нь байр, агуулах, талбайдаа оруулахгүй байх, бусад хэлбэрээр шалгалт хийлгэхээс татгалзах тохиолдолд хөндлөнгийн 2-оос доошгүй гэрч байлцуулан тэдгээрт нэвтрэн орж шалгалт хийх; 249.2.5.хуульд заасан бусад эрх.	2008
9	Монгол Улсын хууль	Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх нөлөөллийг бууруулах тухай	3.2.Энэ хуулийн 3.1-д заасан гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүнд дараах бараа, бүтээгдэхүүн хамаарна: 3.2.3.мах.	2022

10	Монгол Улсын хууль	Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх нөлөөллийг бууруулах тухай	5.1.Монголбанк энэ хуульд заасан гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 5.1.1.мах, гурилын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах бэлтгэн нийлүүлэгч, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг банкны эх үүсвэрээр олгох;	2022
11	Монгол Улсын хууль	Зөвшөөрлийн тухай хууль	8.1.1. Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно: 1.3.амьтан тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох - Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; 8.1.1.21. олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох - Удирдан зохицуулах зөвлөл	2022
12	Монгол Улсын хууль	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	5.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 5.1.5.төв суурин газар, хүнсний зах, махны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж зэрэг шаардлагатай газарт мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоож, мал, махны гарал үүсэлд хяналт тавих; 10.1.Сум, баг, дүүрэг, хорооны Засаг дарга мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төв суурин газарт борлуулах, худалдах зорилгоор оруулж байгаа мал, маханд мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ олгоно. 10.2.Мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээний загвар, олгох журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	2004
13	Монгол Улсын хууль	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	8.1.Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ: 8.1.1. мал, мах бэлтгэх ажлыг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх; 8.1.2. мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалж байх; 8.1.3. амьдын жингээр авч нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд саадгүй үзүүлж байх; 8.1.4. мал, мах бэлтгэх ажлыг энэ хуулийн 5.1.5-д заасан цэгт хийх. 8.2. Тээврийн хэрэгслийн жолооч нь мах бэлтгэлийн зориулалттай мал, махыг тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээтэй эсэхийг нь шалгасны үндсэн дээр тээвэрлэнэ.	2004

14	Монгол Улсын хууль	Мал, амьтны эрүүл мэндийн тухай	31.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мал эмнэлгийн хяналтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 31.4.1.Засгийн газрын эрх олгосноор гадаад улс, олон улсын байгууллагатай мал эмнэлэг, хорио цээрийн талаар хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах; 31.5.1.өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын байгууллагатай мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, хяналт шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах; 31.5.3.олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох;	2017
15	Монгол Улсын хууль	Мал, амьтны эрүүл мэндийн тухай	31.8.Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ: 31.8.1.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа, боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр, хаяг, байршил, түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, боловсруулалтын байдал /хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, хөргөсөн, шинэ гэх мэт/, савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл агуулсан хүсэлт; 31.8.2.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт; 31.8.3.худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг.	2017
16	Монгол Улсын хууль	Малчны тухай	5.2.Малчин дараах үүргийг хүлээнэ: 5.2.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах; 5.6.Энэ хуулийн 5.2.4-т заасан үүргийг биелүүлэх хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ: 5.6.2.малын мах бэлтгэлийг хийхдээ малын арьс ширийг механик гэмтэлгүйгээр цэвэрлэгээ, анхан шатны тордолтыг хийж, стандарт, шаардлагын дагуу бэлтгэх;	2024
17	Монгол Улсын хууль	Малын генетик нөөцийн тухай	13.7.Малын үүлдэр хамгаалах, ашиглах, хөгжүүлэх үүлдрийн нийгэмлэг байгуулах, зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мах, сүү үйлдвэрлэлийн төрөлжсөн бүсэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг Засгийн газраас дэмжинэ.	2017
18	Монгол Улсын хууль	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	13.1.Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийнэ. 13.4.Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу импортлох болон экспортлох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд холбогдох хяналт шалгалт хийнэ.	2012

19	Монгол Улсын хууль	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	3.1.Энэ хууль хүнсний түүхий эдийн анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, үйлчлэх, импортлох, экспортлох, хүнсийг савлах, шошголох зэрэг хүнсний сүлжээний бүх үе шатанд үйлчилнэ. 4.1.6."хүнсний сүлжээ" гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг; 6.5.Хяналтын байгууллага дор дурдсан үйлдвэрлэлийг шинээр эрхлэх хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Хүнсний тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана. 6.5.1.мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;	2012
20	Монгол Улсын хууль	Хүнсний тухай	6.7.Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтооно.	2012
21	Монгол Улсын хууль	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай	14.7.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 14.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.	
22	Монгол Улсын хууль	Хүнсний тухай	3.1.6."стратегийн хүнс" гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг; 6.1.Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ. 6.4.Засгийн газар хүнсний эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдлаас хамааран энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож болно. 6.8.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.7-д заасны дагуу тогтоосон хэмжээнд багтаан Засгийн газраас баталсан журмын дагуу стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгоно. 51.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг нэр төрлөөс нь хамааруулан дараах хугацаанд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд цахимаар хүргүүлнэ: 51.1.2.малын махны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны дотор; 51.3.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага стратегийн хүнсийг экспортлох зөвшөөрөл олгоход зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 10	2012

			хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлд нийлүүлэх, импортлох зөвшөөрлийг олгоход зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 50 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлээс худалдан авах шаардлагыг тавьж, хуулийн этгээдтэй энэ талаар гэрээ байгуулж болно. 51.6.Энэ хуулийн 51.5-д заасан ажлын хэсэг стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын зар гаргах, урилга хүргэх, хариу илгээх, үр дүнг мэдээлэх ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна.	
23	Улсын Их Хурлын тогтоол	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай	1/Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр: в/малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;	2024
24	Улсын Их Хурлын тогтоол	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай	4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр: в/хот, суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, махны чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой, сүүний чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой үхрийн аж ахуй, махны болон нарийн ноост хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг бий болгох, өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох санхүүжилтийг төсөвт тусгах;	2022
25	Засгийн газрын тогтоол	Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	3.Сангийн сайд Д.Даваасамбуу, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Өөлд нарт даалгах нь: а)Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу хүн амын мах, гурилын зайлшгүй хэрэгцээг тогтвортой хангах зорилгоор мал, мах бэлтгэл, уринш боловсруулалт, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэхэд шаардагдах шатахуун, тээврийн зардал болон гадны байгууллагаас очиж ажиллагчдын хөдөлмөрийн хөлсийг төлөхөд зориулсан зээлийн хүүгийн зөрүүг зээл авах аж ахуйн нэгж, байгууллагатай тодорхой гэрээ байгуулсны үндсэн дээр нөхөж олгох арга замыг 8 дугаар сарын 25-ны дотор Монгол банктай тохиролцож, уг зээлийг зориулалтаар нь ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласугай; б)хөдөө аж ахуйн байгууллагуудын үр ашиг, төлбөрийн чадварыг дээшлүүлэх,аж ахуйг эрхлэх арга барилыг сайжруулах замаар өөрийгөө санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, түүнчлэн зээлийн хүү өдөр, инфляц ихтэй байгаа өнөөгийн нөхцөлд мах, гурилын үйлдвэрлэлийг зээлийн хүүгийн хөнгөлөлтөөр урамшуулах асуудлыг судалж энэ оны 11 дүгээр сард багтаан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлсүгэй.	1993
26	Засгийн газрын тогтоол	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай	2. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгах нь: б/улсын хэмжээнд дотоодын зах зээлд нийлүүлэх мал, мах бэлтгэлийн ажлыг зохион байгуулан мах экспортлох ажилд бодит дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажилласугай;	2007

27	Засгийн газрын тогтоол	Автобензин, дизелийн түлш, мах, нийтийн тээврийн үнийг тогтворжуулах зарим арга хэмжээний тухай	9. Дотоодын зах зээлийг хамгаалах, махны хангамжийг тогтворжуулах зорилгоор махны экспортыг 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл түр хугацаагаар хязгаарлахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай.	2012
28	Засгийн газрын тогтоол	Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	4.Худалдааг хөнгөвчилж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд тус тус даалгасугай: 4.3.Булган-Такашикен, Бичигт-Зүүнхатавч, Шивээхүрэн-Сэхээ боомтоор мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх талаар БНХАУ-тай яриа хэлэлцээр хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нарт;	2023
29	Засгийн газрын тогтоол	Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	1. Мал сүргийн тоо толгойн өсөлт, бэлчээрийн даац, хадлан, тэжээлийн хүрэлцээ хангамжтай уялдуулан таваарын зориулалттайгаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор малын гоц халдварт өвчин гараагүй аймаг, сумдаас үржлийн бус эр хонь, ямааны 20 хүртэл хувийг экспортлохыг зөвшөөрсүгэй. 2. Импортлогч улсын холбогдох яам, мэргэжлийн газруудтай мал экспортлох гэрээ, хэлцэл хийж, орон нутгийн байгууллагуудыг бодлого, зохицуулалтаар дэмжиж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг нарт, шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт тус тус даалгасугай. 3. Импортлогч улсын мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн малыг хорио цээрийн тусгаарлагдсан бүс, байгууламжаар дамжуулан мал эмнэлгийн хяналтын дор үзлэг, шинжилгээнд хамруулж, мал бордох үйлчилгээг үзүүлж экспортлох арга хэмжээг зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2017
30	Засгийн газрын тогтоол	Мах, сүүний зарим үйлдвэрийн талаар авах арга хэмжээний тухай	1.Монгол, Оросын Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны комиссын 4 дүгээр хуралдааны протоколоор тохиролцсоны дагуу ОХУ-д төлөх урсгал өрийн зарим хэсгийг барагдуулах зорилгоор мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуйн нэгжүүдэд "Хишиг", "Багахангай" компаниудыг оролцуулах, шаардлагатай бол мал, мах бэлтгэхэд нь зориулан зохих журам, нөхцөлийн дагуу хөрөнгийн урьдчилгаа олгох арга хэмжээ авахыг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц.ЦОГТ), Сангийн яам (Э.БЯМБАЖАВ)-д зөвшөөрсүгэй. 2.Улаанбаатар хотын үйлдвэр, худалдааны "Сүү", Дархан-уул аймгийн "Хишиг" компанийн үйлдвэрлэсэн сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүнд ногдуулах худалдааны албан татварыг 1996 оны 5	1996

			дугаар сарын 1-нээс эхлэн хоёр жилийн хугацаанд 50 хувиар хөнгөлсүгэй. 3.Гадаадын хөрөнгөөр баригдсан болон тусламжаар техникийн шинэчлэлт хийсэн хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд судалгаа хийж, санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэх, бүтэц, ажлын зохион байгуулалтыг нь сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц.ӨӨЛД)-д даалгасугай.	
31	Засгийн газрын тогтоол	Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн талаар авах арга хэмжээний тухай	2.Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн экспортыг сайн дурын хязгаарлалтад хамруулах, түүхий эд экспортлох эрхийг багцлан дуудлага худалдаагаар олгох тогтолцоо бий болгох боломжийг судлан санал боловсруулж энэ оны П улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Гадаад харилцааны сайд Н.Туяа нарт даалгасугай..	2000
32	Засгийн газрын тогтоол	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2020 оныг "Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийн ашиглалт, экспортыг нэмэгдүүлэх" жил болгон зарласугай. 2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эд, бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, хүчин чадлаас давсан нөөцийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжих, түүхий эдийг үнэгүйдэхээс хамгаалах бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. 4. Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт даалгасугай. 5. Мал төхөөрөх, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр, цехийн хүчин чадлын ашиглалт, боловсруулалтын түвшнийг сайжруулах замаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын зах зээлийг өргөтгөх үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд даалгасугай.	2020
33	Засгийн газрын тогтоол	Мах хөтөлбөр	2.1. Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 2.2.4. дотоодын болон экспортын махны нөөц бүрдүүлэх; 3.6. Оролцогч аж ахуйн нэгжийн чиг үүрэг 3.6.1. олгогдсон зээлийг зөвхөн дотоодод болон экспортод гаргах зориулалтаар махны нөөц бүрдүүлэхэд ашиглах; 5.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ: 5.1.2. мах, махан бүтээгдэхүүний экспорт өсч, гадаад валютын эх үүсвэр нэмэгдэнэ; 3.1. Хөтөлбөрийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж Хөгжлийн банк санхүүжүүлнэ.	2015

34	Засгийн газрын тогтоол	Мал аж ахуй түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай	4. Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зарим суманд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах нэгдсэн бүтэц бүхий загвар хоршоо байгуулж, кластерын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2020
35	Засгийн газрын тогтоол	Ургамлын үр, үрслэг, суулгац нэвтрүүлэх, үржлийн мал, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боомтын тухай	3. Улсын хилийн дараах боомтуудаар түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлохыг зөвшөөрсүгэй: 1) Өмнөговь аймгийн Шивээхүрэн; 2) Өмнөговь аймгийн Гашуунсухайт; 3) Булган аймгийн Бага-Илэнх; 4) Сүхбаатар аймгийн Бичигт; 5) Говь-Алтай аймгийн Бургастай.	2010
36	Засгийн газрын тогтоол	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам	2.1. Амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг экспортлогч иргэн, хуулийн этгээд нь хүсэлтээ хууль тогтоомжид заасан хугацаанд дор дурдсан мэдээлэл, баримт бичгийн хамт гаалийн байгууллагад ирүүлнэ: 2.1.1. амьтан, ургамал, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ; 2.1.2. худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг; 2.1.3. экспортлогч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар; 2.1.4. мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн лабораторийн шинжилгээний дүн; 2.1.5. амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл; 2.1.6. нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа; 2.1.7. амьтан, ургамал, бүтээгдэхүүний тоо, хэмжээ, боловсруулалтын байдал (хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, шинэ гэх мэт), савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл зэрэг дагалдах баримт бичиг. 2.2. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйл, 24.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нөхцөлд хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн экспортын гэрчилгээг гаалийн байгууллага олгоно.	2003

37	Засгийн газрын тогтоол	Багахангайн мах боловсруулах үйлдвэрийн санхүүгийн чадварыг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Улсын төсвөөс 1992-1995 онд олгосон зээлийн үлдэгдэл 101,1 сая төгрөгийг хүүгийн хамт Багахангайн мах боловсруулах үйлдвэрийн тайлан тэнцлээс чөлөөлөн төлбөрийг төвлөрсөн төсвийн шууд хөрөнгө оруулалтад тооцохыг Сангийн сайд П.Цагаанд зөвшөөрсүгэй.	1998
38	Засгийн газрын тогтоол	Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журам	2.1. Экспортын барааны гарал үүслийг тодорхойлох, гэрчилгээг Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээрт заасан нөхцөл, журмыг баримтлан гэрчилнэ хэмжээ тогтоосон акт зэргийг удирдлага болгон экспортлогчийн хүсэлтийг үндэслэн холбогдох аргачлалыг ашиглан дараах тохиолдолд олгоно. Үүнд: 2.1.1. Энэхүү журмын 1.2.1.-т Монгол Улсаас гарал үүсэлтэй бараанд; 2.1.2. Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу тухайн импортлогч орны гаалийн тарифын хөнгөлөлтөд хамрагдах бараанд; 2.1.3. Олон улсын гэрээ, хэлэлцээр буюу бусад баримт бичигт энэ тухай дурдсан байвал; 2.1.4. Үзэсгэлэн, яармагт явуулж байгаа бараанд; 2.1.5. Тендер, худалдан авалт болон олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдсан ЖДҮ-ийн бараа, бүтээгдэхүүн; 2.1.6. Гадаадын захиалагчийн материалаар үйлдвэрлэгдсэн Монгол Улсын гарал үүсэлтэй бүтээгдэхүүнд.	2024
39	Засгийн газрын тогтоол	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам	2.4. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 2.3-т заасан зөвлөмжийг үндэслэн тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг БТКУС-ийн кодод нийцүүлэн түүхий эд, бүтээгдэхүүн тус бүрээр тогтооно.	2019
40	Засгийн газрын тогтоол	Ойрын үеийн тулгамдсан зорилтыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	1.Мах, гурилын хангамжийн асуудалд онцгой анхаарч, тэдгээрийг бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулах, төлбөр хийх, тээвэрлэх болон хуваарилалтын бүх шатанд төрийн зүгээс тавих хяналтыг эрс сайжруулж, энэ өвөл мал, мах бэлтгэх ажлыг хэрэглэгч байгууллагуудын шууд оролцоотойгоор гардан зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга нарт; энэ ажилд хяналт тавьж шуурхай зохион байгуулж ажиллахыг уул ажлыг хариуцсан Засгийн газрын комисс,холбогдох яамдад тус тус даалгасугай.	1992
41	Засгийн газрын тогтоол	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	2/"Арван нэг.Малчдын хоршоонд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулах ажиллагаа 11.1.11.мах, сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрлэл.	2017

42	Засгийн газрын тогтоол	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт	1.1.1.Энэ техникийн зохицуулалтаар хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлох, импортлоход тавигдах шаардлагыг тогтооно; 1.1.2.Энэ техникийн зохицуулалтыг нийтийн хэрэгцээнд зориулан мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө; 1.1.3.Чөлөөт бүсэд мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалахад энэ техникийн зохицуулалтыг мөрдөнө; 1.1.4.Эрх бүхий этгээдээс шаардсан тохиолдолд бусад амьтны махыг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалахад энэ техникийн зохицуулалтыг дагаж мөрдөж болно; MNS CAC RCP 58 Махны эрүүл ахуйн дадлын дүрэм; MNS 2456 Мах, махан бүтээгдэхүүн. Үхрийн хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага; MNS 2457 Мах, махан бүтээгдэхүүн. Хонь, ямааны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага; MNS 0167 Гахайны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага; MNS 0703 Тахианы хэсэглэж ангилсан мах. Техникийн ерөнхий шаардлага; 1.3.6.“мах” гэж хүнсэнд хэрэглэхэд тохиромжтой малын бүх хэсгийг (цус орно); 1.3.7.“хөргөсөн мах” гэж зориулалтын хөргөх өрөөнд байршуулж, гүний температурыг (0-4) 0С хүртэл бууруулсан махыг; 1.3.8.“хөлдөөсөн мах” гэж зориулалтын хөлдөөх өрөөнд байршуулж, гүний температурыг -80С буюу түүнээс доош бууруулсан махыг; 1.3.11.“дотор мах” гэж хүнсний зориулалтын элэг, бөөр, зүрх, уушги, дэлүү, чацархай, өрц, гүзээ, гэдэс, ходоод, олгой, хос, сархинагийг; 1.3.12.“махан бүтээгдэхүүн” гэж чанах, жигнэх, утах, давслах, нөөшлөх, хатаах, амтлах, өтгөрүүлэх, эсхүл эдгээр боловсруулалтын аргыг хослуулах замаар түүхий махны мэдрэхүйн болон физик-химийн шинж чанарыг өөрчлөн, хагас ба бүрэн боловсруулсан бүтээгдэхүүнийг; 1.3.13.“хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн” гэж хэрэглэхийн өмнө дулааны боловсруулалт хийх шаардлагатай махан бүтээгдэхүүнийг; 1.3.14.“бүрэн боловсруулсан махан бүтээгдэхүүн” гэж боловсруулалт хийхгүйгээр шууд хэрэглэх махан бүтээгдэхүүнийг; 1.3.16.“махан бэлдмэл” гэж MNS CAC RCP 58 Махны эрүүл ахуйн дадлын дүрмийн 2.26-д заасныг; 2.3.4.мах, махан бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “MNS CAC MRL 2 Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын шаардлагыг хангасан байх. 3.4.11.мах, түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнийг ачих, буулгах зориулалтын талбай, саравчтай байх бөгөөд шалны түвшин нь тээврийн хэрэгслийн шалны өндрийн хэмжээнд тохирсон, эсхүл автоматаар тохируулагч тавцантай байх; .6.Мах боловсруулах үйлдвэрийн дотоод байгууламжид тавих шаардлага: 3.6.1.боловсруулах үйлдвэр нь түүхий эд хүлээн авах өрөө, хадгалах өрөө (хөргөгч), хөлдүү мах гэсгээх өрөө, сав, баглаа боодол, амтлагч, бусад туслах материал хадгалах өрөө, гулууз эвдэх, шулах, ангилах өрөө, шулсан мах	2022

			хөргөх, хадгалах өрөө, жор бэлтгэх өрөө, махан бэлдмэл бэлтгэх өрөө, (мах хэрчих, ангилах, машиндах, холих, найруулах, савлах), махан бэлдмэл түр хадгалах өрөө (хөргөгч), дулааны боловсруулалт хийх өрөө, бэлэн бүтээгдэхүүн хөргөх, хадгалах өрөө (хөргөгч), бүтээгдэхүүн савлах, шошголох өрөө, дотоод хяналтын лаборатори, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн болон химийн бодис хадгалах өрөө, эсхүл шүүгээ, ажиллагсдын хоолны газар, ажиллагсдын хувцас солих өрөө, хувцас хэрэгсэл угаах өрөө, ариун цэврийн өрөө тасалгаатай байх; 3.6.Мах боловсруулах үйлдвэрийн дотоод байгууламжид тавих шаардлага: 3.6.1.боловсруулах үйлдвэр нь түүхий эд хүлээн авах өрөө, хадгалах өрөө (хөргөгч), хөлдүү мах гэсгээх өрөө, сав, баглаа боодол, амтлагч, бусад туслах материал хадгалах өрөө, гулууз эвдэх, шулах, ангилах өрөө, шулсан мах хөргөх, хадгалах өрөө, жор бэлтгэх өрөө, махан бэлдмэл бэлтгэх өрөө, (мах хэрчих, ангилах, машиндах, холих, найруулах, савлах), махан бэлдмэл түр хадгалах өрөө (хөргөгч), дулааны боловсруулалт хийх өрөө, бэлэн бүтээгдэхүүн хөргөх, хадгалах өрөө (хөргөгч), бүтээгдэхүүн савлах, шошголох өрөө, дотоод хяналтын лаборатори, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн болон химийн бодис хадгалах өрөө, эсхүл шүүгээ, ажиллагсдын хоолны газар, ажиллагсдын хувцас солих өрөө, хувцас хэрэгсэл угаах өрөө, ариун цэврийн өрөө тасалгаатай байх; 3.6.3.түүхий мах хүлээн авах, эвдэх, шулах, ангилах, савлах, бүтээгдэхүүний бэлдэц үйлдвэрлэх, бэлэн бүтээгдэхүүн савлах, шошголох болон бусад технологийн өрөө, орчин 120С температураас ихгүй байх; 3.6.4.энэ техникийн зохицуулалтын 4.10.2, 4.10.3-т заасны дагуу мах, махан бүтээгдэхүүнийг хөргөх, хөлдөөх агуулахтай байх; 3.8.9.мах ангилж савлах, боловсруулах, хөргөх, хөлдөөх, гэсгээх өрөө, хөргөлттэй агуулах нь температур, харьцангуй чийглэгийг хянах зориулалтын багаж, төхөөрөмжөөр тоноглогдсон байх; 3.8.10.махан бүтээгдэхүүнд дулааны боловсруулалт хийх төхөөрөмж нь бүтээгдэхүүний гүний температур, чийг хэмжих хэрэгслээр тоноглогдсон байх; 4.2.3.үйлдвэрлэгч нь мал төхөөрөх технологийн зааврыг төрөл тус бүрд батлан мөрдөх ба технологийн зааварт дараахь үйл ажиллагааг тусгана: 4.2.3.6.гэдэс дотор, дотор мах, дайвар бүтээгдэхүүн гаргах, мал төхөөрсний дараах үзлэгт бэлтгэх; 4.2.3.8.махыг хөргөх, хөлдөөх. 4.11.Мах боловсруулах үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавих шаардлага: 4.11.1.мах хэсэглэх, шулах, ангилах, савлах өрөөний хэм 120С температураас ихгүй байх. Импортлогч орны эрх бүхий байгууллагатай байгуулсан мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хэлэлцээрт заасныг харгалзан өөр байж болно; 4.11.2.мах шулах, ангилах, түүгээр хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд энэ техникийн зохицуулалтын 4.10.2, 4.10.3, 4.10.6-д заасны дагуу хөргөж хөлдөөсөн мах, дотор мах хүлээж авах; 4.11.4.нэг өрөөнд өөр өөр төрлийн малын мах ангилж савлах, өөр нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиолдолд тэдгээрийг өөр хооронд нь цаг хугацааны хувьд эсхүл орон зайн хувьд давхцуулахгүй зааглах боломж	

			бүрдүүлсэн байх; 4.13.Нөөшилсөн махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавих шаардлага: 4.13.1.нөөшилсөн махан бүтээгдэхүүний сав, баглаа боодлын битүүмжлэлийг тогтмол шалгаж бүртгэл хөтлөх; 4.13.2.нөөшлөх зориулалттай махан бэлдмэлийг бэлтгэснээс хойш 1 цагийн дотор пастерийн, 2 цагийн дотор ариутгах боловсруулалтад оруулах; 4.15.4.гулууз мах, мал, амьтны ангилж савласан махны шошгод “MNS 2456 Мах, махан бүтээгдэхүүн. Үхрийн хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага”, “MNS 2457 Мах, махан бүтээгдэхүүн. Хонь, ямааны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага”, “MNS 0167 Гахайны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага”, “MNS 0703 Тахианы хэсэглэж ангилсан мах. Техникийн ерөнхий шаардлага”-д тус тус заасан кодыг хэрэглэх; 4.15.5.мах, махан бүтээгдэхүүн хадгалах үе шатанд өрөөний ариун цэвэр, температур, агаарын харьцангуй чийглэгийг тогтмол хэмжиж, бүртгэл хөтлөх. 4.16.Түгээх, тээвэрлэх үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавих шаардлага: 4.16.1.мах, махан бүтээгдэхүүнийг түгээх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадлыг баримтлах; 4.16.2.мах, махан бүтээгдэхүүнийг зориулалтын, хөргөлттэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх ба чингэлгийн доторх бүх гадаргууг зэвэрдэггүй, гөлгөр, бат бөх, цэвэрлэж халдваргүйтгэхэд хялбар материалаар хийх, хаалга нь жижиг хортон мэрэгч болон бохирдуулагч бусад зүйл орохооргүй, битүүмжлэгддэг байх; 4.16.3.мах, махан бүтээгдэхүүнийг тээвэрлэх зориулалтын сав, эргэлтийн хайрцгийг ачилт хийх бүрийн өмнө цэвэрлэж, шаардлагатай тохиолдолд халдваргүйтгэж, тухай бүр бүртгэл хөтлөх; 4.16.5.хөргөсөн гулууз махыг (0-4)0С температурт өлгөсөн байдлаар, савласан мах, хагас болон бүрэн боловсруулсан махан бүтээгдэхүүнийг (0-4)0С температурт зориулалтын эргэлтийн сагсанд хийж өрсөн байдлаар, хөлдөөсөн гулууз махыг -180С температурт өрсөн байдлаар зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх; 4.16.6.түүхий болон бүрэн боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг тусад нь тээвэрлэх; 4.16.7.хөргөсөн, хөлдөөсөн махан бүтээгдэхүүнийг ачих, тээвэрлэх үед хүйтэн хэлхээний зарчмыг баримтлах; 4.16.9.мах, махан бүтээгдэхүүнийг ачих, буулгах хэсэг нь орчны нөлөөллөөс хамаарч мах бохирдохгүй байх нөхцөлийг хангах; 4.16.10.мах, махан бүтээгдэхүүнийг буулгасны дараа чингэлгийг цэвэрлэж халдваргүйтгэх; 4.16.11.мах, махан бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ “MNS 5343 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага”-ыг баримтлах. 4.17.Мал төхөөрөх үйлдвэрийн мал эмнэлэг, хорио цээр, ариун цэврийн хяналтын үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавих шаардлага: 4.17.1.үйлдвэр нь малд үзлэг хийх, мал болон түүхий эд, бүтээгдэхүүнээс түүврийн аргаар дээж авах, шинжлэх, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх эрх бүхий мал эмнэлгийн алба, эсхүл малын эмчтэй байх;	

43	Засгийн газрын тогтоол	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам	1.1. Мал, амьтны өвчний оношилгоо, тандалт, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ хийх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн мал эмнэлгийн лаборатори /цаашид “сүлжээ лаборатори” гэх/-ийн хоорондын харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго нь оршино. 3.2. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн хүрээнд Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн баталгаажуулсан оношлуур, эм урвалж, цомог, шинжилгээний стандарт, стандарт ажиллагааны зааврууды ашиглан шинжилгээ, сорил, баталгаажуулалт хийнэ. 6.1.7. Харьяа нутаг дэвсгэрт мал, амьтны халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчний онош тогтоох, экспорт, импортын зориулалттай болон дотоодын мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнд баталгаажуулалтын шинжилгээ хийх; 7.1.10. Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч болон сум дүүрэг, аж ахуйн нэгжийн лабораторийн шинжээч нь Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнээс сорьц авч шинжлэх; 9.4. Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний шинжилгээний төлбөрийг хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж хариуцна.	2020
44	Засгийн газрын сайдын тогтоол	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам	5.1.4. Экспорт, импортын зориулалттай мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, эмийн үлдэгдлийн шинжилгээ хийх; 5.1.6. Оношилгоо, тандалт, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, эмийн үлдэгдлийн шинжилгээ, сорил, баталгаажуулалтын хагас жилийн тайланг жил бүрийн 07 дугаар сарын эхний 7 хоногт, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сард багтаан Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар болон албан бичгээр хүргүүлэх. 5.1.9. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын лабораторийн үйл ажиллагаанд батлагдсан стандарт, арга аргачлалын дагуу хоёр жил тутамд үнэлгээ хийж, энэхүү журмын 6.1.10-д заасан тайлантай нэгтгэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах, шийдвэрлүүлэх; 6.1.7. Харьяа нутаг дэвсгэрт мал, амьтны халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчний онош тогтоох, экспорт, импортын зориулалттай болон дотоодын мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнд баталгаажуулалтын шинжилгээ хийх; 7.1.10. Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч болон сум дүүрэг, аж ахуйн нэгжийн лабораторийн шинжээч нь Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу мал,	2020

			амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнээс сорьц авч шинжлэх;	
45	Сайдын тушаал	Гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай	1. Хилийн чанадад гаргах түүхий болон дулааны аргаар эсхүл, бүрэн боловсруулсан махны гаалийн бүрдүүлэлтийг гүний гаалийн байгууллагад хийж, гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгчээр тээвэрлүүлэн хилийн гаалийн байгууллагын хяналтад илгээж байхаар тогтоосугай.	2020
46	Гаалийн ерөнхий газрын дарга	Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам	1.4.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах зорилгоор болон хорио цээрийн хяналтад хамрагдах барааг импортлох, экспортлохоос өмнө иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн албан хүсэлтийн дагуу дээж, сорьц, загварт магадлан шинжилгээ хийж болно. Хүсэлтийг цахимаар ирүүлж болно. 2.7. Гаалийн улсын байцаагч нь лабораторийн дүгнэлтийн CAIS программын “Маягт бичих” талбарт мэдүүлсэн бараатай холбоотой мэдээллийг гадаад худалдааны бичиг баримттай уялдуулан, импортын гаалийн мэдүүлгээс татаж оруулах бөгөөд экспортын барааны хувьд “Цахим төлбөрийн баримтын систем”-д бүртгэгдсэн экспортын гэрээний дугаарыг МШХШ-т оруулан, энэ журмын 2.5-д заасан хугацаанд хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчаар хянуулан, гаалийн лабораторид илгээнэ. 3.6.Барааг экспортлох зорилгоор гаалийн байгууллагад мэдүүлэхээс өмнө аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн сорьц, дээж, загварыг авч магадлан шинжилгээнд хамруулж болно. 3.11.Гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдөж буй импортын ба тарифын ялгаатай бараа, экспортын татвартай ба тарифын бус хязгаарлалттай барааг магадлан шинжилгээнд заавал хамруулж, барааны ангиллын кодыг тодорхойлуулсан байна.	

47		Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар	4.1.Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлогч иргэн, хуулийн этгээд нь хүсэлтээ хууль тогтоомжид заасан хугацаанд дор дурдсан мэдээлэл, баримт бичгийн хамт мал эмнэлгийн байгууллагад ирүүлнэ. Үүнд: 4.1.1.Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт, мал эмнэлгийн гэрчилгээ; 4.1.2.Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг; 4.1.3.Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар; 4.1.4.Хүсэлт гаргагч нь мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа; 4.1.5.Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, хэмжээ, боловсруулалтын байдал (хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, хөргөсөн, шинэ гэх мэт), савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл; 4.1.6.Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил; 4.2.Мал эмнэлгийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн мэдээлэл, хүсэлт, Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл, экспортлогч орны халдварт өвчний мэдээллүүдийг үндэслэн импортлох мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг олгох эсэхийг шийдвэрлэнэ. 4.3.Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээд нь дор дурдсан мэдээлэл, баримт бичгийн хамт мал эмнэлгийн байгууллагад ирүүлнэ. Үүнд: 4.3.2.Тухайн экспортлогч орны мал эмнэлгийн эрх бүхий байгууллагаас мал, амьтны эрүүл мэнд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан эсэхийг баталгаажуулсан баримт, бичиг /олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, түүнтэй адилтгах/, шаардлагатай тохиолдолд мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт; 4.5.Хоёр улсын гэрээ хэлэлцээрт тусгайлан заагаагүй бол мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний экспортын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг англи, монгол хэл дээр, импортын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг монгол хэл дээр тус тус бичнэ. 4.8.Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш амьд мал, амьтанд 1 сар хүртэл, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд 5 дугаар сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 31-нийг хүртэлх хугацаанд 21 хоног, 10 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 4 дүгээр сарын 30-ныг хүртэлх хугацаанд 30 хоног хүчинтэй байна. Гэрчилгээний хүчинтэй хугацаанд экспортолж буй улс орон, бүс нутагт мал, амьтны худалдааны хорио цээрт өвчин гарсан, хүн, малын эрүүл мэндэд эрсдэл үүсэх нөхцөл үүссэн үед гэрчилгээг олгосон байгууллага хүчингүй болгож болно.	2021

48	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын захирлын тушаал	Монгол Улсас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүслийг тодорхойлох аргачлал, гарал үүслийн гэрчилгээнд тавигдах шаардлага	1.1. МҮХАҮТ нь Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ олгох журмын дагуу гэрчилгээ олгохдоо барааны гарал үүслийг тодорхойлох зорилгоор журамд заасан үндэслэл, холбогдох нотлох баримт болон доорх аргачлалыг ашиглан тодорхойлно. 1.4. МҮХАҮТ нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцтай газар дээр нь танилцан гарал үүслийг тодорхойлох ажиллагааг явуулж болно. 2.8. Монгол Улсын экспортын барааны гарал үүслийн гэрчилгээнд МҮХАҮТ-ын гүйцэтгэх захирал, түүний эзгүйд дэд захирал гарын үсэг зурж Танхимын тусгай тэмдгээр баталгаажуулна.	
49	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын захирлын тушаал	Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журам	1. "Монгол Улсаас гарал үүсэлтэй бараа" гэж Монгол Улсын бүрэн гарал үүсэлтэй бараа болон Монгол Улсад үйлдвэрлэлийн явцад үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн барааг ойлгоно. Үүнд: г/ Монгол Улсын нутаг дэвсгэрт төрж бойжсон амьд мал, амьтан, загас болон тэдгээрээс гаралтай бараа бүтээгдэхүүн. 1.1.5. "Гарал үүслийн гэрчилгээ" гэж МҮХАҮТ-аас экспортын барааны гарал үүслийг уг журмын дагуу тодорхойлон олгож байгаа нууцлал, үнэт цаас бүхий баримт бичгийг. 3.2. МҮХАҮТ нь дээрх бичиг баримтын үндсэн дээр шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх, дараа үзлэг хийж зөрчилгүй гэж үзсэн тохиолдолд энэхүү журамд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх ерөнхий зохицуулалтын дагуу гарал үүслийн гэрчилгээ олгоно.	
50	Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын XIII хуралдааны тогтоол тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай	1.11.Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 толгой мал бол 1000 төгрөг, 10-аас дээш тооны толгой мал бол 1000 төгрөг дээр 10-аас дээш тооны малын толгой тутамд 50 төгрөг нэмж.	